



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛЫН
ЯАМ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ
БАГА БҮЛЭГ



УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАГШИЙН ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ	2
1.1 Багшийн гарын авлагын зорилго, бүтэц	2
1.2. Сургалтын хөтөлбөр, гарын авлагатай танилцъя	2
1.3. Сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх	5
ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХӨТӨЛБӨРИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙ	8
2.1. Бага насны хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох тухай	8
2.2. Сургалтын хөтөлбөрийн арга зүйтэй уялдах онол	10
2.3. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй	12
ГУРАВДУГААР БҮЛЭГ: СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ	21
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- IX САР	21
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - X САР	26
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - XI САР	35
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - XII САР	44
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - I САР	55
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - II САР	65
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - III САР	74
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - IV САР	86
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - V САР	96

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАГШИЙН ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ

1.1 Багшийн гарын авлагын зорилго, бүтэц

Энэхүү гарын авлага нь сургуулийн өмнөх боловсролын түвшний сургалтын хөтөлбөр болон долоон чиглэлийн сургалтын хөтөлбөрийг ойлгох, ухагдахуунуудыг тайлж уншихад дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд багш нарт онолын мэдлэг, арга зүйн чиглэл, практик жишээ, зөвлөмжөөр дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжилд чиглэсэн чанартай сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх чадварын хөгжлийг дэмжих зорилготой.

Та бүхэн гарын авлагатай танилцахын зэрэгцээ сургуулийн өмнөх боловсролын түвшний сургалтын хөтөлбөрөөс философи, онол, арга зүйн үндэс, суурь зарчим, бүтцийг сайтар судлаарай. Мөн долоон чиглэлийн сургалтын хөтөлбөрөөс бүтэц, чадвар, суралцахуйн үр дүн, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээний хэсгүүдийг уялдуулан харах хэрэгтэй.

Багшийн гарын авлагын Нэгдүгээр бүлгээс суралцахуйн үр дүн болон бусад гол ухагдахуунуудын талаар цэгцтэй, дэлгэрэнгүй ойлголт авахын зэрэгцээ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хэрхэн жил, сар, долоо хоногоор төлөвлөхийг харах боломжтой.

Хоёрдугаар бүлгээс сургалтын хөтөлбөрийн суралцахуйн онолын үндэс, хэрэгжүүлэх арга зүй нь сургалт, үйл ажиллагааны төлөвлөлттэй хэрхэн уялдаж байгаатай танилцана уу.

Гуравдугаар бүлгээс жил, сар, долоо хоногийн төлөвлөлтөд хэд хэдэн чиглэлийн суралцахуйн үр дүнг хэрхэн нэгдмэл байдлаар авч хэрэгжүүлж болох жишээтэй танилцаарай. Жишиг сарын төлөвлөлтөөс хичээлийн жилийн турш суралцахуйн үр дүнгүүдийг (НСХ 3.1а, МАТ3.2а гэх мэт) нэгтгэж харах, төлөвлөх, хянах боломжтой. Энэ бүлэг дэх нэгдмэл үйл ажиллагаанууд нь та бүлгийнхээ хүүхдүүдийг тодорхой суралцахуйн үр дүнд хүргэхийн тулд санаа авч хэрэгжүүлж болохуйц арга, ажиллагааны жишиг гэдгийг сайтар санаарай. Эдгээр жишиг үйл ажиллагааг сайжруулах, өөрчлөх, санаа авч өөрсдийнхөөр шинээр төлөвлөх боломжтой юм.

Мөн энэхүү гарын авлагаар хүүхдийн суралцахуйг анги танхимаас гадна эцэг эхтэй хамтран гэр бүлд нь хэрхэн үргэлжлүүлж болох талаар жишиг санааг тусгаж өгсөн.

Багш нар гарын авлагаа ашиглан хамтран төлөвлөх, харилцан хичээлд суух, эргэцүүлэх, туршлагаа хуваалцах замаар мэргэжлийн тасралтгүй хөгжлөө дэмжих боломжтой бөгөөд энэхүү гарын авлага нь шинэ, залуу багш нарыг сургах, чиглүүлэхэд тохиромжтойгоор боловсруулагдсан.

1.2. Сургалтын хөтөлбөр, гарын авлагатай танилцъя

Чадамжид суурилсан хөтөлбөр

Чадамж гэдэг нь 1. Мэдлэг (юуг мэдэх), 2. Чадвар (яаж хийх), 3. Хандлага (ямар үнэт зүйл, зан төлөвтэй байх) гурвын нэгдлийг хэлнэ. Хөтөлбөр чадамжид суурилна гэдэг нь хүүхэд ямар нэгэн мэдээллийг цээжлээд өнгөрөх төдий бус харин амьдралд хэрэглэх мэдлэг, чадвар, хандлага, зан үйл, сэтгэлгээний арга барил эзэмшихэд чиглэнэ гэсэн үг юм.

Сургалтын хөтөлбөр нь хүүхдийг оюун санааны дархлаатай, аз жаргалтай насан туршдаа суралцах чадамжтай болгохыг гол зорилгоо болгосон. Хөтөлбөрийн агуулга, арга зүй нь хүүхэд бүрийн оролцоонд суурилсан үйл ажиллагаагаар дамжуулан ирээдүйд суралцах суурь чадвар бүхий бие хүн болгож төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

Хөтөлбөр, гарын авлагын уялдаа

Багш нь сургалтын хөтөлбөр, багшийн гарын авлагыг хамтад нь хослуулан хэрэглэнэ. Ингэхдээ сургалтын хөтөлбөрөөс хүүхдүүдийн ямар чадамжийг хөгжүүлж ямар суралцахуйн үр дүнд хүргэхээр зорьж байгаагаа харна. Харин багшийн гарын авлага дээрх санал болгосон жишгүүдээс арга зүйн санаа авна.

Сургалтын хөтөлбөрөөс харах зүйлс	Багшийн гарын авлага дээр хэрхэн буусан бэ?
Хөтөлбөрийн үзэл баримтлалд тулгуурлан эзэмшүүлэх чадамж, суралцахуйн зорилт, хөгжлийн ай, дэд ай, суралцахуйн үр дүнг тодорхойлсон.	Хөтөлбөр дахь суралцахуйн зорилтод чиглэсэн нас, хөгжлийн онцлогт тохирсон жишиг арга зүй, өдөр тутмын үйл ажиллагаа санал болгосон.
Суралцахуйн үр дүн бүрээр 2-5 настай хүүхдэд хөгжлийн 4 түвшнийг тодорхойлсон.	Түвшин бүрд жишиг үйл ажиллагаа санал болгохын зэрэгцээ СҮД-үүдийн залгамж холбоог хангах арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
Сургалтын долоон чиглэлийн хүрээнд нэгдмэл арга зүй баримтлахаар боловсруулсан.	Сургалтын чиглэл дэх айнуудыг сэдэвт үйл ажиллагаагаар нэгтгэж болох жишээ санал болгосон.

Сургалтын хөтөлбөр, гарын авлагын бүтэц

Нэн түрүүнд сургалтын долоон чиглэл, эдгээрт тодорхойлсон хөгжлийн дөрвөн түвшин, суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгууруудыг нарийн танилцаж ойлгох нь чухал юм.

Сургалтын чиглэл. Сургалтын хөтөлбөрийг хүүхдийн хөгжлийн чиглэлд үндэслэн дараах 7 чиглэлээр боловсруулсан. Үүнд: 1) Нийгэм-сэтгэл хөдлөл; 2) Хөдөлгөөн, эрүүл мэнд; 3) Хэл яриа; 4) Байгаль, нийгмийн орчин; 5) Математик; 6) Зураг, урлал; 7) Хөгжим; зэрэг юм.

Хөтөлбөрийн сургалтын чиглэл бүр нь чадвар, тухайн чадварын ай, дэд айгаас бүтнэ. Дэд ай бүр 1-4 түвшинд тодорхойлогдсон суралцахуйн үр дүнтэй. Жишээ нь: Нийгэм-сэтгэл хөдлөлийн сургалтын чиглэл *"Хүүхэд сэтгэл хөдлөл, мэдрэмж, харилцаа, хүмүүнлэг байдлын талаар ойлголт мэдлэгтэй бусадтай зөргөөр харилцах, хамтрах, зан үйлээ хариуцлагатайгаар удирдан зохицуулах чадвартай, өөрт болон бусдад төдийгүй нийгэмдээ энэрэнгүй, эрх тэгш, хүндэтгэлтэй хандлагатай болж төлөвших"* чадварыг эзэмшүүлэхийг зорих бөгөөд үүний тулд 1. Өөрийгөө таних; 2. Бусадтай харилцах; 3. Харилцан хамаарал гэсэн гурван айтай, ай тус бүр гурван дэд айн хүрээнд нийт 36 суралцахуйн үр дүнг тодорхойлсон байна.

Суралцахуйн үр дүн (СҮД). Сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулгыг хэрэгжүүлснээр хүүхдийн хөгжлийн хувьд хүрэх үр дүнг "Суралцахуйн үр дүн" гэж нэрлэсэн. Тиймээс "Суралцахуйн үр дүн" нь мөн сургалтын хөтөлбөрийг амжилттай эзэмшсэн суралцагчийн мэдэх, ойлгох, хэрэглэх шаардлагатай хүрэх түвшингийн илэрхийлэл болно.

Суралцахуйн үр дүнгийн хүрэх түвшин. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хүүхдэд эзэмшүүлэх чадварыг дөрвөн түвшинтэй боловсруулсан. Энэхүү хөтөлбөрөөр

эзэмшүүлэх чадварын түвшин нь сургуулийн өмнөх боловсролын зохион байгуулалтын түвшингээс тусдаа ойлголт болно. Өөрөөр хэлбэл, хүүхэд бүрийн хөгжлийн хурд, явц ялгаатай учраас эзэмших чадварын 4 түвшин нь бага, дунд, ахлах, бэлтгэл бүлэгт дүйцэх албагүй юм.

Суралцахуйн үр дүн ба чадамж. Суралцахуйн үр дүнгүүд нь хүүхдийн ерөнхий болон суурь чадамж (мэдлэг, чадвар, хандлага)-д чиглэнэ. Ингэхдээ хүүхдийн өмнөх мэдлэг, төсөөлөл, амьдралын туршлагад тулгуурлан аливаа зүйлийг сонирхон судалж, эргэцүүлэн таамаглаж тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх чадамж хандлагыг хөгжүүлэх юм.

Нэгдмэл арга зүй. Суралцахуйн үр дүнд хүрэхийн тулд багш нэгдмэл арга зүйг хэрэглэнэ. Нэгдмэл арга зүй нь сургалтын хэд хэдэн чиглэлийг хамарсан, олон талт, нарийн нийлмэл, оролцоонд тулгуурласан хэлбэртэй байна. Нэгдмэл арга зүйд ямар сургалтын загвар, хэлбэрийг авч ашиглах нь багшийн өөрийн шийдэл боловч энэхүү гарын авлагын хүрээнд дараах дөрвөн арга зүйг жишээ болгон авч үзсэн. Үүнд: Тоглоомд суурилсан; Зохиолд суурилсан; Сонирхон судлахад суурилсан; Төсөлд суурилсан зэрэг болно. Эдгээр арга зүйгээр өдөр тутмын сургалт, үйл ажиллагааг төлөвлөж, өдрийн хуваарьт (хүлээн авалт, тойргийн цаг, чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа, төвийн үйл ажиллагаа, зугаалгын цаг, хөгжөөн баясах үйл ажиллагаа, номын цаг ... гэх мэт) цагуудад зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээг цогцоор нь багтаасан.

Багш та төлөвлөлтөө хийхдээ өдрийн хуваарьт үйл ажиллагааг бүтцийн дагуу зохион байгуулахад анхаараарай. Өдрийн хуваарьт үйл ажиллагааны онцлогийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 1. Өдрийн хуваарьт үйл ажиллагааны онцлог

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны онцлог
Тойргийн цаг	Өдрийг амжилттай эхлэхийн нэг үндэс нь өглөөний тойргийн цагт хийгдэж буй ажлын төлөвлөлт байдаг. Тухайн өдрийн судлах зүйлийн талаар суурь ойлголт авах боломж олгодог. Тойргийн цаг нь: - Мэндчилгээ - Ярилцлагаас бүрдэнэ.
Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Багшийн заавар, тодорхой зорилго, аргачлалтайгаар танин мэдэхүй, хэл яриа, бие бялдар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлдэг. - Тоолох, ангилах, ялгах - Туршилт хийх - Сонсох, ярих, санаа бодлоо үйл явдлын дагуу үргэлжлүүлэн зохиох, - Зураг, наамал, барих, зохион бүтээх
Төвийн үйл ажиллагаа	Бие даасан байдал, асуудал шийдвэрлэх, бүтээлч оролцоог дэмждэг. Багш чиглүүлэхээс илүү ажиглагч, дэмжигчийн үүрэгтэй. Хэдэн төвтэй, ямар тоглоомтой байхыг багш төлөвлөж тоглоомын аргачлал, тоглох заавар зэргийг зургаар илэрхийлж хайрцаг, саванд байрлуулж, хүүхэд аль төвд ажиллах сонголт хийнэ. Төв нь: Хүүхдийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн, сонголт хийх боломжтой байна. - Туршилт танин мэдэхүйн төв - Математикийн төв - Хэл яриа-номын төв - Тоглоомын төв

Зугаалга	Хүүхдийг байгальтай танилцуулах, орчноо ажиглах, туршин судлах, хөдөлгөөнийг дэмждэг өдөр тутмын үйл ажиллагааны хэлбэр юм. Зугаалга нь: - Ажиглалт - Хөдөлмөр - Тоглоом
Номын цаг	Хүүхдийн хэл яриа, уран дүрслэл, сонсох чадвар, анхаарал төвлөрөл, төсөөллийг хөгжүүлэх үлгэр, номын зохиол уншиж, ярилцана. Чиглүүлэх асуултаар баяжуулна. - Үлгэр унших - Зурагт ном тайлбарлах - Дүрд тоглох - Үлгэрийг үргэлжлүүлэх
Өөртөө үйлчлэх цаг	Хүүхдийг өдөр тутмын хувийн хэрэгцээг хангахад чиглэсэн. Эх сурвалж: Бямбадорж.П, Гандолгор.Ш., (1994). "Бага насны хүүхдийн хөдөлмөр, зурагт сургах арга зүй") - Гар, нүүр угаах - Хувцас өмсөх/эвхэх - Ор хураах, засах гэх мэт
Хөгжөөн баясах цаг	Хүүхдийг хөгжөөн баясахад, чиглэсэн өдөр тутмын үйл ажиллагаа, үлгэр зохиолын дүрд хувирах, хөгжилтэй хөдөлгөөн, хөнгөн дасгал, хөгжимт тоглоомоор сэргээнэ. Хөгжөөн баясах цаг: - Үлгэр зохиол танилцуулах, дүрд хувирах - Хөгжмийн хэмнэлээр бүжиглэх - Хөгжөөнт тоглоом - Хөгжилтэй дасгал

1.3. Сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх

1. Үйл ажиллагааны сэдэв сонгох

Гарын авлагад "Сэдэв" гэх ойлголтыг нэг сарын хугацаанд хэд хэдэн суралцахуйн үр дүнг нэгтгэх, арга зүйг нэгдмэл байдлаар хооронд нь уялдуулах зорилгоор оруулж ирсэн. Багш нар хүүхдүүдээ хөгжүүлэхээр зорьж буй суралцахуйн үр дүн, орон нутгийн онцлог, хүүхэд, эцэг эхийн хүсэл сонирхол, өөрийн боломж, давуу тал зэрэг хүчин зүйлсийг харгалзаж төлөвлөлтийн сэдвийг тодорхойлно. Сэдэв нь дотроо хэд хэдэн дэд үйл ажиллагааг агуулах бөгөөд нэгдмэл арга зүйгээр хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, багш үйл ажиллагааг суралцахуйн чиглэл тус бүрээр салангид явуулах бус харин хүүхдүүдийн хувьд утга учиртай, нэгдмэл байдлаар төлөвлөх, зохион байгуулахад "сэдэв" чиглэгдэх юм.

2. Сэдэв, үйл ажиллагааны хүрээнд эзэмших СҮД-гүүдийг нарийвчлан уялдаа холбоог сайжруулах

Сэдвийн хүрээнд төлөвлөхдөө сургалт, үйл ажиллагааны СҮД-гүүдийн уялдаа холбоог шалгахын зэрэгцээ нийт жилийн сургалт, үйл ажиллагаанд нэг СҮД хэт олон давтагдах эсвэл орхигдож байгаа эсэхийг лавлаарай. Мөн нөгөө талаас бүх үйл ажиллагаанууд тухайн СҮД-д чиглэж байгаа эсэх, зорилтот СҮД-гүүд хангагдаж байгаа эсэхийг байнга нягталж байх хэрэгтэй. Тухайлбал, дараах үйл ажиллагаанд Нийгэм-сэтгэл хөдлөлийн есөн СҮД-гээс нэгийг нь эзэмшүүлэхээр төлөвлөсөн байна.

Бага бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
---------------	--	---------------------------

Ангитайга танилцъя	<p>НСХ1.1а. Биеийн зарим мэдрэмжээ нүүр, гар, биеийн хөдөлгөөн, дуу авиа, үгээр илэрхийлдэг болно.</p> <p>БНО1.1в. Ойр орчны эд зүйлс, тоглоомыг мэдэрч нэрлэнэ.</p> <p>МАТ1.1а. Гэр, цэцэрлэгийн орчин тойронд байх юмсаас 1 эсвэл 3 ширхэг тоглоом, юмсыг заах, нэг гэж хэлнэ.</p>	<p>Өөрт таатай, таагүй байгааг биеийн хэлэмж, үгээр хэлэх, заах</p> <p>Орчныхоо тоглоом, эд зүйлсийг сонирхон ажиглах, тоглох, нэрлэх</p> <p>Ангийн тоглоомоос нэг тоглоом сонгон тоглох</p>
--------------------	--	--

Дунд бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Олоорой	<p>НСХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно.</p> <p>МАТ2.1б. Дараалан байрлуулсан тоглоом, юмсын зүй тогтлыг ажиглаж, дуурайна.</p>	<p>Таних тэмдэгтэй өрж байгуулах тоглоомоор тоглох</p> <p>Өөрийн таних тэмдгийг таних, бусдынхтай харьцуулах</p> <p>Ойр орчмын дуу чимээ танил үг, өгүүлбэрийг анхааралтай сонсох, дуурайх.</p>

Ахлах бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Миний зуны амралт	<p>ХЯ2.2а. Энгийн өгүүлбэрээр харилцан ярилцана.</p> <p>ЗУ2.2а. Зураас, дүрсээр өөрийн бодол төсөөллөө илэрхийлнэ.</p> <p>НСХ2.3в. Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцоно.</p>	<p>Өдөр тутмын үйл ажиллагааны явцад сэдвийн хүрээнд өөрийгөө илэрхийлэн, бусадтай харилцахдаа асуулт харилцан яриаг эхлүүлэх</p> <p>Дугуй дүрс, цэг зураасаар дүрсэлж зурах</p> <p>Өдрийн дэглэмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох</p>

Дээрх жишээнд ахлах бүлгийн эхний сарын зарим үйл ажиллагаануудыг хоёрдугаар түвшний СҮД-гийн хүрээнд төлөвлөсөн байна. Энэ нь хүүхэд бүлэг шилжих үед СҮД-гийн түвшнийг уусгах, шилжилтийг хүүхдэд хялбарчлах зорилготой. Мөн эндээс та бүхэн СҮД-гийн түвшин сургалтын зохион байгуулалтын түвшин буюу бүлэгтэй заавал тохирох албагүй байгааг харж болно.

Бэлтгэл бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Би-миний найзууд	<p>БНО4.2а. Өөрийнхөө тухай танилцуулж, бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандана.</p> <p>НСХ4.3в Өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой дүрэм баримтлан хамтран оролцдог болно.</p>	<p>Өөрийгөө болон гэр бүлийнхээ тухай танилцуулах</p> <p>Ангийн дүрмээ хэлэлцэхэд өөрийн саналаа хэлэх, хамтдаа зохиох</p>

3. Сар, долоо хоногийн төлөвлөгөө зохиох

Гарын авлагад хичээлийн жилийн эхнээс буюу 9-өөс 5 дугаар сарын нийт есөн сарын жишиг төлөвлөлтийн загвар оруулсан. Ингэхдээ сар бүрийн эхний хоёр долоо хоногийн үйл ажиллагааны төлөвлөлтийг жишиг болгосон. Эндээс багш нар санаа авч тухайн сарын 2 долоо хоногийг үргэлжлүүлэн төлөвлөх зориулалттай юм. Сар бүр нэгдсэн сэдэвтэй бөгөөд цааш долоо хоногийн дэд сэдэв, үйл ажиллагаагаар төлөвлөгдсөн.

Жишээ нь: Бага бүлгийн 9 дүгээр сар *"Шинэ орчин"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудаар төлөвлөгдсөн бөгөөд, тухайлбал нэг, хоёрдугаар долоо хоногууд *"Ангитайгаа танилцъя"*, *"Миний хөөрхөн гар, нүүр"*, *"Дуулцгаая"* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Жишээ нь: Дунд бүлгийн 9 дүгээр сар *"Хамтдаа тоглоё"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудаар төлөвлөгдсөн бөгөөд, тухайлбал, нэгдүгээр долоо хоног *"Зогсоорой"*, *"Олоорой"*, *"Алгаа ташаарай"*, *"Олсоор наадъя"*, *"Гараа угаацгаая"* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Жишээ нь: Ахлах бүлгийн 9 дүгээр сар *"Миний танил орчин"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудаар төлөвлөгдсөн бөгөөд, тухайлбал, нэгдүгээр долоо хоног *"Миний зуны амралт"*, *"Миний нэг өдөр"*, *"Авхаалжтай хүүхэд"* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Жишээ нь: **Бэлтгэл** бүлгийн 9 дүгээр сар *"Хөгжилтэй найзууд"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудад задрах бөгөөд тухайлбал нэгдүгээр долоо хоног *"Би-миний найзууд"*, *"Бид хамтдаа"*, *"Хамтдаа хийгээрэй"* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Дээрх жишиг төлөвлөлтүүдээс дараах асуултад хариулт авах боломжтой. Үүнд:

- Үйл ажиллагаа, арга зүйг хэрхэн сонгож сарын төлөвлөлт хийх вэ?
- Тухайн сард ямар СҮД-гүүдийг сонгон авч хэрхэн хооронд нь уялдуулах вэ?
- Долоо хоног, өдрийн төлөвлөлтийг хэрхэн хийх вэ?
- Сургалтын чиглэл хоорондын уялдааг хэрхэн хангах вэ?
- Шаардлагатай дасгал, үйл ажиллагааны давтамжийг хэрхэн тодорхойлох вэ?
- Сургалтын долоон чиглэлийн тэнцвэртэй байдлыг хэрхэн хангах вэ?

Сэдвийн хүрээнд тоглох, үлгэр, зохиол унших, турших, төсөл хэрэгжүүлэх, дуу, хөгжим, хөдөлгөөн, зурах, бүтээх гэх мэт бүх төрлийн үйл ажиллагааг хослуулахыг хичээгээрэй. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүх арга зүйн үндэс нь **тоглох үйл ажиллагаа** байгаа учраас бүлгээр, хамтран, зэрэгцэн, чөлөөт сонголттой хэлбэрүүдийг тэнцвэртэй оруулбал зүйтэй. Эдгээр үйл ажиллагаа, тоглох үйл явцуудыг хүүхдийн сонирхол, хэрэгцээ, хөгжлийн түвшинд тохируулан сонгож төлөвлөнө.

4. Хэрэгжүүлэх, ажиглах, үнэлэх, эргэцүүлэх

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээний үндсэн хэлбэр нь тасралтгүй ажиглалтад суурилсан албан бус үнэлгээ юм. Зорилтот СҮД-д баримжаалан хүүхдийн ахиц, хөгжлийн хэрэгцээг тодорхойлох зорилгоор үнэлгээг хийнэ. Багш өөрийн хэрэгцээ, нөөц боломжид тулгуурлан улирал, жилээр үнэлгээг нэгтгэж хүүхдийн ахицыг тодорхойлж дараагийн төлөвлөлтөд тусгана. Ингэхдээ багш нар үнэлгээний шалгуурын хүрээнд ажиглалтын хуудас, эргэцүүлэл, шалгах хуудас зэрэг хэрэгсэл ашиглана.

Гарын авлага нь багшид мэргэжлийн хөгжлийн хөтөч болох давхар ач холбогдолтой. Үүний тулд багш нар сэдэв бүрийн төгсгөлд амжилттай хэрэгжсэн үйл ажиллагаа, шалтгаан, сайжруулах шаардлагатай үйл ажиллагааны талаар эргэцүүлээ бичиж хэвших хэрэгтэй. Мөн эргэцүүллийн хүрээнд бусад багш нартай хэлэлцүүлэг өрнүүлж санал бодлоо солилцвол илүү үр дүнтэй. Эдгээрт тулгуурлан багш үйл ажиллагаануудыг төлөвлөж цаашид хүүхдийнхээ хэрэгцээ, сонирхол болон орон нутгийн онцлогтой уялдуулан сайжруулахын зэрэгцээ өөрөө мэргэжлийн ур чадварын хувьд өсөж хөгжих юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХӨТӨЛБӨРИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙ

2.1. Бага насны хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох тухай

Хүрээлэн буй орчны өөрчлөлт, түүний зүгээс тавигдаж байгаа шаардлагад нийцэх нь дасан зохицох чадвар юм. Дасан зохицох чадвар нь сэтгэц-физиологи, гүйцэтгэх үйл ажиллагаа, хүрээлэн буй орчны нөхцөл байдал, хүмүүсийн харилцаа хандлагад дасах үйл явцыг агуулна. Тиймээс хүүхэд цэцэрлэгт дасан зохицох чадвар нь нийгмийн орчинд дасан зохицож буй нэг хэлбэр бөгөөд цэцэрлэгийн орчинд хүүхэд бие бялдар, сэтгэлзүйн хувьд аюулгүй тайван байх мэдрэмж юм.

Хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох чадварт тэдний сэтгэл хөдлөл, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийн онцлогоос гадна дараах хүчин зүйлс нөлөөлдөг.

- Хүүхдийн амьдралын өөрийн туршлага
- Эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдийн цэцэрлэгт итгэх итгэл
- Эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдэдээ итгэх итгэл
- Цэцэрлэгийн багшийн хүүхдэд анхаарал хандуулах, итгэлцлийн харилцаа

Судлаачид дасан зохицохуйн гурван түвшинд авч үзсэнийг дараах хүснэгтэд харуулъя.

Хүснэгт 2. Хүүхдийн дасан зохицох түвшин

Дасан зохицох чадвар сайн	Дасан зохицох чадвар дунд	Дасан зохицох чадвар сул
<ul style="list-style-type: none"> - 10-15 хоногийн дотор хүүхэд хэвийн байдалд орж хамт олны дотор биеэ чөлөөтэй авч явж, өвдөх, хямрах байдал бага байна. - Хичээлийн агуулга хөтөлбөрийг хялбархан бүрэн эзэмшинэ. - Төвөгтэй асуудлыг шийдвэрлэнэ. - Хичээнгүй, багшийн заавар тайлбарыг анхаарч сонсоно. Хяналт шаардлагагүйгээр үүрэг даалгаврыг биелүүлнэ. - Цэцэрлэгт явах дуртай, багшийн шаардлагыг зохистой хүлээж авна. - Бие даан ажиллах чадвар сайн. - Нийгмийн идэвх өндөр, хариуцлагатай уриалгахан байна. 	<ul style="list-style-type: none"> - Ахиц дэвшил нь сарын дотор хэвийн байдалд орж, жин нь түр зуур хасагдаж, “өвдөх” болон сэтгэл санааны бага зэргийн хямралаар илэрнэ. - Цэцэрлэгт явахдаа дургүйцдэггүй. - Багш хичээлийг дэлгэрэнгүй, дүрслэлтэй заахад ойлгож авна. - Томчуудын хяналт дор даалгаврыг анхааралтай хийж гүйцэтгэнэ. - Зөвхөн сонирхолтой зүйлд төвлөрнө. - Ангийн олон хүүхэдтэй нөхөрлөнө. 	<ul style="list-style-type: none"> - 2-6 сар үргэлжилдэг. Энэ үед хүүхэд байн байн өвдөх, дадал болсон зүйлээ мартаж, биеийн болон сэтгэл санааны хямралд ордог. - Цэцэрлэгтээ явах дургүй. - Сэтгэл зүйн хувьд дарамттай. - Ангийн дүрэм журмыг дагаж мөрдөхгүй. - Багшийн тайлбарласан зүйлийг хэсэгчлэн ойлгоно. - Бие дааж ажиллах чадвар сул, аливаа даалгаврыг хяналт дор гүйцэтгэнэ. - Багш эцэг эхийн зүгээс тогтмол хяналт тавих, байнга сануулах, тусламж шаардлагатай. - Дотно найз нөхөдгүй, цөөн тооны хүүхдийн нэрийг мэднэ.

Түүнчлэн хүүхдийн бие махбод, өөрийгөө илэрхийлэх, орчноо мэдрэх чадвар, гэр бүлдээ эзлэх байр суурь, гэр бүлийн уур амьсгал зэрэг нь дасан зохицолд нь нөлөөлдөг. Оюун ухааны хөгжил сайтай, сэтгэл хөдлөлийн хувьд тогтвортой хүүхдэд дасан зохицоход бэрхшээл тулгардаггүй бол сэтгэл хөдлөлийн тогтворгүй хүүхдүүдэд хүндрэлтэй байдаг.

Хүүхдийн хувийн онцлог, гэр бүлийн соёл, дадал зэргээс шалтгаалан шинэ нөхцөлд дасан зохицох чадвар нь харилцан адилгүй өөр өөр байдаг ч дасан зохицох тодорхой үе шатыг туулдаг. Тухайлбал, 3.Фрейдийн онолоор хүүхэд хуучин байдлаа хадгалан үлдэхийг хичээдэг учраас шинэ нөхцөлд дасан зохицохдоо түгшүүрийн үе, дайчлах үе, дасан зохицох эсвэл үл дасан зохицох гэсэн 3 үе шатыг дамждаг бөгөөд дасан зохицохын тулд хичээж, тайван юм уу тэнцвэртэй байдлыг олж авахыг хичээдэг гэж үздэг байна. Үүнд:

Түгшүүрийн үе: Энэ үе шат нь айх, түгших, сандрах, зөрүүдлэх, зэрэг сэтгэл санааны тогтворгүй байдлаар илэрдэг. Энэ үед хүүхдэд дарамттай мэдрэмж зонхилж, жин нь хасагдах, хоолонд дургүй болох, ойр ойрхон өвдөх, дадал болсон зүйлээ мартаж, дүрэм журам зөрчих зэрэг шинж тэмдэг болно. Энэ үе шат хүүхдийн дасан зохицох чадвараас шалтгаалан харилцан адилгүй хугацаанд үргэлжилнэ.

Дайчлах үе: Энэ үе шат нь сэтгэл санаагаа тайвшруулах, айдсаа даван туулах, бусдыг дуурайх, өөрийгөө танин мэдэх, өөртөө итгэлтэй болох, бусдад итгэх зэрэгт хүчин чармайлт гаргах үе. Хүүхдийн өсөлт хөгжил удаашралтай тэнцвэрийн энэ үе шат 3-5 сар үргэлжилнэ. Энэ үед хүүхдүүд өөрийн бие махбодыг дээд зэргээр дайчилна.

Дасах эсвэл үл дасах үе: Энэ шатанд хүүхэд маш хурдтай хөгжиж, өмнөх удаашралыг нөхөж гүйцдэг. Хэрэв хүч нөөцөө хэчнээн дайчлаад нөлөөллийг даван туулж чадахгүй бол үл дасах байдалд орно. Ийм тохиолдолд хүүхдийн сурч, хөгжих боломжид саатал гарах магадлалтай. Харин дасан зохицлын хувьд хэвийн хүүхдүүд шинэ чадвар, дадал эзэмших авьяас билгээ хөгжүүлэх явцдаа асар их сэтгэл ханамж авч цэцэрлэгтээ дасан зохицож, суралцах чадвар нь илүү байдаг ажээ.

Цэцэрлэгийн бүлгийн багшаас хүүхдийн дасан зохицож буй чадварыг өглөөний хүлээн авалтын үед 14 хоногоос дээш хугацаанд хүүхдэд илрэх шинж, үйлдлийг дараах байдлаар ажиглаж, 1-5 хүртэл үнэлгээг хийж болно.

Үнэлгээний асуулт	Үнэлгээний дүгнэлт
Эцэг эхээсээ салж үлдэх үед уйлах	Цэцэрлэгт хүүхдээ хүргэж өгөхөд эцэг эх, асран хамгаалагчдаасаа салж, үлдэхэд удаан хугацаа зарцуулдаг
Салах үед эцэг эхээсээ "дүүжлэгдэх"	Цэцэрлэгт хүүхдүүдтэй хамтран хийх үйл ажиллагаа болон тоглоомд оролцдоггүй
Өдрийн турш уйлах	Өдрийн турш хоол идэхээс татгалзаж, бусад хүүхэдтэй харилцдаггүй
Үйл ажиллагаа, тоглоомд оролцож байгаа түвшин сул	Оройн таралтын үед эцэг эх, асран хамгаалагчдаас хүүхдэдээ санаа зовсон үйлдэл гаргадаг
Дүрэм журмыг дагахгүй байх	Оройн таралтын үед эцэг эх, асран хамгаалагчдаа хараад хүүхэд уйлдаг
Эцэг эхтэйгээ орой уулзах үедээ уйлах	Цэцэрлэгийн орчинд байгаа насанд хүрэгчидтэй харилцаа үүсгэж ярилцдаггүй байдал хүүхдэд хоёр долоо хоногоос илүү хугацаагаар үргэлжилсэн, бусад сөрөг шинж тэмдгүүд илэрсэн

Иймээс хүүхдийг цэцэрлэгт дасгахын тулд дараах ажлыг зохион байгуулж болно.

- Цэцэрлэгт эцэг эх, асран хамгаалагчдын дэргэд хүүхэд байх хугацааг бий болгож бага багаар дасгах;
- Цэцэрлэгт хүүхдээ хүргэж өгсөн үедээ эцэг эх, асран хамгаалагчдад сэтгэл санааны таагүй байдал мэдрэмж бий болсон бол багш, сэтгэл зүйчтэй ярилцах;
- Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн цэцэрлэгийн орчинтой танилцах боломжийг бүрдүүлэх;
- Цэцэрлэг нь байгууллагын хүний нөөц болон материаллаг боломжид тулгуурлан хүүхдийн дасан зохицох чадвар, нийгэмшүүлэхүйн үйл явцыг дэмжих ажлыг зохион байгуулах;
- Насанд хүрэгчдээс цэцэрлэгт явагддаг үйл ажиллагаатай холбоотой үлгэр, зохиолыг хүүхдэд уншиж өгөх;
- Багш нар болон туслах ажилтнуудаас хүүхдийг зохион байгуулсан үйл ажиллагаанд хүчээр оролцуулах, явуулахыг албадахгүй байх;
- Цэцэрлэгт итгэж, аюулгүй байдал, хүлээн зөвшөөрөгдсөн мэдрэмжийг бий болгох.

Цэцэрлэгт эцэг эх, асран хамгаалагчдын итгэх итгэл нэмэгдэхэд хүүхэд цэцэрлэгийн орчинд таатай байх, бусад хүүхдүүдтэй харилцах зэрэгт ахиц гардаг болохыг судалгаагаар баталсан байдаг. Иймд дасан зохицож байгаа нь дараах шинжээр илэрч болно. Үүнд:

- Хүүхэд хооллох дуршилтай болдог;
- Хурдан унтдаг, цагтаа босдог;
- Бусадтай эерэг сэтгэл хөдлөлөөр харилцдаг;
- Амархан тоглодог, хамтардаг

2.2. Сургалтын хөтөлбөрийн арга зүйтэй уялдах онол

Сургалтын хөтөлбөрийг суралцахуйн загварын онол, бодит суралцахуйн онол болон конструктивист онолд суурилж боловсруулахыг Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд тусгасан.

Зан үйлийн болон танин мэдэхүйн онолууд нь хүүхдийн суралцахуйд нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч хэд хэдэн хүчин зүйлийг илүү чухалчилж үздэг. Тухайлбал, зан үйлийн онолууд нь хүрээлэн буй орчны нөлөө, ялангуяа өдөөлт ба сэдэлжүүлэлтийн онцлог, түүний зохион байгуулалт, хэлбэр, мөн хүүхдийн үзүүлэх зан үйлд багшийн хариу үйлдэл, орчныг онцгой чухалчилдаг (Dale, 2012). Зан үйлийн онолын гол төлөөлөгчид нь Джон Ватсон (John Watson), Б. Ф. Скиннер (B. F. Skinner) нар юм. Тэд зан үйлийн зөв дадал төлөвшихөд дотоод сэтгэлгээ бус, орчны нөлөө чухал үүрэгтэй гэж үзээд нөхцөлт үйл, эерэг хариу үйлдлээр хүүхэд эерэг зан үйлд суралцана гэж үзжээ. Энэ онолын үүднээс суралцах үйл, дадал нь орчноос ирэх хариу үйлдлийн үр дүн хэмээн үздэг бөгөөд эерэг, сөрөг хариу үйлдэл, давталт нь хүүхдийн суралцах зан үйлийг бэхжүүлэх ба энэ нь хүүхдийн сурах хандлага, оролцоонд шууд нөлөөлдөг (Schindler et al., 2019). Өөрөөр хэлбэл, хүүхэд орчноос ирэх нөлөөлөл буюу орцоор суралцах үйлд сэдэлждэг бөгөөд эдгээрийг хүүхэд хэрхэн боловсруулдаг үйл явцыг танин мэдэхүйн онол тайлбарладаг.

Танин мэдэхүйн онолууд нь хүрээлэн буй орчноос ирэх хариу үйлдэл хүүхдийн суралцахуйд нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрдөг (Dale, 2012). Багшийн мэдээлэл, өдөөлт, үйл ажиллагаа, зааварчилгаа, хүүхдийн асуулт, хүсэлтэд өгөх багшийн хариу үйлдэл зэрэг нь хүүхдэд орчноос ирж буй суралцахуйн орц юм. Эдгээр орцууд нь хүүхдэд суралцах чадварыг бүрэн өгдөггүй (David et al., 2015). Танин мэдэхүйн онолын гол төлөөлөгч нь Ж. Пиаже, Ж. Брунер нар бөгөөд хүүхэд орчноо хүртэж, танин

мэдэхдээ оюуны идэвхтэй үйл хийдэг. Харин тэдгээрийг хүүхэд ажиглах, дуурайх, давтах, залруулах зэрэг идэвхтэй үйлээр боловсруулж байдаг нь суралцахууд хөтөлж, чиглүүлж байдаг. Хүүхэд орчноос ирж буй орцыг (багшийн мэдээлэл, өдөөлт, сэдэлжүүлэлт, үйл ажиллагаа, зааварчилгаа, хүүхдийн асуулт, хүсэлтэд өгөх багшийн хариу үйлдэл зэрэг) анхаарах, ажиглах, дүрслэх, хувиргах, кодлох, хадгалах, өөрт шинэ мэдлэгийг бүтээх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, танин мэдэхүйн онолууд нь хүүхдийн өөрийнх нь сонирхол, бодол санаа, итгэл үнэмшил, хандлага, үнэт зүйлсийн үүргийг чухалчилдаг.

Дээрх хоёр чиглэлийн онолоос гадна хүүхдийн сурах арга барил, хандлага төлөвшихөд чиглэсэн конструктивист (Constructivist) онолууд нь хүүхэд мэдээлэл хүлээн авагч бус, мэдлэгийг өөрийн үйл ажиллагаа, туршлагаар бүтээгч хэмээн үздэг, хүүхдийг идэвхтэй суралцагч хэмээн үздэг. Конструктивист онолчид шинжлэх ухааны цор ганц, туйлын үнэн байдаг гэсэн ойлголтоос татгалзаж, үнэн олон талтай, эргэлзээтэй үнэнийг олон янзаар нээж, баталж болно хэмээн үздэг (Dale, 2012). Энэ олон талт үнэнийг илрүүлэх арга зам нь асуулт тавих, ажиглах, асуудлыг олж харах, бодох, уялдаа холбоог олох, шийдвэр гаргах зэрэг идэвхтэй үйл ажиллагаа юм. Энэ идэвхтэй үйл ажиллагаа нь хүүхдийн тоглох үйл юм. Хүүхэд тоглох явцдаа ертөнцийг танин мэдэх, төсөөлөн бодох, нийгэмших, хэл ярианы чадвараа хөгжүүлдэг. Тоглох явцдаа юмс үзэгдлийн мөн чанар, логик уялдааг ойлгож, асуудлыг олж харах, шийдэх чадвартай болдог.

Аливаа үйл ажиллагааг хүүхэд өөрийн хүсэл сонирхлоор, зорилготой, сонголтоор хийх (үүнийг хүүхэд төвт үйл ажиллагаа гэж хэлдэг) ба багш орчныг сонирхолтой байдлаар төлөвлөж зохион байгуулах, хүүхдийн үйл ажиллагааг ажиглах, чиглүүлэх, шаардлагатай дэмжлэгийг үзүүлдэг. Энэ нь хүүхэд өөрийн хурдаар тааваараа, сонирхолдоо хөтлөгдөн, учир утга зорилготой үйл ажиллагаанд оролцох, улмаар бие даасан байдал, шүүн тунгаах, асуудал шийдвэрлэх чадварт суралцах боломжийг бүрдүүлдэг (Farquhar & White, 2014).

Бага насны хүүхдийн суралцахууг дэмжих, хөтлөн чиглүүлэхэд багшийн анхаарах зүйлсийг суралцахуын онолтой холбон үзье.

Хүснэгт 3. Суралцахуын онол

Суралцахуын онол	Зорилго	Багшлахуй
Зан үйлийн онол	Хүүхдийн суралцах үйл ажиллагааг сэдэлжүүлэх, нөлөөлөх (суралцахуын орц)	<ul style="list-style-type: none"> - Хүүхдэд эерэг зан үйл төлөвшихөд чиглэсэн давтамжтай, эерэг хариу үйлдэлт, чиглүүлэгтэй орчин бүрдүүлэх. - Хүүхдийн зан үйлд тохирсон эерэг хариу үйлдэл (урамшуулал, чиглүүлэг, дэмжлэг гэх мэт) үзүүлэх, сөрөг зан үйлийг залруулах. - Эерэг зан үйлийг давтах, бататгах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг ажиглах, үнэлэх.
Танин мэдэхүйн онол	Хүүхдийн суралцахууг идэвхжүүлэх, суралцахуын дадалд хөтлөх (мэдээлэл боловсруулах, суралцах үйл явц)	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн сэтгэхүйн хөгжлийг дэмжих нээлттэй асуулт асуух, сорилттой дасгал даалгавар өгөх. - Хүүхдийн анхаарах, ажиглах, дүрслэх, төсөөлөх, илэрхийлэх, дүгнэх үйлийг дэмжсэн үйл төлөвлөх. - Суралцах үйл ажиллагаанд багш мэдээлэл дамжуулагч бус, чиглүүлэгч, хамтрагч байх.

Конструктивист онол	Хүүхдийн сурах арга барил эзэмшихэд чиглүүлэх, суралцах хандлага төлөвшүүлэх (суралцахуйг хөтлөх үйл, үр дүн)	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн идэвхтэй үйл ажиллагаа, оролцоог дээдэлсэн, бие даан мэдлэг бүтээх орчныг бүрдүүлэх (зохиолд суурилсан, тоглоход суурилсан, төсөлд суурилсан, судлан шинжлэх). - Хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурласан, утга учиртай, зорилготой үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах. - Хамт олонтойгоо харилцах боломжийг нэмэгдүүлэх, хамтын суралцахуйг дэмжих.
---------------------	---	---

Бага насны хүүхдийн хөгжил, суралцахуйг дэмжихдээ багш зан үйлийн, танин мэдэхүйн, конструктивист онолуудад тулгуурлах нь багшлах үйл ажиллагаа үр дүнтэй болох шинжлэх ухааны үндэслэл болно. Хүүхдийн зан үйлд тохирох эерэг хариу үйлдэл үзүүлэх, оюуны болоод нийгэм-сэтгэл хөдлөл, бие даасан бүтээлч сэтгэлгээг дэмжих нь суралцах үйл ажиллагааг хүүхдийн хөгжлийн онцлогт нийцүүлэн үр дүнтэйгээр удирдахад чухал ач холбогдолтой. Иймээс суралцахуйн онолуудын уялдаа холбоог ойлгож, багшлах үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь багшийн мэргэжлийн чадамжийн нэг чухал бүрэлдэхүүн болдог.

2.3. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн талаарх дараах чиглэлийг тусгасан. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд суралцагчийн хөгжлийн онцлогт нийцүүлэн суралцахуйн загварын, бодит суралцахуйн, конструктивист болон хувилбарт сургалтын онолын үндсэн дээр боловсруулсан сургалтын идэвхтэй аргыг хэрэглэнэ.
- Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалт, үйл ажиллагаанд тоглоом, зохиол, шинжлэн судлах, төсөлд суурилсан арга зүйг хүүхдийн насны онцлог, эзэмших чадамж суралцахуйн үр дүн, сургалтын чиглэлийн онцлогтой холбон бүтээлчээр хэрэглэнэ.
- Монгол суралцагчийн цогц чадамжийг төлөвшүүлэхэд суралцахуйн чиглэлийн онцлог бүрийн оруулах хувь нэмрийг тусгасан бөгөөд үүнийг нэгдмэл уялдаатай, хүүхэд төвтэй байхуйц суралцахуйн арга зүйгээр зохион байгуулна. Түүнчлэн дээрх арга зүй нь үйлээр дамжиж чадамжид хувь нэмрээ оруулах бөгөөд үүнийг дараах хүснэгтээр танилцуулъя.

Хүснэгт 4. Эзэмших чадамж

Монгол суралцагчийн эзэмших чадамж	Суралцахуйн арга зүйг хэрэгжүүлэх явцад хүүхдийн хийх үйлийн хувилбар	
	2-4 хүртэлх настай хүүхдийн хийх үйл	4-5 настай хүүхдийн хийх үйл
Бүтээлчээр сэтгэх	Гол санааг олох, дүрд хувирах	Төсөөлөх, бүтээл, биеийн хэлэмжээр өөрийгөө илэрхийлэх, шинэ санаа гаргах
Шүүн тунгаах	Ажиглах, асуулт тавих, зөв бурууг таних	Зөв, бурууг таних, учир шалтгааныг олох
Суралцахуйд суралцах	Асуулт асуух, хариулах, идэвхтэй сонсох, үйл ажиллагаанд оролцох	Шийдэл олох, учир шалтгааныг ойлгох, танин мэдэх, өөрийгөө удирдах
Харилцах	Бусдыг сонсох, биеийн хэлэмж, хэл яриагаар өөрийн санаа бодлоо илэрхийлэх	Ялгаатай байдлыг хүндэтгэх, ээлжээ хүлээх, дүрэм баримтлах, зөрчлийг шийдвэрлэх
Хамтран ажиллах	Бусдын тоглохыг ажиглах, хамтран тоглох, бусдад туслах	Багаар тоглох, хамтран үйл хийх, ээлжээ хүлээх, бусдад туслах


Нийгэм, сэтгэл хөдлөл	Бусдын сэтгэл хөдлөлийг мэдрэх, таних, дүрмийг мөрдөх,	Бусдад туслах, хамтрахад суралцах, өөрийн сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, эрх тэгш харилцах
Үндэсний болон дэлхийн өв соёл	Зан заншлаас таньж мэдэх	Соёлын ялгаатай байдлыг ойлгох, хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх

Монгол суралцагчийн эзэмших чадамжийн хүрээнд хийх үйлийг суралцахуйн арга зүйтэй холбон авч үзсэн бөгөөд арга зүй тус бүрийн онцлог, үе шатыг цааш дэлгэрүүлэн авч үзье.

Сургуулийн өмнөх насны 2-4 хүртэлх насны хүүхэд буюу цэцэрлэгийн бага, дунд бүлэгт хэрэгжүүлэх арга зүйн онцлогийг авч үзье.

Тоглоомд суурилсан арга зүй: Суралцахуйн онолын үзэл, чиг хандлагын ихэнх бүтээлүүдэд хүүхдийн үндсэн үйл ажиллагаа тоглоом бөгөөд түүгээр дамжуулан тэд суралцаж, хөгжиж, танин мэдэж, бусадтай харилцаж, насанд хүрсэн үеийн танин мэдэхүйн хөгжлийг тодорхойлох авч үзсэн байдаг. Тухайлбал, Жан Пиаже хүүхдийн тоглох үйл нь танин мэдэхүйн хөгжилд онцгой хамаатай бөгөөд тэд машин барих, гал тогоо сэдэвт тоглоомын наадгайгаар хоол хийх зэргийг харснаа даган дуурайж аливаа зүйлс хэрхэн ажилладгийг ойлгож эхэлдэг. Мөн Жан Пиаже “өөрөө мэдлэгээ бүтээх нь бусдаар заалгахаас хавь илүү гэж үзэж тоглохыг суралцахуйн гол арга зам” гэсэн санааг дэвшүүлсэн байна. (Жанет Гонзалез -Мина, 2024)

Зураг 1. Тоглоомд суурилсан арга зүйн онцлог



(Bergen, D., & Fromberg, D., 2009)

Сургуулийн өмнөх насны 2-4 хүртэлх насны хүүхэд буюу цэцэрлэгийн бага, дунд бүлэгт тоглоомд суурилсан арга зүйгээр сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахдаа хүүхдийн сэтгэлзүйн болон тоглох онцлогийг харгалзахаас гадна тоглоом нь тэднийг үл таних зүйлст бэлтгэх сайн арга гэдийг анхаарч, дараах санаатай танилцаарай.

- *Тоглоом, наадгайг тогтсон “байр” тай байлгах:* Хайрцаг дотроос хэрэгтэй тоглоом наадгайг олж авах нь хоёр настай хүүхдэд ихээхэн хүндрэлтэй ба юмсын эмх цэгц, дэс дараалал өөрчлөгдөхөд бухимдах тул тоглоом нь намхан тавиур дээр тогтсон “байр” тай байх нь чухал.
- *Тоглоом, наадгайг сонгоход туслах:* Тоглох үйл явцад бүрэн оролцож чадахгүй байгаа хүүхдэд зориулан наадгайг сонгоход тусалж анхаараарай. Тухайлбал, харах чадвар сул хөгжсөн хүүхэд мэдэрч хүртэхүйн чадварыг сайжруулах наадгайг өгч тоглуулах нь эд зүйлсийн шинж чанарыг тодорхойлох туршлага хуримтлагдаж, хүртэхүйн тусламжтайгаар гадаргуу болон хэлбэр дүрсийн талаарх ойлголт, мэдээлэл үүсдэг.
- *Тоглоом, наадгайг хамтдаа хураах, цэгцлэх:* Хүүхэд тоглож дуусаад наадгайг хураах, зөвхөн хураасны дараа өөр наадгайгаар тоглох чадварыг багшаас суралцах тул үлгэрлэн харуулах нь үгээр заахаас илүү үр дүнтэй.

- *Хүүхэдтэй хамтдаа тоглох:* Багш та хүүхэдтэй хамтран тоглохдоо тэд ямар төрлийн тоглоом сонирхож байгаа болон сонирхохгүй байгааг ажиглах, цаашид хэрхэн хөгжлийг дэмжих гарцаа ч олж харах боломжтой.
- *Арга зүйг хослуулан хэрэглэх:* Бүлгийн сургалт, үйл ажиллагааг тоглоом болон бусад арга зүйтэй хослуулан, тухайлбал, зохиолд, шинжлэн судлахад, төсөлд суурилсан арга зүйтэй хослуулсан хэлбэрээр зохион байгуулж болно.

Чөлөөт тоглоомын үед хүүхэд насанд хүрэгчдийн хөндлөнгийн оролцоо, чиглүүлэггүйгээр юугаар, хэрхэн тоглохоо сонгох боломжтой. Чөлөөт тоглоом нь хүүхдийн нийгэм, сэтгэл хөдлөл, хэл яриа, бүтээлч сэтгэлгээ зэрэг чадвар хөгжихөд эергээр нөлөөлөхөөс гадна өөрийн сонирхлоо танин мэдэх, хөгжүүлэх боломжийг олгодог. Харин чиглүүлэгтэй тоглоом нь насанд хүрэгчээс хүүхдийн тоглох үйл ажиллагааг ямар нэгэн байдлаар удирдан чиглүүлэх хэлбэр бөгөөд шинэ мэдлэг, чадварт суралцахад бичиг үсэг, тоо бодох, байгаль шинжлэл гэх мэт тодорхой чиглэлээр хүүхдийн суралцахуйг дэмжихэд (Bergen, D., & Fromberg, D., 2009) эергээр нөлөөлдөг.

Тоглоомд суурилсан арга зүйн мөн чанарыг ойлгох, санаа сэдэл төрүүлэхэд дэмжлэг болгох зорилгоор багш танд зохион байгуулах хувилбарыг танилцуулъя.

Хүснэгт 5. Сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн хувилбар

Үйл ажиллагааны нэр: Бөмбөг шидээрэй	Хэрэглэгдэхүүн: Гурав хүртэл өнгийн жижиг бөмбөг, наадгай сагс, хөгжмийн ая	Суралцахуйн үр дүн: ХЭМ1.1а. Гарын сарвууг атгах, тэнийлгэх, сэгсрэх, базах хөдөлгөөнийг жижиг тоглоом, эд зүйлийг ашиглан тоглоно. ХЯ1.2а. Харилцан яриаг ажиглан үг, өгүүлбэрийг дуурайж, оролцоно. НСХ1.3а. Насанд хүрэгчийн тусламжтайгаар байнга хэрэглэдэг эд юмсыг байранд нь хураана.
<p>Аргачлал: Хөгжмийн аянд багш, хүүхдүүд хамтдаа алхаж, сагснаас бөмбөг авч барьж, тэмтэрнэ. Хөгжмийн ая зогсоход багш “шидээрэй” гэж хэлж хамтдаа бөмбөгийг нүхтэй бай руу шидэж оруулахыг эрмэлзэнэ. Хамтдаа “нэг хоёр гурав” гэж хэлж бөмбөгийг шидэж ч болно. Хүүхдүүд үгийг дуурайж хэлэхэд багш урамшуулна. Газарт өнхөрсөн бөмбөгийг багш, хүүхдүүд хамтдаа цуглуулж өнгийн сагсанд ялган хийнэ.</p>		
<p>Тайлбар: Хүүхэд бөмбөгийг барьж атгах, шидэх, өнхрүүлэх дуртай бөгөөд энэ нь зориулалт, өнгө, хэмжээ зэргийг танин мэдэх гэсэн хүсэл, сонирхолтой холбоотой. Багшийн тусламжтайгаар тооны нэрийг даган хэлж, дуурайх эрмэлзлээс гадна тооны үг хэллэг мэддэг болох алхам болж байна.</p> <p>Багш тоглоом, наадгайг хураахыг хүүхэд хараад “энэ чухал бөгөөд сонирхолтой, гоё ажил байна” гэж ойлгодог. Заримдаа хүүхэд тоглоомоор тоглохоос илүү буцааж хураах дуртай байх ба багшийг тоглоом хураахыг өдөр бүр хараад дуурайж суралцаж эхэлнэ.</p>		
<p>Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагааны цагт зохион байгуулагдаж байгаа ч дараагийн үйл ажиллагааны бэлтгэл, үргэлжлэл байж болно. Тухайлбал, тойргийн цагт хүүхдүүд “алаг бөмбөг” дууны аянд тойргоор бүжиглэх, хайрцгийн дугуй хэлбэртэй нүхтэй хэсэгт гараа хийж бөмбөгийг гаргаж авах зэргээр үргэлжлүүлэн тоглож болно.</p> <p>Энэхүү үйл ажиллагаа нь суралцахуйн үр дүн, арга зүйн уялдааг хангахаас гадна тархины хөгжил, нүд-гарын хөдөлгөөний зохицлыг дэмжих зэрэг эерэг нөлөөтэй юм.</p>		

Зохиолд суурилсан арга зүй: Зөвхөн үлгэр, зохиол, хүүхдийн яриа, өгүүлэмжийг сонсож, ярих бус, тэдгээрийн дүр, үйл явдал, юмс үзэгдлээр тэдний суралцахуйд сэдэлжүүлэх, бодит амьдралтай уялдуулах гүүр болгож ашигладаг онцлогтой. Бэлэн

үлгэр, зохиолоос гадна хүүхдийн өөрийн өгүүлэмж яриаг суралцах үйлийн эх сурвалж болгон ашигладаг онцлогтой. Багш, хүүхэд үлгэр зохиол, өөрт тохиолдсон явдлаа яриад зогсохгүй, асуулт асууж харилцан ярилцах, үлгэрийн дүрд тоглох, дүр үйл явдлыг урлан бүтээх, үлгэрийн төгсгөлийг өөрөөр бодож бүтээх зэрэг идэвхтэй үйл ажиллагаанд оролцдог. Энэ нь хүүхэд мэдээлэл хүлээн авах бус, мэдлэг “бүтээж” суралцах боломжтой болдог.

Сургуулийн өмнөх насны хүүхдүүд үлгэр, зохиолын дүрийн харагдах байдал болон үйл явдлын шууд утгыг ойлгож хүлээн авах, баатрын зан үйл, хөдөлгөөнийг дуурайх, эд юмсын хэлбэр дүрс, өнгө, онцлог шинжийг ялган таних, мөн үйл явдлын дэс дарааллыг тогтоох байдлаар суралцах онцлог илэрдэг.

Хүснэгт 6. Хүүхдийн хөгжилд зохиолд суурилсан арга зүйн үзүүлэх эерэг нөлөөллийн хувилбар

Хүүхдийн хөгжил	Хүүхдийн суралцах үйл
Танин мэдэхүй	<ul style="list-style-type: none"> • Үлгэрийн үйл явдлыг шууд ойлгож, дүрүүдийг таних, нэрлэхэд суралцдаг. Жишээ нь: Энэ охин нь, энэ ээж нь. (<i>Ж. Пиажегийн Оюун ухааны хөгжлийн онолын Үйлдлийн өмнөх үе шат</i>) • Шалтгаан-үр дагаврыг энгийн түвшинд ойлгоно. Жишээ нь: Хүү нь уйлсан болохоор ээж нь аргадсан. (<i>Ж. Пиажегийн Оюун ухааны хөгжлийн онолын Үйлдлийн өмнөх үе шат</i>) • Өөрийн туршлагатай холбож ойлгодог. Жишээ нь: Намайг уйлахад ээж бас аргадаг. (<i>Л. С. Выготскийн Нийгэм соёлын онол</i>)
Сэтгэл хөдлөл	<ul style="list-style-type: none"> • Дүрийн мэдрэмжийг өөрийнхөөрөө мэдэрч, баярлах, гуниглах, айх зэрэг энгийн сэтгэл хөдлөлийг ялгаж эхэлдэг. Жишээ нь: Хүү нь гунигтай байсан. (<i>Ж. Пиажегийн Оюун ухааны хөгжлийн онолын Үйлдлийн өмнөх үе шат</i>) • Үлгэрийн дүртэй сэтгэл санааны холбоо үүсгэж, аюулгүй мэдрэмж авдаг. Жишээ нь: Би үлгэрт гардаг хүү. (<i>Ж. Боулбийн Ээнэгшлийн онол</i>)
Нийгэмшихүй	<ul style="list-style-type: none"> • Дүрд орж, үлгэрийн баатрыг дуурайдаг. Жишээ нь: Хүү нь ингэж гунигладаг. (<i>Ж. Пиажегийн Оюун ухааны хөгжлийн онолын Үйлдлийн өмнөх үе шат</i>) • Үлгэрийн баатрыг шууд дуурайж туршина. Жишээ нь: Би ч бас тоглоомоо найздаа өгнө. (<i>А. Бандурагийн Нийгэм суралцахуйн онол</i>)

Зохиол сонгоход анхаарах зүйлс

1. Үйл явдал энгийн, богино байх (1-2 үйл явдал);
2. Үйл явдал, үг хэллэг давталттай байх (шүлэглэсэн хэсэгтэй байвал сайн);
3. Сэтгэл хөдлөл тод илэрхийлэгдсэн байх;
4. Дуу авиа ашиглах боломжтой байх;
5. Ном сонгох бол дүрийн зураг тод, үйл явдлын дүрслэлтэй байх.

Сургуулийн өмнөх 2-4 настай хүүхдүүд буюу цэцэрлэгийн бага, дунд бүлэгт тус арга зүйг дараах ерөнхий бүтцийн дагуу хэрэгжүүлж болно. Үүнд:

- 1- р үе шат: Зохиолоо сонсох ба дүрүүд, үйл явдалтай нь танилцах;
- 2- р үе шат: Өөр хэлбэр, зохион байгуулалттайгаар зохиолтой давтан танилцах;
- 3- р үе шат: Дүрд тоглох ба бүтээлчээр оролцох;
- 4- р үе шат: Сургалтын чиглэл, суралцахуйн үр дүнг интеграцчилан хэрэгжүүлэх.

Арга зүйн зөвлөмж

– Үлгэр, зохиолыг ярихдаа хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан тэдний мэдэх үгээр, хурдаа тохируулан ярих: Давтан ярихдаа жүжигчлэн тоглох, орчин,

хэрэглэгдэхүүний сонголт өөр байх нь хүүхдийн сонирхлыг татах, анхаарал удаан төвлөрөх нөхцөлийг бүрдүүлдэг.

- Зохиол ярих явцдаа хүүхдийг оролцуулах: Зохиолын эхэнд номын хавтсыг харуулж “Энэ юу вэ?”, “Энэ зохиолд хэн хэн гарах юм шиг байна?”, “Ямар өнгөтэй байна?” зэрэг богино асуултаар хүүхдийн анхаарлыг татаж, харилцан ярилцах боломж олгоно.
- Хөдөлгөөнт тоглоом, үйл хөдлөлтэй хослуулах: Хүүхдийн ойлголтыг бататгах, үйл явдлыг ойлгоход тустай. Жишээ нь, амьтны дуу авиаг дуурайх, баатрын хөдөлгөөнийг дагах, гараараа дүрслэх зэрэг нь хүүхдэд хөгжилтэй, ойлгомжтой байдаг.
- Сургалтын чиглэл, суралцахуйн үр дүнг уялдуулах: Зохиолын дүр, үйл явдал, зохиолд гарсан юмс үзэгдлийг ашиглах суралцахуйн бусад чиглэлийн чадварыг эзэмших үйл ажиллагааг зохион байгуулах нь хүүхдийн танин мэдэхүйн хүрээг өргөжүүлэх, зохиолын дүр, үйл явдлыг эргэн санах, бататгах, юмс үзэгдлийг холбоо хамаарлыг ойлгоход тустай.

Хүснэгт 7. Зохиолд суурилсан арга зүйн хувилбар

Үйл ажиллагааны нэр	Сургалтын хэрэглэгдэхүүн	Суралцахуйн үр дүн	
Манжин үлгэр	<ul style="list-style-type: none"> - Зурагт том ном, үлгэрийн дүрүүдтэй зурагт картууд, аудио бичлэг, ширээний театр - Дүрд тоглох хэрэгслүүд, байгалийн материал: навч, чулуу, хөрс гэх мэт - Зургийн хэрэгсэл 	ХЯ1.3а.Номыг сонирхож үзнэ. НСХ2.1в.Уурлаж тавгүйтсэн шалтгааныг нь асууж ярилцахад тайвширдаг болно.ХЭМ1.1д.Сэдэвт алхалт, гүйлтийг багшийн зааврын дагуу даган дуурайж гүйцэтгэнэ.	
Үе шат	Суралцахуйн үйл	Хүүхдийн хийх үйл	Багшийн хийх үйл
1-р үе шат: Зохиолоо сонсох ба дүрүүд, үйл явдалтай танилцах	Зохиол сонсох	<ul style="list-style-type: none"> - Сонсох, зураг ажиглах - Багшийн хэлж буй үг, хөдөлгөөнийг дагах 	Үлгэрийг тод дуугаар унших,дуу авиа хөдөлгөөнөөр баяжуулах
2-р үе шат: Өөр хэлбэр, зохион байгуулалттайгаар зохиолтой давтан танилцах	Өөр хэлбэрээр давтан сонсох	<ul style="list-style-type: none"> - Зураг харж дүрүүдийг нэрлэх, хөдөлгөөнийг даган гүйцэтгэх, дууг аялах 	Ширээний театр, хуруун хүүхэлдэй, зурагт үзүүлэн зэргийг ашиглан дахин үлгэрийг өгүүлэх
3-р үе шат: Дүрд тоглох ба бүтээлчээр оролцох	Дүрд тоглох, бүтээлчээр оролцох	<ul style="list-style-type: none"> - Дүрийн үйлдлийг хийж үзэх, биеэр мэдрэх байдлаар оролцох Жнь: Татъя, татъя гэж хэлээд урагш хойш татах хөдөлгөөн хийнэ. 	Орчныг бий болгох, баяжуулах, Хүүхдийн оролцоог зохион байгуулан дүр хуваарилах, хүүхдийн сэтгэл хөдлөлийг нэрлэж дэмжих, хүүхдээ ажиглаж чиглүүлэх, хамтдаа хийх

4-р үе шат: Сургалтын чиглэл, суралцахуйн үр дүнг интеграцчилан хэрэгжүүлэх	Интеграцчлан хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Дүрүүдийг болон манжинг өнгөөр ялгаж зурж будах, баримал барих, байгалийн материалаар ногооны талбай хийх - Хэн эхэлж ирсэн бэ дарааллыг биеэр зогсож илэрхийлэх - “Найзаа би чамд тусалъя” дүрд орж тоглон бие биедээ туслах 	Интеграцчилагдсан тоглоом, үйл ажиллагааг зохион байгуулах, өмнөх мэдлэгийг сэргээх, сонирхол төрүүлэх асуулт асууж хүүхдийн сурах, давтан хийх эрмэлзлийг идэвхжүүлэх, хүүхдээ ажиглаж үнэлэх
--	--------------------------	---	--

Тайлбар: “Манжин” үлгэрийг зохиолд суурилсан арга зүйгээр хэрэгжүүлэхэд хүүхэд сонсох, ойлгох, дүрслэх, хамтран оролцох, биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх, сэтгэл хөдлөлийг таних зэрэг олон чадамжийг зэрэг хөгжүүлдэг. Ингэхдээ хүүхэд дүрийн үйлдлийг “хийж үзэх”, “биеэр мэдрэх” байдлаар оролцдог. Тиймээс 2-3 настайчуудыг үлгэрийн үйл явдалд биеэр оролцох, хөдөлгөөнөөр илэрхийлэх боломж олгох нь чухал. Эхлээд богино хэсгээр /эмгэн ба өвгөн/ эхэлж, дараа нь бүх дүрийг нэгтгэн тоглуулна. Үлгэрийн “Хамтдаа хийвэл бүтнэ, бие биедээ тусална гэсэн гол санааг хөдөлгөөн, мэдрэхүй, тоглоомоор мэдрүүлэх нь хамгийн үр дүнтэй юм.

Шинжлэн судлахад суурилсан арга зүй: Энэ нь асуулт асуух, ажиглах, мэдээлэл цуглуулах, баримт нотолгоонд тулгуурлан хамтран дүгнэлт гаргах замаар мэдлэг, нээлт, эргэцүүлэн бодох сэтгэлгээг хөгжүүлж, хүүхдэд төрөлхийн сониуч зангаар асуудлынхаа шийдлийг хайж, сэтгэн бодоход нь тусалж, суралцах үйл явцыг илүү сонирхолтой болгодог.

Сургуулийн өмнөх 2-4 хүртэлх насны хүүхдүүд юмсыг мэдрэхүй, хөдөлгөөнөөр дамжуулан танин мэддэг тул шинжлэн судлах арга зүйг шууд хэрэгжүүлэхээс илүүтэй мэдрэхүйд суурилсан тоглоом, орчны туршлагаар суурийг тавих нь чухал. Шинжлэн судлах үйл хүүхдийн юмсыг барих, амсах, түлхэх, унагах зэргээр орчинтой танилцах үйлдлийг дэмжиж хөгжүүлдэг.

Бага насны хүүхдүүд “яагаад?” асуултаар сониуч зан тодорч, шалтгаан-үр дагаврыг ойлгох анхны оролдлогууд гарч ажиглах, харьцуулалт хийх, энгийн таамаглал гаргах зэргээр хэрэгжүүлэх нь үр дүнтэй. Энэ насны хүүхэд бусдаас ялгаатайгаар бүтээж, туршиж үзэхийг хүсдэг тул бүтээлчээр сэтгэх чадвар хөгжиж эхэлдэг онцлогтой.

Хүснэгт 8. Шинжлэн судлах арга зүйг хэрэгжүүлэх үе шат

Үе шат	Суралцахуйн үйл	Багшлахуйн дэмжлэг
Оролцох үе шат (Өмнөх мэдлэгийг сэргээн сануулах)	<ul style="list-style-type: none"> - Ажиглах - Асуулт асуух - Сонирхох 	<p><i>Асуултаар эхлэх</i></p> <p>Хүүхдүүд сэдвийг бодох, өөрсдөө асуулт асуух, хариулахад дэмжлэг болно.</p>
Шинжлэн судлах үе шат	- Эрэл хайгуул хийх	<i>Эрэл хайгуул хийхийг зөвшөөрөх</i>

(Идэвхтэй эрэл хайгуул хийх боломж олгох)	- Туршилт хийх	Сонирхол татсан асуулт, хариултын дараа хүүхдэд бие даан сонирхох, боломжийг олгоход тусална.
Тайлбарлах үе шат (Эргэцүүлсэн ойлголтоо илэрхийлэх боломжийг олгох)	- Сонирхон, нээн илрүүлэх - Харилцан ярилцах	<i>Туршилтын үр дүнг хэлэлцэх</i>
		Хүүхдүүд өөрийн үгээр ярих, тайлбарлахад урамшуулж дэмжиж, ойлгоход тусална.
Нарийвчлан судлах үе шат (Илүү сайн нарийвчлан боловсруулах)	- Харьцуулах - Өөрийн үгээр ярих - Хийсэн үйлээ нэрлэх, бататгах	<i>Хэрэглэгдэхүүн, нэмэлт эх сурвалжаар хангах</i>
		Хүүхдэд хэрэглэгдэхүүн, наадгайг нэмэлтээр хангаж, хэрэглэх боломжтой бөгөөд энэ нь ойлголтыг бататгахад тусалдаг.
Үнэлэх үе шат (Өөрсдийн ойлголтыг үнэлэх боломжийг олгох)	- Бүтээл үйлээ өөрөө тайлбарлах, ярихыг оролдох - Санал гарах	<i>Сурсан мэдсэнээ нэгтгэн дүгнэх</i>
		Сургалт, үйл ажиллагааны төгсгөлд сурсан зүйлээ дүгнэх нь мэдээллийг эргэн санахад тусалдаг.

Хүснэгт 9. Шинжлэн судлахад суурилсан арга зүйн хувилбар

Үйл ажиллаганы нэр:	Хэрэглэгдэхүүн:	Суралцахуйн үр дүн:	
Хатуу, зөөлөн ялгаа.	Хатуу: модон халбага, түлхүүртэй цоож, хатуу сам Зөөлөн: даавуу, зөөлөн тоглоом, хуванцар зөөлөн аяга	БНО2.1в.Ойр орчны эд зүйлс, тоглоомын шинжийг мэдэрч нэрлэн, зориулалтаар нь ашиглана. ХЯ2.1а.Бусдын яриаг анхаарч, үг өгүүлбэрээр ярина. НСХ2.1.а.Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно.	
Шинжлэн судлах арга зүйг хэрэгжүүлэх аргачлал			
Үе шат	Суралцахуйн үйл	Хүүхдийн хийх үйл	Багшийн хийх үйл
Оролцох үе шат	Ажиглах ба сонирхох	Эд зүйлсийг ажиглаж, хүрч үзэх, барих	Энгийн асуулт тавих: энэ юу вэ,? хатуу юу, зөөлөн үү, чи юу гэж бодож байна вэ ?
Шинжлэн судлах үе шат	Турших	Хүүхэд цохиж, хөдөлгөж, дуугаргаж, үнэрлэж, нугалж үзэх, хатуу, зөөлөн ялгааг биеэр мэдрэх	Аюулгүй байдлыг хангаж, хүүхдийн хийж буй үйлийг чиглүүлэх: энийг дарахад юу мэдэрч байна вэ?, энэ нугарах уу?
Тайлбарлах, ойлголтоо илэрхийлэх үе шат	Харьцуулах ба нэрлэх	Хоёр зүйлсийг харьцуулж Энэ хатуу, энэ зөөлөн гэсэн богино өгүүлбэрээр хариулна.	2 эд зүйл үзүүлж “энэ хоёрын алин нь зөөлөн бэ? гэж асууна.

Нарийвчлан судлах, дүгнэх үе шат	Таньж мэдсэн зүйлээ зориулалтаар ашиглах	Эд зүйлийг ангилж, хайрцагт хийнэ. Үгээр болон үйлдлээр өөрийн ойлголтоо илэрхийлнэ.	Хоёр хайрцагт эд зүйлийг Хатуу, зөөлнөөр ангилж хийх даалгавар өгнө. Хүүхдүүдийн сонголтыг ажиглаж, зөв хариултыг бататгана.
----------------------------------	--	--	--

Тайлбар: Шинжлэн судлах арга зүй нь хүүхэд хүрээлэн буй орчноо мэдрэхүй, хөдөлгөөн, туршилт, ажиглалтаар танин мэдэх, ингэхдээ асуулт тавих, ямар учиртай вэ гэж сонирхох, хариуг өөрийн туршлагаар олох үйл явц тул хүүхдэд эд зүйлсийг үзүүлэхдээ “Хүрээд үз, ямар байна вэ, нугарч байна уу, зөөлөн мэдрэгдэж байна уу гэх мэтээр аливаа зүйлийг ажиглан өөрийн гараар туршиж үзэх боломж олгоно. Багшийн зүгээс хүүхдийн сонирхлыг ажиглах, Өөрөөр яаж үзэх билээ?, Хатуу аяга, зөөлөн даавуу хоёр юугаараа ялгаатай вэ? гэх мэтээр дахин судлах туршилтад чиглүүлэх, Бид юу олж мэдсэн бэ? гэж ярилцан дүгнэлт хийлгэнэ. Хүүхдийн хэлсэн санааг багш бататган үгийг зөв хэллэгээр давтаж өгөх хэрэгтэй. Хэрэв хүүхэд ихээр сонирхож байвал тухайн эд зүйлсийг Ангийнхаа туршилтын тавиур дээр тавьж дахин судлуулж болно.

Төсөлд суурилсан арга зүй: Үе тэнгийнхэн эсвэл бусадтай харилцах, суралцах үйл явцад төвлөрдөг бөгөөд дараах зорилготой.

- Хамтдаа суралцах, багаар ажиллах, харилцаа холбоог чухалчилдаг.
- Багш бүх үйл ажиллагаанд чиглүүлэн оролцдог.
- Бодит амьдрал дээрх сорилт, асуултууд дээр суурилдаг.
- Нээлттэй, үр дүн нь урьдчилан тодорхойлогдоогүй шинэ зүйл байдаг.

Төсөлд суурилсан арга зүйгээр сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахдаа багш Та дараах санааг анхаараарай.

- Бодитой байх: Хүүхэд өдөр тутамд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэхийг зорьж, мэдлэгээ бодит байдалд ашиглах, хэрэглэх чадварыг нэмэгдүүлдэг.
- Нотолгоонд суурилсан байх: Хүүхдээс асуулт асуух, судлахад дэмжлэг үзүүлэхэд суурилах нь сониуч зан, шүүмжлэлтэй сэтгэх чадварыг хөгжүүлдэг.
- Хугацааг төлөвлөх: Богино, дунд, урт хугацаагаар хэрэгжүүлэх боломжтойгоор төлөвлөх нь хүүхдэд дахин судлах, эрэл хайлт хийх, сонирхох, ярилцах зэрэг үр чадварыг хөгжүүлэх боломжийг олгодог.
- Хүүхэд төвтэй байх: Хүүхдүүд хамтран юу судлахаа шийдэх нь тэдний сониуч занг өдөөж, мэдэх, хийх хүсэл эрмэлзлийг төрүүлж, оролцоо, урам зориг өгдөг.
- Нэгдмэл байх: Сургалт, үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн сургалтын чиглэлүүдийг нэг цогц болгон нэгтгэдэг.
- Өөрийгөө удирдах: Хүүхэд суралцахуйн явцдаа өөрийгөө хянах, хариуцлага хүлээх чадварт суралцаж эхэлдэг.
- Хамтын ажиллагаатай байх: Хүүхдүүд бусадтай ярилцаж, хамтрах, туслах, дэмжих замаар асуудлыг шийдэж, харилцах чадварын эхлэл тавигддаг.
- Түүнчлэн хүүхдүүдийн харилцан ярилцлага, тоглоомын явцад гарсан санаа зэргийг баримжаалан сэдэв, санааг гаргаж болно.

Хүснэгт 10. Төсөлд суурилсан арга зүйг хэрэгжүүлэх багшлахуй, суралцахуй

Суралцахуй	Багшлахуй
<p>Ажиглах, турших:</p> <ul style="list-style-type: none"> - Байгальд гарсан өөрчлөлт (ургамал, цаг агаар гэх мэт)ийг ажиглах - Туршилт (барих, үнэрлэх, амтлах өөрөө 	<p>Сонирхлыг өдөөж, сэдэлжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Асуудал дэвшүүлж, “Энэ юу вэ?” гэх мэт асуултаар өдөөх - Хүрч мэдрэх боломжийг олгох (барьж,

<p>хүртэж мэдрэх)</p> <ul style="list-style-type: none"> - Хүн, амьтан, юмсын үйлдлийг ажиглах - Бодит орчныг ажиглах <p>Тоглох:</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэд өөрөө хийж үзэх, бусдын дэмжлэгтэй, даган дуурайж, бие даан тоглох - Дүрсэлж үзүүлэх тоглоом (амьтны хөдөлгөөн дуу авиаг дуурайх) - Барьж бүтээх тоглоом - Судалж буй агуулгад тохирсон хөдөлгөөнт, хөгжимт тоглоом тоглох <p>Бүтээх, урлах:</p> <ul style="list-style-type: none"> - Зурах, наах, зохион бүтээх - Байгалийн болон дахин боловсруулах материалаар бүтээл хийх - Шавар, элсээр бүтээх - “Энэ юу вэ? хаана байна вэ?” гэх мэт асуулт асуух - Бусдыг даган дуурайх, асуусан асуултад үйлдлээр хариулах, заах, нэрлэх - Төсөлтэй холбоотой дуу, шүлэгт суралцах <p>Төслийн үр дүнг танилцуулах:</p> <ul style="list-style-type: none"> - Хийсэн бүтээлээ харж баярлах - Хийсэн зүйлээ бусдад үзүүлэх - Баярлаж буйгаа үйлдлээр илэрхийлэх - Хамтдаа үзэсгэлэн гаргах - Хамтын бүтээлээ бусдад үзүүлэх 	<p>тэмтрэх, үнэрлэх, амтлах)</p> <ul style="list-style-type: none"> - Сэдэвт тохирсон ном, зураг, бодит материал ашиглан сонирхлыг нэмэгдүүлэх <p>Төслийн үе шат бүрд чиглүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - багш эхлээд биечлэн хийж үзүүлэх, хамтдаа хийх боломжийг олгох, чиглүүлэх - хүүхэд оролцох боломжтой зүйлийг өөрөө хийж, туршиж үзэхэд чиглүүлэх - Цаг хугацаа болон орчныг зөв зохион байгуулах <p>Хүүхдийн оролцоог дэмжих</p> <ul style="list-style-type: none"> - туршиж үзэх, өөрөө хүрч мэдрэх боломжийг олгох - Алдах, дахин оролдох үйлийг дэмжих - Хийсэн зүйлийг магтах, бүтээлч байдлыг дэмжих - Нэрлэсэн үгийн нөөцийг нэмэгдүүлэх, шинэ үг хэлж сурахад чиглүүлэх - Зурагт ном, зурган зааварчилгааг заах, нэрлэх, үйлдлээр илэрхийлэх оролдлогыг дэмжих <p>Хөгжлийг дэмжих, урамшуулах</p> <ul style="list-style-type: none"> - Туршилт, ажиглалт хийх орчин бүрдүүлэх (ус, элс, байгалийн материал) - Хөдөлгөөн оролцсон үйл ажиллагаа төлөвлөх - Зурах, барих, өрөх, хөдөлгөөн хийхэд дэмжих - Хүүхдийг ажиглаж тэмдэглэх - эцэг эх, асран хамгаалагч, багш хамтран хүүхдийн бүтээлийг танилцуулах, үзэсгэлэн гаргах, бусадтай хуваалцах
--	--

Хүснэгт 11. Төсөлд суурилсан арга зүйн хувилбар

Үйл ажиллагааны нэр	Хэрэглэгдэхүүн	Суралцахуйн үр дүн
Усны шинж чанарыг танин мэдье Хугацаа: 7 хоног	Тунгалаг шилэн сав, аяга, ус, жижиг сав, юулүүр, мөс, халуун, хүйтэн ус, соруул, Цаас, бийр, усан будгийн багц, усны зураг, усны амьтад	БНО2.1г.Байгалийн үзэгдлийг ялгаж таних, ажиглаж ярилцана. ХЯ2.2в.Юмсын өнгө,хэмжээ, байрлал заасан үгээр ярина. ЗУ2.2а.Зураас дүрсээр өөрийн бодол төсөөллөө илэрхийлнэ.
Суралцахуйн үйлүүд	Үйл ажиллагаа	Багшлахуйн дэмжлэг
Ажиглах	Цэвэр ус, бохир ус, мөс, буцалж буй ус, өнгөт усыг ажиглана. Усны өнгө, үнэр, хэлбэр, хөдөлгөөнийг анзаарна. Ус урсаж, дусалж байгааг сонсоно.	Ус ямар өнгөтэй байна вэ?, Хүйтэн байна уу?, урсаж байна уу,? уур гарч байна уу? , урсаж байна уу? гэсэн асуултаар хүүхдийн анхаарлыг төвлөрүүлнэ. Багшийн асуулт: Яагаад ус халуун байна вэ?, Яагаад ус хүйтэн байна вэ?
Турших	Урсаж байгаа мөн хүйтэн усанд гараа дүрэх, мөс барих, ус халуун, хүйтэн үед ямар	Ямар зүйл живж байна вэ?, яагаад мод хөвж байна вэ? асуулт тавьж аюулгүй орчин бүрдүүлэн хүүхдээр

	байдлаар өөрчлөгдөхийг харна. Усанд өнгө нэмж үзнэ, хөвдөг, живдэг зүйлсийг туршина.	үйлдэл хийлгэнэ.
Тоглох	Ус юүлж, хувингаар зөөж, шанагаар хутгаж, аягалж, шилэн дотор хийх, хоолойгоор ус урсгаж тоглох. Хөөс, саван ашиглан тоглох.	Хүүхдийг чөлөөтэй оролцуулан тоглуулах орчин бүрдүүлэх, усаа юүлье, хөөс болгон үлээе, ус хувингаар зөөцгөөе, хоолойгоор урсгаж тоглоё гэх мэт оновчтой үгээр чиглүүлэх.
Бүтээх, урлах	Гол, горхины ус будах, усны дусал будах, хөөсөөр үүл наах, бороотой өдөр гэх мэт сэдэвт зураг зурах.	Төрөл бүрийн материалаар туршиж, өөрийн санаагаар бүтээж урлахыг сэдэлжүүлэх. Загвар зурж, дүрсэлж чиглүүлэх. Багшийн үүрэг: ажиглагч, чиглүүлэгч, орчныг бэлдэгч, хамтран тоглогч, туршигч.
Төслийн үр дүнгээ танилцуулах	Өөрийн бүтээл, туршилтаа найзууддаа үзүүлж нэрлэх, туршилтаа өөрийн үгээр тайлбарлах оролдлого хийх.	Чи юу хийсэн бэ?, Яагаад ингэж бодсон бэ? гэх мэтээр асууж хэл яриагаар өөрийгөө илэрхийлэхийг дэмжиж чиглүүлэх.

Уг төсөлд ажлаар усны шинж чанарыг туршиж мэдэх, хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх, байгальтай харилцах зөв дадлыг төлөвшүүлэх зорилготой. Багш нь хүүхдийг ажиглах, чиглүүлэх, аюулгүй орчныг бүрдүүлэх, дэмжих, бие даан турших, тоглох боломж олгох үүрэгтэй. Ажиглах, турших, тоглох, бүтээх, хийсэн зүйлээ танилцуулах нь хүүхдийн үүрэг юм. Төслийн үе шат нь 3-5 өдөр үргэлжилж болно. Энэ насны хүүхдийн хэл ярианы хөгжил харилцан адилгүй байдаг тул үг, дохио, зураг, үзүүлэн, бодит материал ашиглан ойлголцоно. Төслийг багшийн идэвхтэй оролцоотой, бүлгээр хэрэгжүүлэх ба биеийн мэдрэмж, мэдрэхүйн туршлага давамгайлсан үйл ажиллагаа байхад багш нар анхаарах хэрэгтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- IX САР

ШИНЭ ОРЧИН

Хүүхдийн эзэмших чадамж:

Харилцах: Хүүхэд өөрийгөө илэрхийлэх, сонсох, бусдад ойлгуулах, бусадтай хамтран тоглох, сонирхсон зүйлээ биеийн хэлэмжээр илэрхийлэхийг эрмэлзэх.

Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил: Дуу хоолой, үг, дохио зангаа, үйлдлээр өөрийгөө илэрхийлэх;

Аюулгүй байдлын зөвлөмж:

Хүүхдийг гүйхгүй, холдож төөрөхгүй байхаар ойрхон хүрээ үүсгэж гадаа талбайд тоглуулна. Хурц ирмэгтэй зүйл хүүхдийн гарт өгөхгүй. Навч, чулуу зэрэг аюулгүй байгалийн зүйлсийг л ашиглана.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Энгийн асуултад хариулахыг эрмэлзэх, танил тоглоомын нэрийг давтан хэлнэ.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Өдрийн үйл ажиллагаанд дасан зохицож, сонирхож оролцох, тоглох, хөгжимт хөдөлгөөнийг даган дуурайх үйлийг нь урамшуулан дэмжинэ.

Зугаалга:

- Гадна талбайд энгийн ажиглалт, хөдөлмөр, тоглох үйлд даган дуурайж оролцоно.

Номын цаг:

Номын хуудас эргүүлэх, дараагийн хуудсан дээр юу гарах бол? гэж сонирхлыг татах, анхаарал сарних үед богино завсарлага, хөдөлгөөн хийнэ

Хөгжөөн баясах цаг:

- Энгийн зааврыг ойлгож, хөгжөөнт тоглоомд хамтран оролцоно.

Боломжууд:

Хамтын үйл ажиллагаанд сонирхлыг татаж оролцуулах, анхаарал сарних үед богино завсарлага авах.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
БНО1.2в. Гэрт болон ангидаа эд зүйлсийн байрлалыг мэдэж, багшийн өгсөн энгийн зааврыг биелүүлнэ. ХЯ1.2в. Танил эд юмсыг нэрлэнэ.	<ul style="list-style-type: none"> - Анги болон гэрийн орчинд энгийн зааврыг ойлгож, дагаж биелүүлэх. - Танил орчны юмс, тоглоом, эд зүйлс, амьтны нэр, энгийн үйлдэл зэргийг нэрлэх, 	Бидний тоглоом
ХӨГ1.1в. Дуу, аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийнэ. ХЭМ1.1а. Гарын сарвууг атгах, тэнийлгэх, сэгсрэх, базах хөдөлгөөнийг жижиг тоглоом, эд зүйл ашиглан тоглож гүйцэтгэнэ.	<ul style="list-style-type: none"> - Энгийн үйл илэрхийлсэн дууны үгийг дагаж хөдөлгөөн хийх. - Гарын сарвууг атгаж тэнийлгэх, чангалж суллах дасгал хийх. 	Ажилсаг гар

9 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Бидний тоглоом	Тойргийн цаг	Энгийн зааврыг ойлгож, дагаж биелүүлж энгийн үйлдэл хийнэ. Танил тоглоом, эд зүйлсийг нэрлэнэ.	Танил тоглоомууд (машин, бөмбөг, баавгай) Сагс эсвэл хайрцаг.	Энэ юу вэ? Энэ ямар тоглоом бэ? Машин яаж дуугардаг вэ? Бөмбөг ямар өнгөтэй байна вэ?	Харилцах: өдөр тутмын үйлдэлд өгсөн зааврыг анхааран сонсох, ойлгох, давтаж хэлэх, дуурайн гүйцэтгэх;	Энгийн зааврыг ойлгож дагадаг.
	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Тоглоом, эд зүйлсийг нэрлэж, энгийн зааврыг дагаж үйлдлээр биелүүлнэ.	Танил тоглоомууд (машин, бөмбөг, баавгай)	Машиныг чирч явуулж надад авчирч өгөөрэй. Бөмбөгийг толгой дээрээ барьж зогсоорой. Баавгайг тойрч мөлхөөрэй.	Бүтээлчээр сэтгэх: анхааран сонсох, заах, нэрлэх	Бусдын өгсөн зааврыг ойлгон биелүүлдэг.
	Номын цаг	Танил тоглоомыг номын зургаас зааж нэрлэж үйлдлийг даган дуурайна.	Том зурагтай, товч өгүүлбэртэй ном, Номтой холбоотой жижиг тоглоом (амьтан, машин, бөмбөг)	Энэ юу вэ? “Энд юу байгаа бол?” “Энд ямар амьтан байна вэ?” “Энэ ямар өнгөтэй байна вэ?” Энэ юу вэ? Машин уу? “Машин ямар дуу гаргадаг вэ?” “Баавгай юу хийж байна?” “Чи баавгай шиг алхаж чадах уу?” “Бөмбөг ямар өнгөтэй вэ?” “Бөмбөгийг өнхрүүлдэг, тийм үү?”	Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил: Дуу хоолой, өнгө аяс, сэтгэл хөдлөлийг ялган мэдэрч, үг, дохио зангаа, үйлдлээр өөрийгөө илэрхийлэх;	Танил тоглоомыг номын зургаас заадаг.
	Хөгжөөн баясах цаг	Нуусан тоглоом, эд зүйлсийг хайж олж, нэрлэж тоглоно.	Танил тоглоомууд (машин, бөмбөг, баавгай)	Ногоон бөмбөг хаана байна? Гүйж олоод сагсанд хийгээрэй! “Баавгайг хай! Олоод над дээр авчирч өгөөрэй.	Хамтран ажиллах: Бусдын санааг анхаарч сонсох, хамтын үйл ажиллагаанд насанд хүрэгчдийн дэмжлэгтэй оролцох	Амьтан, эд зүйлийг ялгаж, нэрлэдэг.
Миний хөөрхөн гар	Зугаалга	Сарвууг тойргоор эргүүлэх, хооронд нь	Навч, хөнгөн шүүр, хуванцар хавчуур	Энэ навч ямар өнгөтэй вэ? Жижиг үү? Том уу?	Суралцахууд суралцах: Сонсох, дуурайж	Жижиг тоглоомыг эрхий

		үрэх дасгал давтах, гар		Хатуу юу? Зөөлөн үү? гараараа илж үзээрэй. Гараар илэхэд ямар санагдаж байна?	давтах	хуруу, алгандаа атгаж авдаг.
	Хөгжөөн баясах цаг	Энгийн үйл илэрхийлсэн дууны үгийг дагаж хөдөлгөөн хийх, сарвууг тойргоор эргүүлэх, хооронд нь үрэх дасгал давтах	Хэмнэлтэй ая, бичлэг	Аялгууны хэмнэлд тохируулан, аяыг мэдэрч дууны үгийг дагаж дуурайж хөдөлгөөнийг хийгээрэй.	Харилцах: Бусдын үгийг хүлээж авах, ойлгох, үг үйлдлээр өөрийгөө илэрхийлэх;	Дуу, ая, аялгууг мэдэрч энгийн үйлийг биеэр илэрхийлдэг.

Албан хэрэгцээнд

9 дүгээр сарын I долоо хоног

БИДНИЙ ТОГЛООМ

Шинэ үг: Тоглоом

Үйл ажиллагаа 1. Танил тоглоом (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Танил тоглоомууд (машин, бөмбөг, баавгай) сагс эсвэл хайрцаг.

Аргачлал: 2–3 танил тоглоомыг урдаа тавина. Танил орчны юмс, тоглоом, эд зүйлсийг нэрлэнэ.

Хүүхэд хэлж чадахгүй бол багш тоглоомын нэрийг дагуулан давтан хэлүүлнэ.

“Машиныг надад өгөөч.” “Улаан бөмбөгийг ав.” “Баавгайг сандал дээр суулгаарай гэж ангийн орчинд энгийн зааврыг ойлгож, дагаж биелүүлнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ юу вэ?
- Энэ ямар тоглоом бэ?
- Машин яаж дуугардаг вэ?”
- Бөмбөг ямар өнгөтэй байна вэ?

Үйл ажиллагаа 2. Гүйж аваад ир (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Танил тоглоомууд (машин, бөмбөг, баавгай)

Аргачлал: Тоглоомуудыг өрөөний нэг талд тавина. Хүүхдийг эсрэг талд зогсооно. Багш ангийн үгэн зааврыг өгнө. Машиныг чирч явуулж надад авчирч өгөөрэй. Бөмбөгийг толгой дээрээ барьж зогсоорой. Баавгайг тойрч мөлхөөрэй.

Үйл ажиллагаа 3. Зурагт ном (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Том зурагтай, товч өгүүлбэртэй ном, номтой холбоотой жижиг тоглоом (амьтан, машин, бөмбөг)

Аргачлал: Хүүхдүүд ээ, өнөөдөр бид нэг ном үзэж уншина. Номоо өндөр өргөөд: Энэ юу вэ?

“Энд юу байгаа бол? Амьтан байж магадгүй гэж ярьж номын нүүрийг хүүхдүүдэд харуулна.

“Энд ямар амьтан байна вэ?”

“Энэ ямар өнгөтэй байна вэ?” Хүүхдүүдтэй хамт ярилцана. Номын хуудас бүрийг удаанаар, тод дуугаар уншина. Хуудас бүр дээр баавгай, бөмбөг, машиныг нэрлүүлнэ. Энэ юу вэ? Машин уу?” “Машин ямар дуу гаргадаг вэ?” “Баавгай юу хийж байна?” “Чи баавгай шиг алхаж чадах уу?” (хүүхдүүд дуурайж хөдөлнө) “Бөмбөг ямар өнгөтэй вэ?” “Бөмбөгийг өнхрүүлдэг, тийм үү?” бөмбөгийг гараар өнхрүүлж хамтдаа тоглох.

Үйл ажиллагаа 4. Хаана байгаа вэ? (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Танил тоглоомууд (машин, бөмбөг, баавгай)

Аргачлал: Танил тоглоомыг харагдахуйц газарт (ор, сандал, ангийн эд зүйлийн ард) нууна. Багш ангийн үгэн зааврыг өгнө.

“Ногоон бөмбөг хаана байна? Гүйж олоод сагсанд хийгээрэй!” “Баавгайг хай! Олоод над дээр авчирч өгөөрэй.”

Энгийн зааврыг биелүүлж, хүүхэд хайж тоглоомыг олох даалгавраа биелүүлнэ.

9 дүгээр сарын II долоо хоног

МИНИЙ ХӨӨРХӨН ГАР

Шинэ үг:

Үйл ажиллагаа 1. Гараа угаая (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хэмнэл, хөгжилтэй ая, бичлэг

Аргачлал: Аялгууны хэмнэлд тохируулан, аяыг мэдэрч дууны үгийг дагаж дуурайж хөдөлгөөнийг хийнэ.

Савангаа авья аа-шур шур шур

Гараа үрье ээ-үр үр үр

Хөөс үүснэ-пүн пүн пүн

Цэвэрхэн болно оо-ля ля ля

Хөдөлгөөн:

- Саван авья, гараа үрье, хөөс үүсгэе, гараа угаая ангийн үг хэллэгийг хэлнэ.

- Гараа угаая - гарын алга, ар, салаа, хуруу, бугуйг угаах хөдөлгөөн хийнэ.
- Савангаа түрхээд үрье ээ - савангаа авах, гараа үрэх хөдөлгөөн хийнэ.
- Цэвэрхэн гоё болжээ - гоё гоё гоё гээд гараа дээш өргөн хөдөлгөнө.
- Гоё гоё гоё гэж давтаж хэлнэ.

Шинэ үг: Навч, хатуу, зөөлөн

Үйл ажиллагаа 2. Ажилсаг гар (Зугаалгын цаг)

Хэрэглэгдэхүүн: Навч, хөнгөн шүүр, хуванцар хавчуур

Аргачлал: Бяцхан навч хүүхдүүдээ, өнөөдөр бид навчийг ажиглая. Хүүхэдтэй хамт навчаас 1–2 ширхэг авч харна.

- Энэ навч ямар өнгөтэй вэ? (ногоон, шар гэх мэт)
- Жижиг үү? Том уу?
- Хатуу юу? Зөөлөн үү? гараараа илж үзээрэй.
- Гараар илэхэд ямар санагдаж байна? Хүүхдүүд навчийг агаарт өргөж хийсгэж тоглоно.

Бяцхан цэвэрлэгч хүүхдүүдэд жижиг, хөнгөн шүүр эсвэл хуванцар хавчуур өгнө. Навчийг жижигхэн хавчуураар чимхэж авч ,навчнуудыг нэг газарт цуглуулна. Овоолсон навчийг саванд хийнэ.

Өндөр зам тоглоом: Багш “Автобус маань өндөр уулан дээгүүр гаръя” гэхэд гараа дээш өргөнө. Тоглогч хүүхдүүд гараа дээш өргөнө, гараа доош буулгана. Хөгжмийн хэмнэлд давтана. Багш “Автобусны дугуй эргэлээ, бугуйгаа эргүүлэе” гэхэд хүүхдүүд бугуйгаа хоёр тийш тойруулан эргүүлнэ. Аялгууны хурдад тохируулан хөдөлгөөнөө удаан, хурднаар хийнэ.

Сонсьё, дэмжье/ Туслалцаа:

Хүүхэд бусадтай хөдөлгөөн хийх, тоглох үйлдлүүдэд дэмжиж урамшуулах ярилцах

Хүүхдийг ажиглаж, сонирхсон тоглоомоор тоглуулах

Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг оролцоо:

Цэцэрлэгт дасан зохицоход багшаас зөвлөмж авах, үйл ажиллагаанд хамтран оролцож дэмжих; Шинээр сурсан дуу, хөгжимт хөдөлгөөнийг давтаж бататгах.

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./

Амжилттай хэрэгжүүлсэн:

Сул хэрэгжүүлсэн:.....

Цаашид сайжруулах:.....

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - X САР

ТАНИЛЦЬЯ

Хүүхдийн эзэмших чадамж:

Харилцах: Хүүхэд энгийн үг, дохио зангаагаар өөрийгөө илэрхийлэх, өдөр тутмын үйлдэлд өгсөн зааврыг анхааран сонсох, ойлгох

Хамтран ажиллах: Бусдын тоглохыг ажиглах, хамтрагч болох, тоглохдоо дүрэм дагах, тоглоомоо хураах

Бүтээлчээр сэтгэх: Дүрд тоглох, мэддэг эд юмсыг бие даан эвлүүлэхийг оролдох

Суралцахуйд суралцах: Анхааралтай сонсох, дуурайж давтах, өөрийгөө илэрхийлэх

Шүүн тунгаах- орчны дуу чимээг ялгах

Аюулгүй байдлын зөвлөмж:

Багш хүүхдийг дулаан, эерэг харилцаагаар угтаж, айж эсвэл уйлах үед нь тэвчээртэй, тайван байдлаар дэмжинэ. Хүүхэд өөрийн орон зайгаа ойлгож, бусдын зайг хүндэтгэн мөргөлдөхгүйгээр тоглох, хамтдаа оролцохыг чиглүүлнэ.

Хүүхдэд сэтгэл хөдлөлөө чөлөөтэй илэрхийлэх боломж олгож, тайвшрахад нь туслах арга (гүн амьсгал авах, тайван хөгжим сонсох) санал болгоно.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Өөрийгөө танилцуулах, нэрээ хэлэх, бусадтай харилцахад тусална. Биеийн эрхтнээ зааж нэрлэх, үйлдлийг дуурайх чадварыг дэмжээрэй.

Чиглүүлэгтэй, тоглоом, үйл ажиллагаа:

- Хүүхдүүд дуу дуулах, өрж байгуулах тоглоомыг хамтран тоглох, биеийн хөдөлгөөнийг даган дуурайж байгааг урамшуулан дэмжинэ. Хүүхдийн хүсэл сонирхлыг харгалзан тоглох боломжийг олгож ярилцана.

Зугаалга:

- Цэцэрлэгийн орчинтой танилцаж, ажиглалт хийх, хамтдаа навч түүж тоглоход чиглүүлж дэмжинэ.

Номын цаг:

- Бусдын яриаг сонсох, ажиглах чадварыг дэмжих, номын хуудсыг эргүүлж үзэх, үлгэр, зохиолыг хамтдаа сонсох дадалтай болно.

Хөгжөөн баясах цаг:

- Хүүхдүүд хормогчин болон ширээний театрт дүрд тоглож, бүтээлчээр оролцох бие даасан үйлийг дэмжинэ. Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, бусдын үйлийг ойлгож хүлээцтэй байхад тусална

Боломжууд:

Хүүхдийн сэтгэл хөдлөлд эерэг хариу үйлдэл үзүүлэн тайвшруулах, асуулт асууж ярилцана.

Хүүхдүүд тоглоомоо булаацалдах, муудалцах үед аль болох өөрсдөөр нь шийдвэрлүүлж бие биеэ ойлгодог болоход тусална.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
НСХ1.1а. Биеийн зарим мэдрэмжээ нүүр, гар, биеийн хөдөлгөөн, дуу авиа, үгээр илэрхийлдэг болно. ХЯ1.1а. Бусдын яриаг сонсоод ойлгосноо үг үйлдлээр илэрхийлнэ. БНО1.2а. Өөрийн нэр, нас, бие, эрхтнээ нэрлэж, тоглоом, эд зүйлсээ танина.	<ul style="list-style-type: none"> - Хоёр гараа үрж, халуу оргиж байгааг мэдэрч илэрхийлэх. (гараа хацартаа хүргэх) - Танил хүмүүсийн үгийг давтаж хэлэх, үйлдлийг дагаж хийх, хийж буй үйлдлийг үгээр илэрхийлэх - Өөрийн нэр, нас, биеийн зарим эрхтнийг нэрлэх, үйлдлээр харуулах, тоглоом эд зүйлсээ ялгаж таних, 	Надтай танилц
ЗУ1.2е. Өрж байгуулах, эвлүүлэх аргаар тоглоом, эд юмсыг бусдын дэмжлэгтэй бүтээнэ. МАТ1.3в. Юмсын байршлыг танина. (дээр, доор)	<ul style="list-style-type: none"> - Өрж байгуулах тоглоомыг давхарлан өрөх - Өрж байгуулах тоглоом, эд юмсыг байранд нь хураах - Тавиур ширээний дээр, доор байгаа бодит юмсыг нэрлэх 	Миний цэцэрлэг
ХЭМ1.1г Байрандаа болон чиглэлээ өөрчилж алхаж, гүйнэ. ХЭМ1.1е Дөрвөн хөллөж 20 см-ын зайтай зураас хооронд мөлхөнө НСХ1.3б. Бусад хүмүүс ижил зүйл хийж байгааг ажиглаж мэддэг болно.	<ul style="list-style-type: none"> - Гар гараасаа хөтлөлцөн байрандаа болон тойргоор алхах - 2-3 м зайд байрлуулсан тоглоом хүртэл найзтайгаа уралдаж мөлхөх - “Эхлээд би, дараа нь чи” гэсэн өөрийгөө хянах, дараалал ойлгох төрөл бүрийн тоглоом тоглох; 	Би өөрөө

<p>ХЭМ1.1а. Гарын сарвууг атгах, тэнийлгэх, сэгсрэх, базах хөдөлгөөнийг жижиг тоглоом, эд зүйлийг ашиглан тоглож гүйцэтгэнэ. ХӨГ1.1в Дуу, аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Гарын сарвууг атгаж нийлүүлэх, чангалж суллах дасгал хийх, бөмбөг, зөөлөн тоглоом ашиглан базах, савлах, хөдөлгөөнийг дагаж хийх - Хөгжимт хөдөлгөөнийг сонсоод даган дуурайж хийнэ. 	<p>Намайг дуурай</p>
<p>ХЯ1.3а.Номыг сонирхож үзнэ. БНО1.1в. Ойр орчны эд зүйлс, тоглоомыг мэдэрч нэрлэнэ</p>	<ul style="list-style-type: none"> - Номын хуудсыг эргүүлж, амьтан, өнгө, эд зүйлийн зургийг ажиглаж, хуруугаар заах, нэрлэх, нэрлэсэн зүйлийг олох - Өдөр тутам хэрэглэдэг зүйлсийн зурган карт, тоглоом зэргийг ажиглан таних, заах, нэрлэх 	<p>Номтой танилц</p>
<p>ХӨГ1.1б. Дууг анхааралтай сонсож, зарим үг, авиаг дуурайн хэлж, аялна. ХӨГ1.1в. Дуу, аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийнэ. ХЯ1.1а. Бусдын яриаг сонсоод ойлгосноо үг, үйлдлээр илэрхийлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Бусдын дуулж байгааг хараад дагаж аялах оролдлого хийнэ - Багш хүүхэд хамтдаа дууны аянд чөлөөтэй хөдлөж хөгжимт тоглоомоор тоглож хөгжилдөх - Энгийн үйлийг илэрхийлсэн дууны үгийг дагаж хөдөлгөөнийг хийх 	<p>Хөгжилтэй дуу</p>

10 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Надтай танилц	Тойргийн цаг	Бөмбөг дамжуулан нэр, нас болон бие эрхтнээ нэрлэж, үйлдлээр харуулж, танилцана. Тухайн өдөр хийх зүйлсийг танилцуулна.	Бөмбөг, шаар; биеийн хөдөлгөөн болон эд зүйлстэй зурагт хуудас.	Хүүхэд бүрийн оролцоог дэмжиж, хүлээцтэй сонсоно.	Харилцах: биеийн хэлэмж, хэл яриагаар санаагаа илэрхийлэх	Нэр, нас, бие эрхтнээ нэрлэдэг.
Энэ юу вэ?	Тойргийн цаг	Багш бие эрхтнээ зааж асуухад хүүхдүүд зааж нэрлэнэ. Хүүхдүүд хоорондоо бие эрхтнээ нэрлэж тоглох, өдрийн үйл ажиллагааны талаар ярилцана	байхгүй	Энэ юу вэ? (Бие эрхтнийг зааж асуух).	Харилцах-Өөрийн санаа, хэрэгцээг дохио зангаа, богино үгээр илэрхийлэх	Нэр, нас, бие эрхтнээ нэрлэдэг
Чимээ чагнаа	Хөгжөөн баясах цаг	Цаг, утас, машины дуу чимээг сонсож ялгах, дуурайх. Сонссон дуу чимээг зурагт хуудас дээр заах.	Зурагт хуудас, Цаг, утас, машины дуу чимээний бичлэг	Юу дуугарч байна бэ?.	Шүүн тунгаах- чимээ ялгах,	Дуу чимээг сонсож дуурайдаг.
Гадаа тоглоцгооё	Зугаалга	Цэцэрлэгийн орчин, барилга, мод, цэцэг зэргийг ажиглаж ярилцах. "Навчаа олъё" тоглоомоор навч цуглуулж, өнгө, хэмжээгээр ялган дээр доор байрлуулж тоглох,. хувцсаа бие даан гэвж цэвэрлэх	Цэцэрлэгийн орчин	Ажигласан зүйлсийнх нь талаар асууж, давтан хэлүүлэх.	Харилцах.-байшин барилга орчны ажиглан ярилцах	Ажиглалт.
Эвлүүлж бүтээе	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өрж байгуулах тоглоомоор дээр доор байрлуулах талаар ярилцах, бүтээлээ танилцуулах.Тоглоомоо өнгөөр ялган сагсанд хураах.	Өрж байгуулах тоглоом, өнгөт савх, LEGO, модон блок.	Чи ямар өнгөтэй тоглоом сонгосон бэ?; Чи юу урлаж байна вэ?; Дээр доор хэрхэн байрлуулсныг асууна.	Бүтээлчээр сэтгэх-мэддэг эд юмсыг бие даан эвлүүлэхийг оролдох, Хамтран ажиллах-хамтдаа тоглоомоо хураах	Өрж байгуулах, эвлүүлэх аргаар тоглоом, эд юмсыг бүтээдэг.

Намайг дага/бие угаадаг/мөлхө ө жаал/	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд цагариг дотор зогсож, бусдад саад болохгүйгээр орон зайгаа мэдрэх. Хөгжмийн аянд багшийн дохиогоор алхах, зогсох, суух үйлдлийг хийх, 4 хөллөн мөлхөх,	Цагариг, хөгжмийн ая, зөөлөн тоглоом, мөлхөлтийн нум, бөмбөг.	Багшийн дохио: алхаарай, зогсоорой, суугаарай, бяцхан хүүхдүүд мөлхөөрэй, нүдээ аниарай	Хамтран ажиллах-бусдын тоглохыг ажиглах, дүрэм дагах	Чиглэлээ өөрчлөн мөлхдөг.
Намайг дуурайгаарай	Өглөөний дасгал	Гарын сарвууны хөдөлгөөнийг олон хувилбартай зохиомжлон (атгах, тэнийлгэх, алгаа таших) тогтмол давтаж хийх.	Удаан хэмнэлтэй хөгжмийн ая.	Багшийн үгэн тайлбарын дагуу хийх	Харилцах бусдын үгийг хүлээж авах, ойлгох, үг үйлдлээр өөрийгөө илэрхийлэх	Багшийн зааврыг ойлгодог эсэх.
Цэвэрхэн гар	Хөгжөөн баясах ажил	Гар угаах дарааллын үйлдлийг (норгох, савандах, хөөсрүүлэх) даган дуурайх. Шоог ээлжлэн хаяж, буусан зургийн хөдөлгөөнийг хийх.	Том шоо (гар угаах дарааллын зурагтай).	Үйлдлийг даган дуурайх	Суралцахуйд суралцах- эрүүл ахуйн дадал хэвшүүлэх, Хамтран ажиллах- ээлжлээ хүлээх.	Ажиглалт-идэвхтэй оролцоог дэмжих
Номын хуудас	Номын цаг	Номын төвөөс ном сонгон, барих, хуудсыг нэг нэгээр эргүүлж үзэх. Зургуудыг ажиглаж, хамтдаа ярилцах	Зурагт ном, дэр, жижиг сандал.	Номын гадна талын хуудсыг юу гэж нэрлэдэг бол? Ямар зураг байна?; Дараагийн хуудсанд ямар зураг байна вэ?.	Харилцах-номыг сонирхож үзэх,	Номын хуудсыг эргүүлэх, зургийг дүрсэлж ярьдаг
Хормогчин театр	Хөгжөөн баясах ажил	Хормогчин театрыг ашиглан бие эрхтнүүдийг нааж, нэрлэх, үүргийг тайлбарлах. Хүүхдүүд ээлжлэн тоглож, өөрийн бие дээр зааж дуурайх.	Хормогчин театр.	Ярилцах, даган дуурайх	Харилцах-бие эрхтнээ зааж нэрлэх, багшийн зааврыг ойлгож гүйцэтгэх	Ажиглалт-энгийн үгээр хариулж чаддаг.
Ширээний	Хөгжөөн баясах	Ширээний театр ашиглан	Ширээний театр.	Миний малгай ямар	Бүтээлчээр сэтгэх-	Өөрийн эд

театр	ажил	хүүхэлдэйн дүрд хувирч танилцуулах, хувцасны өнгө, төрлийн талаар ярилцах.		өнгөтэй вэ? Чиний цамц ямар өнгөтэй байна вэ? Хувцасны зургуудыг хараад нэрлээрэй?	дүрд тоглох, Харилцах-энгийн үг, дохио зангаагаар өөрийгөө илэрхийлэх.	зүйлсийн өнгийг ялгадаг.
Өглөөний дасгал/Бүжиглээрэй	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Д.Хоролсүрэнгийн “Өглөөний дасгал” дууны аянд тохируулан дуулж, хөдөлгөөнийг хийх. Хүүхдийн сайн мэдэх, хөгжилтэй аяг сонсож, багштай хамт чөлөөтэй бүжиглэх.	“Өглөөний дасгал” дууны ая. бүжгийн ая.	Чөлөөтэй дуулж, бүжиглэхийг дэмжинэ.	Суралцахууд суралцах-анхааралтай сонсох, дуурайж давтах, өөрийгөө илэрхийлэх	Ажиглалт-Чөлөөтэй бүжиглэдэг.

10 дугаар сарын I долоо хоног

НАДТАЙ ТАНИЛЦ

Шинэ үг: Бие эрхтэн, чимээ

Үйл ажиллагаа 1. Танилцъя (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Бөмбөг, шаар, биеийн хөдөлгөөн болон эд зүйлстэй зурагт хуудас

Аргачлал: Хүүхдүүд тойрог болж зогсоод бөмбөг (эсвэл шаар)-ийг дамжуулна. Бөмбөгийг барьсан хүүхэд өөрийн нэр болон насаа хэлж, дараагийн найздаа дамжуулан танилцана.

Хүүхдүүд бие эрхтний зурагт хуудасны дагуу өөрийн бие дээр зааж нэрлэнэ. Бие эрхтнээ заах тоглохдоо сууж, босох энгийн хөдөлгөөнийг хийж хөгжилдөнө. Багш хүүхэд бүрийн оролцоог дэмжих, хүлээцтэй сонсоно. Тухайн өдөр юу хийх тухайгаа танилцуулна.

Үйл ажиллагаа 2. Энэ юу вэ? (Тойргийн цаг)

Аргачлал: Багш өөрийн бие эрхтнүүдийг зааж “Энэ юу вэ?” асуултад хүүхдүүд хуруугаараа зааж нэрлэнэ. Хүүхдүүд хоорондоо бие эрхтнээ зааж нэрлэх, нэрээ хэлж танилцан, чөлөөтэй тоглоно. Өдрийн ямар үйл ажиллагаа хийх талаар ярилцах, хүүхдийн хүсэл сонирхлыг сонсоно.

Үйл ажиллагаа 3. Чимээ чагнаа (Хөгжөөн баясах ажил)

Аргачлал: Цаг, утас, машины дуу чимээг сонсгоод, “Юу дуугарч байна бэ?” асуултын дагуу ярилцаж, дуугарч байгаа чимээг хамтдаа даган дуурайна.

- Сонссон дуу чимээг ялган зурагт хуудас дээр заана.
- Энэ юу вэ? гэсэн асуултад тухайн эд зүйлсийг нэрлэнэ.
- Сонссон дуу чимээг зурагт хуудаснаас олж, ижил зурагтай давхцуулж байрлуулна.

Хүүхэд найзыгаа хүлээж ээлжлэн тоглоход багш чиглүүлнэ.

МИНИЙ ЦЭЦЭРЛЭГ

Шинэ үг: Дээр, доор

Үйл ажиллагаа 1. Гадаа тоглоцгооё (Зугаалга)

Хүүхдүүд цэцэрлэгийн гадаах талбай, барилга байгууламж, мод, цэцэг, тоглоомын талбай зэрэг зүйлсээс нэгийг нь сонгож ажиглана. Ажигласан зүйлсийнх нь талаар асууж, давтан хэлүүлэх, хуруугаар нь хүрч мэдрүүлнэ.

Хүүхдүүд “Навчаа олъя” тоглоомын явцад навч цуглуулна. Цуглуулсан навчийг өнгө, том, жижиг хэмжээгээр, дээр доор нь байрлуулан тавьж тоглоно. Намар болон навчтай холбоотой дуу дуулж хөгжилдөнө.

Цэцэрлэгтээ орохдоо өөрийн хувцсаа гөвж, гутлаа арчиж орохыг сануулна. Бие даан хувцсаа тайлахад тусална.

Үйл ажиллагаа 2. Эвлүүлж бүтээе (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: өрж байгуулах тоглоом, өнгөт савх, бие эрхтний зургууд, LEGO, модон блок,

Аргачлал: Хүүхдүүд өрж байгуулах тоглоомын хэсгээс сонгох боломж өгнө. Сонгосон зүйлээ дээр, доор хэрхэн байрлуулах талаар ярилцаж, санаагаа хуваалцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи ямар өнгөтэй тоглоом сонгосон бэ?
- Чи юу урлаж байна вэ?

Найзтайгаа хамтдаа давхарлаж өрж тоглох санал гаргах. Өөрсдийн бүтээсэн зүйлээ бусдад танилцуулахад багш дэмжиж дээр доор хэрхэн байрлуулсныг асууна.

Багшийн зааврын дагуу тоглоомоо өнгөөр нь ялган сагсанд хийж, тавиурын дээр болон доор байрлуулна.

Үйл ажиллагаа 3. Өрж тоглоё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Хүүхдүүд өнгөт савхыг барьж, атгаж, гараас гарт дамжуулан мэдэрч тоглоно. Савхны өнгийг зааж нэрлэнэ. Жижиг сагсанд өнгө өнгөөр ялгаж хийнэ. Савхыг зөрүүлж дээр дээр нь өрж тавина.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Яаж өрвөл өндөр байшин болох бол?
- Хэний байшин хамгийн өндөр байна вэ?
- Хамтдаа хамгийн өндөр байшинг барьцгаах уу?

Өнгөт савхыг тэнцвэртэй байрлуулж тогтоох аргыг зааж урамшуулна. Тоглож дуусаад хүүхдүүд өнгийн савхаа хайрцагт хийж, тавиурын дээр доор байрлуулна. Багш хүүхдийн үйлдлийг ажиглаж, шаардлагатай тохиолдолд энгийн загварыг өгч тоглоомыг баяжуулна.

БИ ӨӨРӨӨ

Шинэ үг: Зогсоорой, мөлх, цагариг

Үйл ажиллагаа 1. Намайг дага (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Цагариг, хөгжмийн ая

Аргачлал: Хүүхэд бүр цагариг дотор зогсоно. Гараа алдлан зогсоход бусадтай шүргэлцэхгүй, хэн нэгэнд саад болохгүй талаар тайлбарлан өөрийн орон зайг мэдрүүлнэ.

Хүүхдүүд гар гараасаа хөтлөлцөн цагариганы ард зогсоно. Хөгжмийн аянд багш цагариганы ард/урд/дотор нь алхаарай, зогсоорой, суугаарай гэх мэт дохио өгөхөд хүүхдүүд зааврын дагуу тоглоно.

Хөгжмийн хэмнэлийг хурдан, удаан болгон өөрчилж тоглох үед хүүхэд бүр гүйцэтгэж дуусгахыг хүлээж дараагийн дохиог өгнө.

2. Би угаадаг

Аргачлал: Хөгжимт гимнастикийн дасгалыг даган дуурайж хамтдаа гүйцэтгэнэ. Цахим холбоос 1 ашиглана уу. Багш дасгалыг өөр хувилбараар зохиомжилж болно.

3. Мөлхөө жаал

Хэрэглэгдэхүүн. Зөөлөн тоглоом 3-5 ширхэг, мөлхөлтийн нум, бөмбөг

Аргачлал: Хүүхдүүдийг 2 хэсэгт хувааж, цуваагаар зэрэгцэн ээлжээ хүлээж мөлхөнө.

- Зөөлөн тоглоомуудын сүлжиж 4 хөллөн мөлхөх
- Мөлхөлтийн нуман доогуур мөлхөж гарах
- Бөмбөг өнхрүүлж мөлхөх

Хүүхэд “Эхлээд би, дараа нь чи” гэж өөрийгөө хянаж тоглохыг анхаарна.

Тайвшруулах дасгал.

“Бяцхан хүүхдүүд мөлхөөрэй” дохиогоор чөлөөтэй мөлхөнө. Бяцхан хүүхдүүд унтлаа, Нүдээ аниарай, Гараа өргөөд хамраа олоорой, Хацраа олоорой, Нүдээ олоорой, Чихээ олоорой г.м дасгалыг гүйцэтгэж амраана. Хамтдаа дасгал хийсэнд талархаж алгаа ташиж урамшуулна.

Анхаарах зүйл:

Хүүхдүүдийг мөргөлдөхгүй, гэмтэж бэртэхээс сэргийлж тогтмол анхааруулан хяналт тавина. Хүүхэд бүрийн хөдөлгөөн гүйцэтгэх чадварыг дэмжин дасгалыг буухиа хэлбэрээр уралдахгүй байхыг анхаарна. Дасгалын дараа ус ууж хэвшихийг сануулна.

10 дугаар сарын II долоо хоног

НАМАЙГ ДУУРАЙ

Шинэ үг: Гараа атга, тэнийлгэ

Үйл ажиллагаа 1. Намайг дуурайгаарай (Өглөөний дасгал)

Хэрэглэгдэхүүн: удаан хэмнэлтэй хөгжмийн ая

Аргачлал: Багш хүүхэд бүрд харагдахуйц байрлалд зогсож, хамтдаа дасгалыг гүйцэтгэнэ. Зохиомжит дасгалыг олон хувилбартай хийхдээ байрандаа алх, сарвуугаа атгаж тэнийлгэх, алгаа таш, гараа өргө, хөнгөн гүйгээрэй гэх мэт үгэн тайлбартай удирдан чиглүүлээрэй. Жишээ нь:

- 1-8. Гараа хацар дээрээ бариад толгойгоо баруун/зүүн тал руу хазайлгах
- 1-8. Гараа өргөж сарвуугаа атгаж тэнийлгэх, 2 удаа алгаа таших
- 1-8. Байрандаа хөнгөн гүйх
- 1-8. Байрандаа алхах, Амьсгалын дасгал хийнэ.

Дасгалыг өдөр бүр тогтмол хийж хэвших, гар угаах, ус уух дадлыг хэвшүүлэхэд анхаарна.

Үйл ажиллагаа 2. Цэвэрхэн гар (Хөгжин баясах ажил)

Хэрэглэгдэхүүн: Том шоо (гар угаах дарааллын зурагтай)

Аргачлал: Багшийн үйлдлийг хүүхдүүд даган дуурайна.

- Гараа усаар норголоо
- Гараа савандлаа
- Савангаа хөөсрүүлээ
- Савангийн хөөсөө угаацгаая
- Хоёр гарын алгыг дэлгэж үзүүлж, ингээд "Цэвэрхэн гартай боллоо".

Гар угаах үйлдлийг ойлгосны дараа хүүхдүүд шоог ээлжлэн хаяж тоглоно. Бусад хүүхдүүд шидсэн шооны буусан зургийг дуурайж хөдөлгөөн хийж үзүүлнэ. Хүүхэд бүрийн оролцоог идэвхтэй дэмжиж, урамшуулна.

НОМТОЙ ТАНИЛЦЪЯ

Шинэ үг: Номын хуудас, хавтас, театр,

Үйл ажиллагаа 1. Номын хуудас (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Зурагт ном, дэр, жижиг сандал

Аргачлал: Хүүхдүүд номын төвөөс дуртай номоо сонгон авч сууцгаана. Зурагт номыг барих, хуудсыг нэг 1-ээр эргүүлж үзэхийг багш хийж үзүүлнэ. Хүүхэд бүрд номоо эргүүлж үзэх боломж олгоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Номын гадна талын хуудсыг юу гэж нэрлэдэг бол?
- Хуудсаа нээгээд үзээрэй! Ямар зураг байна?
- Дараагийн хуудсанд ямар зураг байна вэ?

Хүүхдийн сонирхсон, анзаарч ажигласан зургуудыг хамтдаа ярилцаж, тайлбарлана.

Номын хуудсыг нэг бүрчлэн эргүүлж, зураг бүрд тайлбар өгч, асуулт тавина. Хүүхдүүд үзсэн номоо номын тавиурт том, жижгээр давхарлан байрлуулахад багш чиглүүлнэ.

Үйл ажиллагаа 2. Хормогчин театр (Хөгжөөн баясах ажил)

Хэрэглэгдэхүүн: Хормогчин театр

Аргачлал: Багш хормогчин театрыг ашиглан бие эрхтнүүдийг нэг нэгээр нь нааж, тоглох явцдаа хүүхдүүдтэй ярилцана.

- Бие эрхтэн бүр өөрийн үүрэгтэй болохыг тайлбарлана.
- Багшийн нэрлэсэн бие эрхтний зургийг хүүхдүүд өөрийн бие дээр зааж, нэрлэж, үйлдлийг нь дуурайн тоглоно.
- Хүүхдүүд ээлжлэн хормогчин театрыг ашиглан бие эрхтний зургийг нааж, хамтдаа тоглоно.

Үйл ажиллагаа 3. Ширээний театр (Хөгжин баясах ажил)

Хэрэглэгдэхүүн: Ширээний театр

Аргачлал: Ширээний театр ашиглаж багш хүүхэлдэйн дүрд хувирч өөрийгөө танилцуулна. Би олон хувцас өмсдөг. Хувцас янз бүрийн өнгөтэй байдаг. Хамтдаа ярилцъя.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Миний малгай ямар өнгөтэй вэ?
- Чиний цамц өнгөтэй байна вэ?
- Хувцасны зургуудыг хараад нэрлээрэй?

Өдөр тутам хэрэглэдэг зүйлсийг зурган картаас ялгаж зааж нэрлэнэ.

ХӨГЖИЛТЭЙ ДУУ

Шинэ үг: Дуулах

Үйл ажиллагаа 1. Өглөөний дасгал (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Д.Хоролсүрэнгийн үг, ая "Өглөөний дасгал" дууны ая,

Аргачлал: Багш дууны аянд тохируулан дуулж, хөдөлгөөн хийж үзүүлнэ. Хүүхдүүд багшийг дуурайж хөдөлгөөнийг хийхийг оролдоно.

2. Бүжиглээрэй

Хэрэглэгдэхүүн: Бүжгийн ая

Аргачлал: Багш хүүхдийн сайн мэдэх, сонсох дуртай хөнгөн хөгжилтэй аяыг сонсгож, хүүхдүүдтэй хамт чөлөөтэй бүжиглэнэ.

Сонсъё, дэмжье/ Туслалцаа:

- Хүүхэд бусадтай зэрэгцэж дуулах, хөдөлгөөн хийх, зурах, тоглох үйлдлүүдэд дэмжиж урамшуулах ярилцах
- Бүрэг ичимхий, өөрийгөө илэрхийлэхэд тусламж хэрэгцээтэй хүүхдийг ажиглаж, дуртай сонирхолтой тоглоомоор тоглуулах, бусадтай хамтрахад туслах
- Гар сарвууны хөгжил сул хүүхэд хана, сандлын хооронд скоч татаад жижиг өнгийн бөмбөг наах, салгаж татаж авахад дэмжлэг үзүүлэх

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Цэцэрлэгт дасан зохицоход тусалж хүүхдэд эерэг хандлага төрүүлж, орой хүүгээ аваад хариад юу хийх талаар тайлбарлах
- Хүүхдээс асуулт асууж, үг үйлдлийг дуурайж хэлүүлэх хамтдаа тоглох, ярилцах цаг гаргах
- Гэр бүлээрээ хөдөлгөөнт тоглоом тоглох, дуулах, хөдөлгөөн хийх, дүрд тоглох боломжийг олгох, дэмжих, зоригжуулах

Цахим холбоос:

1. <https://www.youtube.com/watch?v=wnprVxO0VJM>

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./

Амжилттай хэрэгжүүлсэн:

Сул хэрэгжүүлсэн:.....

Цаашид сайжруулах:.....

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - XI САР

ГЭР БҮЛ

Хүүхдийн эзэмших чадамж:

Харилцах: Биеийн хэлэмж, хэл яриагаар өөрийн санаа бодлоо илэрхийлэх;

Суралцахууд суралцах: Хүрээлэн буй орчныг таних ялгах

Нийгэм сэтгэл-хөдлөл: Бусдын сэтгэл хөдлөл мэдрэмжийг ойлгох

Аюулгүй байдлын зөвлөмж:

Хүүхдэд өдөр тутмын үйл ажиллагааны явцад харилцан ярилцах, асуултыг ойлгож өөрийн санаа бодлоо илэрхийлэх боломж олгож дэмжинэ.

Сургалтын хэрэглэгдэхүүний зориулалтыг танилцуулж, болгоомжтой хэрэглэх зааварчилгааг биечлэн үзүүлэх, урьдчилан шалгаж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Өдрийн туршид юу хийх талаар танилцуулах, хүүхдээс асуулт асууж хариулах боломж олгох, үйлдэл, үгээр, өгүүлбэрээр хариулахыг дэмжиж урамшуулаарай.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Бие даан тоглох явцдаа бусадтай харилцах, хамтран тоглох, хуваалцах ойлголтыг дэмжин чиглүүлээрэй.
- Ном үзэх орчныг чимээ багатай газар сонгож байрлуулах нь хүүхэд анхаарлаа төвлөрүүлэхэд тустай.

Зугаалга:

- Гадаад талбайд хөдөлгөөнт тоглоом тоглох, хөдөлмөр хийх зэрэгт аюулгүй байдлыг хангахад анхаарах, навч түүх, ногоо хураахад оролцох зэргээр хүүхдийн оролцоог хангаарай.

Өөртөө үйлчлэх цаг:

- Хоолны ширээг засах хураахыг насанд хүрэгчдийн дэмжлэгтэй хийх, өөрийн эд зүйлээ таньж мэдэх, хэрэглэсэн зүйлээ байранд нь хураахад урамшуулан дэмжээрэй.

Хөгжөөн баясах цаг:

- Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийх, сонирхол татахуйц хэрэглэгдэхүүнийг бэлтгэж дүрд орж тоглоход дэмжлэг үзүүлээрэй. Хүн амьтны дүрд орж хөдөлгөөнийг дуурайх, нүүрний хувирал гаргах үед урамшуулан дэмжээрэй.

Боломжууд:

Хүүхдээс асуулт асуух, хариулт авах, номын зургийг заах, нэрлэх, харилцан яриаг дэмжээрэй. Тоглосон тоглоом, хэрэглэсэн эд зүйлээ байранд нь хураах дадалд сургаарай.

Бие даан тоглох, тоглох явцдаа бусадтай харилцах, хамтран тоглох, хуваалцах ойлголтыг дэмжин чиглүүлээрэй.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахүйн үр дүн	Суралцахүйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
НСХ1.3а. Насанд хүрэгчийн тусламжтайгаар байнга хэрэглэдэг эд юмсыг байранд нь хураадаг болно. БНО1.1в. Ойр орчны эд зүйлс, тоглоомыг мэдэрч нэрлэнэ. БНО1.2г. Өөрийн хэрэглэсэн эд зүйлс, тоглоомоо байранд нь хурааж, зориулалтын саванд хог хаяхыг оролдоно.	<ul style="list-style-type: none"> - Тоглоом эд зүйлсийн байрлалыг таньж, зөв байршилд хураах - Орчныхоо тоглоом эд зүйлийг харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх мэдрэхүйгээр дамжуулан таньж мэдэх, сонирхон ажиглах, тоглох - Тоглоомоо байранд нь хураах, “Тоглоомоо хайрцагт хийнэ”, “Багажаа хураая” гэхэд дагаж хийнэ. 	Миний тоглоом
ХЯ1.2а. Харилцан яриаг ажиглан, үг, өгүүлбэрийг дуурайна. ХЯ1.3а. Номыг сонирхож үзнэ. БНО1.2б. Гэр бүлийн гишүүдээ нэрлэж, тэдний хийж буй үйлдлийг дуурайж тоглоно.	<ul style="list-style-type: none"> - Багш, эцэг эх, хүүхдүүдийн хоорондын харилцан яриаг ажиглан, ярианд оролцож эд юмсыг нэрлэх - Номын хуудсыг эргүүлж, амьтан, өнгө, эд зүйлийг, заах, нэрлэх - Гэр бүлийн гишүүдээ нэрлэж таних 	Гэр бүл
ХӨГ1.1а. Хүн, амьтны дуу авиаг ялган таньдаг болно. ХӨГ1.1б. Дууг анхааралтай сонсож, зарим үг, авиаг дуурайн хэлж, аялна. БНО1.1а. Ойр орчны амьтныг таньж ягана.	<ul style="list-style-type: none"> - Нохой, муур, шувуу гэх мэт амьтдын дуу авиаг сонсоод дуурайж дуугарах, хөгжилдөх - Бусдын дуулж байгааг хараад дагаж аялах оролдлого хийх - Зурагт ном, тоглоом, ойр орчноосоо амьтдыг ажиглах, нэрлэх, олж таних, заах 	Юу дуугарсан бэ?

<p>ХЭМ1.1д. Сэдэвт алхалт, гүйлтийг багшийн зааврын дагуу даган дуурайж гүйцэтгэнэ. ХЭМ1.1м. Бөмбөгийг ойр зайд шидэж дамжуулна, барьж авна. НСХ1.1б. Өөрийн хэрэгцээг нүүр, гар, биеийн хөдөлгөөн, дуу авиа, үгээр илэрхийлдэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Амьтдын хөдөлгөөнийг дуурайж алхах, гүйх - Бөмбөгийг уяан дээгүүр хоёр гараар давуулж шидэх - Өөрийн хэрэгцээг хэлэх (Багш асууж хүүхдээс хариулт авах Жишээ нь: Чи ус уумаар байна уу?, Ус уумаар байна гэж хэлэх) 	<p>Хамтдаа тоглоё</p>
<p>МАТ1.1а. Гэр, цэцэрлэгийн орчин тойронд байх юмсаас 1 эсвэл 3 ширхэг тоглоом, юмсыг заах, нэг гэж хэлнэ. ХЭМ1.2в. Хоол хүнсний бүтээгдэхүүнийг угааж, чанаж болгож иддэгийг мэднэ, ялгана. ЗУ1.2в. Бусдын дэмжлэгтэйгээр толбо, дардсаар зурна</p>	<ul style="list-style-type: none"> - Ойр орчныхоо ургамлыг ажиглах, зурагт номоос мод, цэцэг, хүнсний ногоо, жимсийг заах - Нэг эд зүйлийг заах, хэлэх, “Хэд байна вэ?” гэсэн асуултад хариулах - Хурууны өндгөөр толболон зурах 	<p>Амтат хүнс</p>
<p>БНО1.2д. Үндэсний хувцас (малгай, дээл, гутал)-ыг таньж нэрлэнэ. ЗУ1.1а. Уран зургийн бүтээлийг ажиглаж хүн, амьтныг ялгаж танина. БНО1.2а. Өөрийн нэр, нас, бие, эрхтнээ нэрлэж, тоглоом, эд зүйлсээ танина.</p>	<ul style="list-style-type: none"> - Үндэсний хувцас (Малгай, Дээл, Гутал) таних, нэрлэх - Хүүхэд уран зургийн бүтээлийг ажиглан хүн, амьтныг ялгаж заах - Өөрийн нэр, нас, биеийн зарим эрхтнийг нэрлэх, зааж харуулах, тоглоом эд зүйлсээ ялгаж таних 	<p>Миний дээл</p>

11 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Тоглоомоо хураацгаая	Өөртөө үйлчлэх цаг	Тоглож дуусаад тоглоомоо хурааж байранд нь тавихад чиглүүлнэ.. Тоглоом хурааж дуусаад гараа угаана, хогоо хогийн саванд хийнэ.	Тоглоом, тоглоомын тавиур, хайрцаг, сагс, хоолны хэрэгсэл.	Чиглүүлэг зааварчилгаа Одоо тоглоомоо хураацгаая, дагаад хийгээрэй, гараа угаагаарай	Хамтран ажиллах: Хамтын үйл ажиллагаанд оролцох өөрт нь тохирсон үүрэг хүлээх, бусадтай хамтрах, хуваалцах,	Тоглож дуусаад тоглоомоо хураадаг.
Хоолны ширээ	Өөртөө үйлчлэх цаг	Хоолны ширээ засахад хамтдаа оролцоно. Аяга таваг, халбагаа суурь дээр байрлуулж, нэрлэнэ. Хооллож дуусаад хураах, амны цаасаа хогийн саванд хийнэ.	Хоолны хэрэгсэл, амны цаас, аяга тавгийн суурь.	Хэн хоолны ширээ засах вэ? Аяга, тавгийг хаана байрлуулж тавих вэ? Хэрэглэсэн амны цаасаа хаана хийх вэ?	Харилцах: Бусдын үгийг хүлээж авах, ойлгох, үг үйлдлээр өөрийгөө илэрхийлэх	Багштай хамтран хоолны ширээ засдаг. Амны цаас хэрэглэдэг.
Миний гэр бүл	Тойргийн цаг	Зургаас гэр бүлийн гишүүдийг зааж, нэрлэх. Хүүхдийн гэр бүлийн зургийг хананд байрлуулж, өөрийн зургийг олох.	Гэр бүлийн жаазтай зураг, ном.	Зурагт хэн байна вэ? заагаарай, нэрлээрэй. Чи хаана байна вэ? заагаарай.	Шүүн тунгаах: Номын зургийг анзаарах	Гэр бүлийг зургийг зааж нэрлэдэг.
Миний бие эрхтэн	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өөрийн нүүрний хэсгийг нэрлэх, заах, барьж үзэх. “Хаана байна вэ?” асуултад энгийн өгүүлбэрээр хариулах.	Бие эрхтэн (нүд, хамар, ам.....)	Нүд, чих, хамар, ам хаана байна вэ? заагаарай.	Харилцах: Өөрийн санаа, хэрэгцээг дохио зангаа, богино үгээр илэрхийлэх бусдын үйлдлийг ажиглан даган дуурайх	Биеийн эрхтэн заана, нэрлэдэг.
Хавтастай ном	Тойргийн цаг	Хүүхдүүд гэрээсээ ном авчирч болно. Номын хуудсыг эргүүлж үзэх, гэр	Ном (гэрээс авчирсан).	Энэ юу вэ? Энэ хэн бэ? Зураг дээр аав, ээж, эмээ, өвөө, ах эгч	Шүүн тунгаах: Сонирхон, асуулт асуух, харьцуулах,	Номыг сонирхон үздэг. Зургийг зааж

		бүл, бие эрхтний зургийг ажиглан, зааж нэрлэх.		хаана байна вэ? заагаарай.	ялгах, шинэ мэдээллийг хүлээн авах	нэрлэдэг.
Юу дуугарсан бэ?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Амьтдын дуу авиаг дуурайж дуугарч үзүүлнэ. Дууны аянд тохируулан дуулж, амьтдын дуу авиаг таньж, зургаас зааж, нэрлэнэ. Муурын хөдөлгөөн, дуу авиаг дуурайж дуурайна.	Дууны ая, амьтдын зурагт үзүүлэн (Цахим холбоос 1).	Юу дуугарсан бэ?	Суралцахууд суралцах: Сонсох, дуурайж давтах	Багшийг дагаж дууны хөдөлгөөнийг дуурайдаг.
Эргэж сурцгаая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Муурын дуу авиаг сонсгоход хүүхдүүд дуурайж дуугарна. Багш "Муур" дууг дуулж, муурын хөдөлгөөнийг дүрсэлж үзүүлнэ.	"Муур" дууны ая, муурыг дүрсэлсэн бээлийн хүүхэлдэй, зурагт үзүүлэн.	Хөгжимт хөдөлгөөн	Суралцахууд суралцах: Сонсох, дуурайж давтах	Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийнэ
Бөмбөг шидэж тоглоё	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Багшийн дохиог сонсож, чиглэлээ өөрчлөх болон суух хөдөлгөөн хийнэ. Бөмбөгийг уяан дээгүүр давуулан шиднэ.	Цагариг, хөгжмийн ая, 2 өөр өнгөтэй дарцаг, Бөмбөг, олс/уяа	Хөдөлгөөнт тоглоом	Хамтран ажиллах: Хүүхэд бусдын хөдөлгөөн, тоглохыг ажиглах, хамтрагч болох, тоглохдоо дүрмийн дагуу тоглох.	Багшийн дохиог сонсож гүйцэтгэнэ. Саадыг павуулан бөмбөг шиднэ.
Аав ээжтэйгээ тоглоё	Хөгжөөн баясах цаг	Эцэг эхчүүдтэй хамтран зохион байгуулна. Шувуу, мод, нохой зэрэг амьтны дүрийг хөдөлгөөн, дуу авиагаар дүрслэнэ.	Цагариг, хөгжилтэй ая.	Хөдөлгөөнт тоглоом	Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил: Өөрийн болон бусдын биеийн мэдрэмжийг анзаарах, үг, үйлдлээр илэрхийлэх.	Амьтны хөдөлгөөн хийнэ. Амьтны дуу авиаг дуурайж дуугарна.
Угаасан ногоо	Өөртөө үйлчлэх цаг	Сагснаас ногоог нэг нэгээр нь авч нэрлэх (1	Хүнсний ногоо, ногоо угаах сав, хормогч	Чи хэдэн, хүнсний ногоо авсан бэ?	Суралцахууд суралцах: Энгийн үйлдлүүдийг	Эд зүйлээс нэг зүйлийг сонгож

		төмс, 1 лууван). Сонгосон ногоогоо усанд хийж угаах туршилт хийнэ.	ханцуйвч.		дуурайх	авдаг.
Амтат жимс	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Нэг зүйл нэмэгдэж олон болдогийг асуултаар чиглүүлэх. Жимсний зургийг нэрлэх (алим, гадил, тарвас). 1-3 жимсийг сонгож авахад дэмжлэг үзүүлнэ.	Жимсний зурагтай карт.	Авсан жимсээ сандал дээрээ тавиарай. Хэдэн жимс сонгож авсан вэ?.	Суралцахууд суралцах: Энгийн үйлдлүүдийг дуурайх	Эд зүйлсээс 1,1-ээр авч гурван зүйл болгодог.
Өнгөт жимс	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хурууны өндгөөр толболон зурах аргачлалыг үзүүлнэ. Жимс, хүнсний ногооны бэлдэц зургийг сонгож, будагт хурууны өндгийг дүрж, толболон зурна.	Жимс, хүнсний ногооны зураг, усан будаг, гуаш, нойтон салфетка.	Будаж дуусаад гараа нойтон салфетикт арчаарай багш сануулна.	Хамтран ажиллах: Бусадтай зэрэгцэж зураг зурах, хуваалцахад суралцах.	Хурууны өндгөөр зурж дүрсэлдэг.
Миний дээл	Тойргийн цаг	Үндэсний дээлийн зах, ханцуй, бүс зэрэг хэсгүүдтэй танилцан, бусад хувцаснаас ялгаатай байдлыг ярилцана.	Дээл, гутал.	Дээл нь ямар өнгөтэй байна вэ? Дээлийн захыг заагаарай, ханцуйн хаана байна вэ? Бүстэй байна уу?	Үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах: Үндэсний хувцас, зан заншлын зарим үйлийг даган дуурайх, баяр ёслолын үйл ажиллагаанд бусдыг даган оролцох.	Дээлийг бусад хувцаснаас ялгаж заана, нэрлэдэг.
Хургачин бүтээл	Тойргийн цаг	Зураач Я.Үржнээгийн "Хургачин" бүтээлийг ажиглан ярилцах.	Зураач Я.Үржнээ "ХУРГАЧИН" бүтээл.	Зурагт хүүхэд хаана байна вэ? Хүүхэд ямар хувцас/гутал өмссөн байна вэ? Хүүхдийн цаана юу харагдаж байна вэ?.	Үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах, өвлөх: бүтээлийг ажиглах	Урлагийн бүтээлийг ажиглан зааж, нэрлэдэг.

11 дүгээр сарын I долоо хоног

МИНИЙ ТОГЛООМ

Шинэ үг: Хураах, хогийн сав

Үйл ажиллагаа 1. Тоглоомоо хураацгаая (Өөртөө үйлчлэх цаг)

Хэрэглэгдэхүүн: Тоглоом, тоглоомын тавиур, хайрцаг, сагс, хоолны хэрэгсэл, амны цаас

Аргачлал: Анги дотор олон төрлийн тоглоомоор олон хэсэгт хүүхдүүд тоглож байна. Багш хонх цохиж анхаарлыг төвлөрүүлнэ. Одоо тоглоомоо хураацгаая гээд “Бөмбөгийг улаан сагсанд хийгээрэй”, “Машиныг тавиур дээр тавиарай” гэж чиглүүлнэ. Эхний үед хүүхдүүд тоглоомыг хураахгүй байж болно. Гэхдээ хэсэг хугацааны дараа хүүхдүүд багшийг даган дуурайж тоглоом бүрийг хаана байрлуулахыг анзаарч өөрсдөө хураана. Тоглоомоо хурааж дуусаад гараа угаана. Гараа цаасан алчуураар арчсан бол хогоо хогийн саванд хийнэ.

Үйл ажиллагаа 2. Хоолны ширээ (Өөртөө үйлчлэх цаг)

Хэрэглэгдэхүүн: Аяга тавагны суурь, аяга таваг, халбага, амны цаас

Аргачлал: Аяга тавгийн суурийг хүүхэд бүрийн өмнө ширээн дээр байрлуулна. Багш давхарлан тавьсан аяга, тавгаас нэг 1-ээр авч өгөхөд хүүхдүүд өөрийн аяга тавгийн суурь дээр байрлуулна. Багш аюулгүй байдлыг хангаж анхааруулж хэлнэ. Хүүхдүүд халбаганаас авч халбага тавих хэсэгт байрлуулна, аяга, таваг, халбага гэж нэрлэнэ. Хоолны ширээнд сууж хоолоо иднэ. Хоолоо бага багаар халбагадаж иднэ. Хооллож дуусаад аяга, тавгаа давхарлана хураана. Хэрэглэсэн амны цаасаа хогийн саванд хийнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хэн хоолны ширээ засах вэ?
- Аяга тавгийг хаана байрлуулах вэ?
- Хэрэглэсэн амны цаасаа хаана хийх вэ?

ГЭР БҮЛ

Шинэ үг: Гэр бүл

Хэрэглэгдэхүүн: Гэр бүлийн жаазтай зураг, ном

Үйл ажиллагаа 1. Миний гэр бүл (Тойргийн цаг)

Аргачлал: Хүүхдийн гэр бүлийн зургийг ангийн ханад байрлуулна. Өөрийн гэр бүлийн зургийг олоорой, хаана байна гэж хэлээд ажиглана. Өөрийн гэр бүлийн зургийг таньж очсон хүүхэдтэй ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Зурагт хэн байна вэ? заагаарай, нэрлээрэй.
- Чи хаана байна вэ? заагаарай.
- Ах, эгч нь хаана байна вэ?

Үйл ажиллагаа 2. Миний бие эрхтэн (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Багш нүүрний хэсгийг нэрлэж, хаана байгааг асууна. "Нүд, чих, хамар, ам" хаана байна гэж асуугаад бодох хугацаа өгнө. Дахин "Нүд нь хаана байна" заагаарай. Хамар нь хаана байна вэ?, заагаарай. Ам нь хаана байна вэ?, Чих нь хаана байна вэ?, заагаарай. гэхэд хүүхдүүд нэрлэсэн эрхтнийг гараараа зааж, барьж үзнэ. Гараа өвдөг дээр тавиарай зэрэг биеийн хэсгийг нэрлэж сурахад дэмжлэг үзүүлнэ.

Үйл ажиллагаа 3. Хавтастай ном (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Гэрээс авчирсан ном

Аргачлал: Хүүхдүүд гэрээсээ ном авчирч болно. Номын хуудсыг нэг нэгээр нь эргүүлж үзнэ. Зарим тохиолдолд багш дэмжлэг үзүүлнэ. Номыг хуудас дээрх гэр бүл, бие эрхтний зургийг ажиглан харна, заана, нэрлэнэ. Зураг дээр дарахад дуу, чимээ гардаг бол үг, авиаг сонсоод дуурайж хэлнэ. Номоо үзэж дуусаад номын тавиур дээр тавина. Номын зургийг тайлбарлан ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ юу вэ? Энэ хэн бэ?
- Инээж байгаа хүмүүс аль нь вэ? заагаарай.
- Зураг дээр аав, ээж, эмээ, өвөө, ах эгч хаана байна вэ? заагаарай.
- Бие эрхтэн (толгой, нүд, ам, хамар, чих, гар, хөл) аль нь вэ? заагаарай, нэрлээрэй.

ДАГААД ДУУЛААРАЙ

Шинэ үг: Дуугарах

Үйл ажиллагаа 1. Юу дуугарсан бэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Дууны ая, амьтдын зурагт үзүүлэн

Аргачлал: Багш дууны аянд тохируулан дуулна.

“Сайн сонсоорой, сайн сонсоорой, юу дуугарсан бэ?” гэж дуулахад, аялгууны дундуур сонсогдсон амьтдын дуу авиаг таньж, зургаас зааж, нэрлэн, дуурайж дуугарах байдлаар тоглоно. Цахим холбоос 1-ийг ашиглаж болно.

Үйл ажиллагаа 2. Муурын дуу (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хоролсүрэнгийн үг “Муур” дууны ая, муурыг дүрсэлсэн бээлийн хүүхэлдэй, зурагт үзүүлэн, муурын дуу авиа бүхий бичлэг,

Аргачлал: Багш муурын дуу авиаг сонсоход хүүхдүүд дуурайж дуугарна, нэрлэнэ.

Багш бээлийн хүүхэлдэйг барьж “Мяу- мяу” гэж дуугарч үзүүлнэ. Хүүхдүүд багшийг дуурайж дуугарахыг оролдоно. Багш “Муур” дууг дуулж, муурын хөдөлгөөнийг дүрсэлж үзүүлнэ. Хүүхдүүд багшийг дуурайн гарыг сарвайлгах, атгах, даллах зэрэг хөдөлгөөн хийнэ. Цахим холбоос 2-ийг ашиглаж болно.

ХАМТДАА ТОГЛОЁ

Шинэ үг: Сууна, эргэнэ

Үйл ажиллагаа 1. Эргэж сурцгаая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Цагариг, хөгжмийн ая, 2 өөр өнгөтэй дарцаг

Аргачлал: Хүүхдүүд гар гараасаа барьж зогсоно. Багш 2 өөр өнгийн дарцгаар удирдаж чиглүүлнэ.

- Улаан дарцаг өргөхөд хүүхдүүд баруун тал руу эргэн тойргоор алхана.
- Хөх дарцаг өргөхөд зүүн тал руу тойргоор алхана.
- Дарцгаа буулгавал доош сууцгаана.

Багш хүүхдүүдийг ажиглан эргэж харсны дараа дохиог өгч биечлэн дагуулж гүйцэтгэнэ.

Үйл ажиллагаа 2. Бөмбөг шидэж тоглоё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Хүүхдүүдийг олсны ард нэг эгнээ болгон зогсооно. 1 метрийн өндөртэй уяан дээгүүр багш бөмбөгийг давуулан шидэж үзүүлнэ. Хүүхдүүд багшийн заасны дагуу бөмбөгөө авч олсны ард зогсоод бөмбөгийг уяан дээгүүр давуулан шиднэ. Хүүхэд өөрт ойр байгаа бөмбөгийг авч олсны ард зогсоод дахин уяан дээгүүр давуулан шидэж тоглоно.

Багш эцэг эхэд гэртээ бөмбөгөөр шидэж, өнхрүүлж тоглохыг санал болгоно.

Дасгал тоглоомын дараа тогтмол ус уухыг санал болгох, хүүхэд өөрөө усаа хийж уухад анхаарал хандуулна.

Үйл ажиллагаа 3. Аав ээжтэйгээ тоглоё (Хөгжөөн баясах цаг)

Аргачлал: Таралтын цаг дээр эцэг эхчүүд, асран хамгаалагчидтай хамтарч зохион байгуулна. Хөгжилтэй ая эгшиглэн хүүхдүүд чөлөөтэй хөдөлгөөн хийнэ.

- Шувуу шувуу нисээрэй гэхэд хүүхдүүд хоёр гараа алдлан дээш доош хөдөлгөж, шувуу болж ийш тийш гүйлдэнэ.
- Модны дор суугаарай гэхэд хүүхдүүд хэсэг хэсгээрээ цагариг дотор сууж амарч буй шувуудыг дүрсэлнэ.
- Нохой нохой хов, хов хуцаж байна гэхэд хүүхдүүд хоёр гараа нийлүүлэн цээжний өмнө авч, “хов, хов” гэж дуугарч нохой болж гүйнэ.

- Үүрэндээ ороорой гэхэд цагариг дотор орж сууна.
- Нохой нохой хав, хав, хав, Шувуу шувуу жив, жив, жив гэж хэлэхэд хүүхдүүд давтан хэлж дуу авиаг дуурайна. Эцэг эхийн оролцуулна.

11 дүгээр сарын II долоо хоног

АМТАТ ХҮНС

Шинэ үг: Нэг, жимс

Үйл ажиллагаа 1. Угаасан ногоо (Өөртөө үйлчлэх цаг)

Хэрэглэгдэхүүн: Хүнсний ногоо, ногоо угаах сав, хормогч ханцуйвч, жимсний зурагтай карт, жимсний бэлдэц зураг, усан будаг, гуаш, нойтон салфетка

Аргачлал: Хүүхдүүдийн голд сагстай ногоог авчирч тавина. Юу байгааг харцгаая. Сагснаас нэг 1 хүнсний ногоо авна. Чи хэдэн, хүнсний ногоо авсан бэ? 1 төмс, 1 лууван гэж өөрийн авсан зүйлээ нэрлэнэ. Өөрийн сонгож авсан хүнсний ногоог савтай усанд хийж ээлжлэн угаана. Дараа нь гараа сайтар угаана. Гэртээ хариад хоолны ногоог ээжтэйгээ хамт угаахыг хүүхдүүдэд сануулж хэлнэ.

Үйл ажиллагаа 2. Амттай жимс (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Жимсний зурагтай картыг газарт тарааж тавьсан байна. Зургийг харж нэрлэнэ (алим, гадил, тарвас). Ямар ч жимсний зураг ашиглаж болно. 1 жимс сонгож аваарай. 3 жимсийг нэг 1-р авахад багш дэмжлэг үзүүлнэ. Авсан жимсээ сандал дээрээ тавиарай. Хэдэн жимс сонгож авсан вэ? асууж ярилцана.

Үйл ажиллагаа 3. Өнгөт жимс (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Жимс, хүнсний ногооны бэлдэц зургийг бэлтгэсэн байна. Өөрийн зурахыг хүссэн зургаа сонгож авна. Усан будаг гуашийг найруулж бэлтгэсэн байна. Багш найруулж бэлтгэсэн будагт хурууны өндгийг дүрж будах зураг дээр зөөлөн зөөлөн дарж толболон зурж үзүүлнэ. Будаг дуусаад гараа нойтон салфетикт арчихыг сануулна. Хүүхдүүд зааврын дагуу өнгөө сонгож найруулж бэлтгэсэн будагт хурууны өндгөө дүрж зургаа хурууны өндгөөр толболон зурж дүрсэлнэ.

МИНИЙ ДЭЭЛ

Шинэ үг: Дээл, гутал

Үйл ажиллагаа 1 Миний дээл (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Дээл, гутал

Аргачлал: Тойргоор сууцгааж чөлөөтэй ярилцана. Өнөөдөр хэн хэн дээлтэй ирсэн бэ? Бүгдээрээ дээл өмссөн байж болно эсвэл дээл өмсөж ирсэн хүүхдийг босгож бусдын хүүхдийн анхаарыг төвлөрүүлнэ. Дээл хувцас нь зах, ханцуй, товч, бүс, гутал зэргийг зааж давтан хэлүүлнэ.

Хүүхдүүд өөрийнхөө дээлийг бусаддаа танилцуулахад багш асуултаар чиглүүлж тусална.

- Дээл нь ямар өнгөтэй байна вэ?
- Дээлийн захыг заагаарай, ханцуйн хаана байна вэ?
- Бүстэй байна уу?, ямар өнгөтэй байна вэ?

Үйл ажиллагаа 2 “Хурагчин” бүтээл (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Зураач Я.Үржнээ “ХУРГАЧИН” зураг

Аргачлал: Бүтээлийн ажиглана. ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Зурагт хүүхэд хаана байна вэ?
- Хүүхдээс өөр юу байна вэ? заагаарай, нэрлээрэй.
- Хүүхэд ямар хувцас/гутал өмссөн байна вэ?
- Хүүхэд гартаа юу барьсан байна вэ?
- Хүүхдүүд яагаад малгай өмссөн юм бол?
- Хүүхдийн цаана юу харагдаж байна вэ?



Дээрх хувилбарт тулгуурлан ажиглалтын хэлбэрээр үнэлэх

нэг загварыг авч үзлээ. Багш та өдөр тутмын сургалт, үйл ажиллагааны явцдаа баяжуулан ашиглах боломжтой.

Сонсьё, дэмжье/ Туслалцаа:

- Хүүхэд хийж байгаа зүйлээ дуусгахгүй орхих, нэг өнгөөр зурах, нэг тоглоомоо байнга тэврэх зэрэг үйлдэл гаргаж болно. Ийм үед хүлээцтэй хандаарай.
- Хүүхдийн хөгжлийн түвшин, онцлог байдлаас шалтгаалан өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол оролцохгүй байгаа тохиолдолд битгий шахаарай.

Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг оролцоо:

- Цэцэрлэгийн үйл ажиллагаанд гэр бүлээрээ оролцох хөдөлгөөнт тоглоом тоглох, дуулах, хөдөлгөөн хийх, дүрд тоглох боломжийг олгох, дэмжих, зоригжуулах
- Хувцаслах үед нь хувцасны талаар ярилцаж, асуулт асууж давтан хэлж хэл яриа танин мэдэхүйн хөгжил бие даах чадварыг дэмжээрэй.
- Хоол хийх явцдаа хүнсний ногоог угаалгах зэрэг хамтдаа үйл хийж болно.

Цахим холбоос:

1. <https://youtube.com/shorts/FNR1TyP2hKw?feature=share>
2. <https://youtube.com/shorts/7No-bpfRxRw?feature=share>

<p>Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/ Амжилттай хэрэгжүүлсэн: Сул хэрэгжүүлсэн:..... Цаашид сайжруулах:..... Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:</p>

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - XII САР

ГУРВАН БААВГАЙ

Хүүхдийн эзэмших чадамж.

Хамтран ажиллах: Бусдыг ажиглан, тэдний үйлдлийг дуурайх оролдох, өдрийн хуваарьт үйл ажиллагаанд бусадтай хамтран оролцох, сонирхох;

Нийгэм сэтгэл хөдлөл: Өөрийгөө бусдаас ялгах, баярлах, уурлах, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх;

Аюулгүй байдлын зөвлөмж: Анхааралтай ажиглаж, шинэ тоглоом, үйл ажиллагаанд оролцуулахдаа тайлбарлаж үзүүлэх, тоглоомыг хамтдаа цэгцлэх, хураах дадал суулгах, бие биеэ түлхэхгүй байх талаар байнга сануулах;

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Өглөө бүрийн эхэнд хүүхдүүдийн анхаарлыг төвлөрүүлэх, ажиглах, сонсох, дуурайх, нэрлэх ярилцах, дуут хөдөлгөөнт тоглоом үйл ажиллагаанд нийтээр оролцуулах;

Чиглүүлэгтэй, тоглоом үйл ажиллагаа:

- Сонирхол, оролцоог дэмжих, хүүхдийн үйлдлийг анзаарах, сонирхож буй зүйлсийг чиглэл болгон ашиглах, тэдний ярианд оролцож, асуулт тавьж харилцан ярилцлага өрнүүлэх;

Номын цаг:

- Зурагт ном, үлгэрийн дүрүүдийг өөр хоолойгоор дуурайлгаж тод чанга унших, номын хуудас дахь зураг зааж, тайлбарлаж ярилцах;

Хөгжөөн баясах цаг:

- Энгийн зааврыг сонсож амьтны хөдөлгөөн, дуу хоолойг дуурайх, үлгэрийн баатрууд, хүүхэлдэйн төрөл бүрийн хэрэглэгдэхүүнээр дүрслэн хамтдаа тоглох;
- Боломжууд:** Хүүхдүүдтэй хамт тоглох боломж олгох, юунд дуртай байгааг ажиглаж сонирхолд тулгуурлаж үйл хийлгэх;

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
ХЯ1.2в. Танил эд юмсыг нэрлэнэ. МАТ1.3в. Юмсын байршлыг танина. (дээр, доор) ХЭМ1.2г. Хоолны хэрэгслийг нэрлэж, зориулалтын дагуу хэрэглэнэ.	<ul style="list-style-type: none"> - Танил орчны юмс, тоглоом, эд зүйлс, амьтны нэр, энгийн үйлдэл зэргийг нэрлэх, зургийг заах, нэрийг давтан хэлэх, эд зүйлстэй холбоотой богино дуу, шүлэг тогтоох гэх мэт үйл хийх; - Нэрлэсэн байршилд (дээр, доор) юмсыг тавих; - Хоолны хэрэгсэл тавих суурь зургийн дагуу аяга, таваг, халбагыг байрлуулах сургах тоглоом тоглох; 	Гурван баавгай
ЗУ1.2в. Бусдын дэмжлэгтэйгээр толбо, дардсаар зурна. БНО1.1б. Өдөр тутам хэрэглэдэг жимс, хүнсний ногоог таньж нэрлэнэ. МАТ1.3в. Юмсын байршлыг танина. (дээр, доор) ХЯ1.2в Танил эд юмсыг нэрлэнэ.	<ul style="list-style-type: none"> - Хурууны өндгөөр толболох; - Жимс, хүнсний ногоог угаах, арчих үйлийг харж сонирхох, оролцохыг хүсэх; - Тавиур, ширээний дээр, доор байгаа бодит юмсыг нэрлэх - Гарт барьсан юмсыг (ном гэх мэт) дээр өргөх, доор байрлуулах. - Эд зүйлс, амьтны зураг тоглоомыг ялгаж байрлуулах, ангилж ялгах, нэрлэх тоглоом тоглох. 	Алтан үст охин
ХӨГ1.1а. Хүн, амьтны дууг авиаг ялган таньдаг болно. ХӨГ1.1в Дуу, аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийнэ. ХЯ1.1б. Хэлсэн үгийг сонсож, давтан хэлнэ.	<ul style="list-style-type: none"> - Аав ээж, ах, эгч гэх мэт хүмүүсийн дуу хоолойг анхааралтай сонсоод, чанга, сул, бүдүүн, нарийныг дуу авиагаар илэрхийлэх; - Дуу, ая аялгуунд тохируулан хөдөлгөөнийг даган дуурайх; - Давтагдсан үгтэй богино дуу, шүлгийн мөрийг давтан хэлж, тогтоох; 	Баавгайн дуу
НСХ1.2а. Бусдын биеийн зарим мэдрэмжийг ойлгодог болно. ЗУ1.3а. Баримлын шавраар нэг бүтэцтэй зүйлийг бусдын дэмжлэгтэй барьж бүтээнэ. ХЯ1.1.б Хэлсэн үгийг давтаж хэлнэ. ХЯ1.3а. Номыг сонирхож үзнэ.	<ul style="list-style-type: none"> - Нүүрний хувирал, биеийн хөдөлгөөнөөр дүрсэлсэн зурагт үзүүлэнг ажиглаж ярилцах; - Баримлын шаврыг тасалж, базаж, зөөллөж гарын алганд бөөрөнхийлөх, хавтгайлах; - Үгийг удаан, тод, ойлгомжтой хэлэх, танил үгсийг сонсоод дуурайх, давтан хэлэх, - Үлгэр, зохиолын дүр, зураг бүрийн тухай асуултад хариулж, үйл явдлыг дүрслэн тоглох; 	Баавгай яагаад уурласан бэ?
ХЯ1.1а. Бусдын яриаг сонсоод ойлгосноо үг, үйлдлээр илэрхийлнэ. БНО1.1а. Ойр орчны амьтныг таньж ялгана. ХЯ1.3а. Номыг сонирхож үзнэ.	<ul style="list-style-type: none"> - Ном, үлгэр зохиолын зураг дээрх үйлдлийг дуурайх, нэрлэх, таах, дүрүүдийн үгийг дагаж хэлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах. - Зурагт ном, тоглоом, ойр орчноосоо амьтдыг ажиглах, нэрлэх, олж таних, заах - Үлгэр, зохиолын дүр, зураг бүрийн тухай асуултад хариулж, үйл явдлыг дүрслэн 	Би хэн бэ?

	тоглох;	
<p>ХЭМ1.1е. Дөрвөн хөллөж 20 см-ын зайтай зураасны хооронд мөлхөнө.</p> <p>ХЭМ1.1г. Байрандаа болон чиглэлээ өөрчилж алхаж, гүйнэ.</p> <p>НСХ1.3б. Бусад хүмүүс ижил зүйл хийж байгааг ажиглаж мэддэг болно</p>	<ul style="list-style-type: none"> - 2-3 м зайд байрлуулсан тоглоом хүртэл найзтайгаа уралдаж мөлхөх; - Тойргоор алхах, гүйх хөдөлгөөнийг давталттай гүйцэтгэх - Эхлээд би, дараа нь чи” гэсэн өөрийгөө хянах, дараалал ойлгох төрөл бүрийн тоглоом тоглох 	Баавгайн үүр

Албан хэрэгцээнд

12 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
“Алтан үст охин ба гурван баавгай” үлгэр	Номын цаг	Үлгэрийг дүрийн дуу хоолой, сэтгэл хөдлөлийг тодотгон ярих. Шинэ үгсийн (Баавгай, аяга, сандал, ор) утгыг тайлбарлана.	Үлгэрийн дүрүүдийн тоглоом (бамбарууш, аяга, сандал, ор).	Аав, ээж, бяцхан бамбарууш аль нь вэ? Аав баавгайн аяга аль нь вэ? гэх мэт.	Харилцах	Танил эд юмсыг нэрлэдэг.
Энэ хэнийх вэ?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	3 баавгайн гэрийн эд зүйлсийг нэрлэх, тэдгээрийг том, жижиг хэмжээгээр ялгаж, зохих баавгайд нь зэрэгцүүлэн өрнө.	Үлгэрийн дүрүүдийн тоглоом (бамбарууш, аяга, сандал, ор).	Том аяга хэнийх вэ? Жижиг сандал хэнийх вэ?.	Шүүн тунгаах Хэмжээгээр ялгах.	Юмсын байршлыг таньдаг.
Хоолны ширээ засъя	Өөртөө үйлчлэх хөдөлмөр	Хоолны хэрэгсэлийг нэрлэж, зураг бүхий дэвсгэрийн дагуу зөв байрлуулах, хураах үйлд сургана.	Хоолны хэрэгсэлийн зураг бүхий дэвсгэр, аяга, халбага, цайны аяга.	(Хэрэгсэл нэрлэх, байрлуулах зааварчилгаа).	Нийгэм сэтгэл хөдлөл	Хоолны хэрэгслийг нэрлэж, зориулалтаар нь хэрэглэдэг.
Алтан үст охин /Хурууны өндгөөр толболох	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Алтан үст охины зургийг ажиглаж, нүүрний хэсгүүдийг нэрлэх. Хурууны өндгөөр будагнаас авч охины үсийг толболон будна.	Хормогч, ханцуйвч, гуаш, гарын алчуур, хэвлэмэл зурагт хуудас.	Охины нүд, хамар, ам, үс хаана байна вэ?.	Бүтээлчээр сэтгэх, юмсыг зурах будах	Хурууны өндөг, эд юмсаар толболж, дардаслаж зурдаг.

Дээр доор	Хөгжөөн баясах	"Дээр", "доор" гэсэн үгсийг ашиглан үлгэрийн дүрүүд болон эд зүйлсийг байрлуулах дасгал хийх. Багшийн зааврыг дагана. .	Үлгэрийн дүрүүдийн тоглоом (Хүүхэлдэй, бамбарууш, сандал, ор).	Алтан үст охиныг сандал дээр суулгаарай. Сандал доор тавиарай.	МАТ: Байршил таних, Харилцах Үгийг давтан хэлэх	Байршлыг таньж, юмсыг байрлуулдаг.
Гурван баавгай дуу / Сэрсэн баавгай	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Гурван баавгай" дууг дууны аянд тохируулан хөдөлгөөнөөр дүрслэн дуулах. "Сэрсэн баавгай" хөгжимт тоглоомыг заавраар тоглох, хурдан, удаан хөдөлгөөнөөр дүрд хувирна.	Зурагт үзүүлэн, хуруун хүүхэлдэй, гурван баавгай дууны ая, баавгайн баг.	Байшинд хэн байна вэ?.	Хөгжим: Дуу авиа ялгах, хэмнэлд тохируулан хөдлөх,	Хэмнэлд тохируулан хөдөлгөөн дуурайдаг.
Баавгай яагаад уурласан бэ?	Тойргийн цаг	Баавгайн уурласан шалтгааныг ярилцах. Өөрийн тоглоомыг булаалгавал ямар мэдрэмж төрөхийг хэлэлцэх. Баавгайн сэтгэл хөдлөлийг (уурлах, уйлах) нүүрний хувирлаар илэрхийлнэ.	Нүүрний хувирал, сэтгэл хөдлөлийн зурагт үзүүлэн, бамбарууш тоглоом.	3 баавгай яагаад уурласан бэ? Тоглоомыг чинь булаавал ямар санагдах вэ?.	Нийгэм, сэтгэл хөдлөл Сэтгэл хөдлөлийг ойлгох	Уйлах, инээх нүүрний хувирлыг үзүүлдэг.
Аяга урлацгаая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Баримлын шаврыг атгаж, зөөллөж, бөөрөнхийлөх. Том, дунд, жижиг хэмжээтэй аяга урлана.	3 өнгийн баримлын шавар (том, дунд, жижиг хуваасан), баримлын суурь.	Аав баавгайн том аяга нь аль вэ? Тавиурын дээр, доор байрлуулаарай.	Шүүн тунгаах Хэмжээ ялгах	Нэг бүтэцтэй зүйлийг барьж бүтээдэг.

Гэрэл сүүдрээр тоглоцгооё	Хөгжин баясах	Гэрэл сүүдэр ашиглан "Гурван баавгай" үлгэрийг жүжигчлэн үзүүлэх. Багшийн яриа, дуу хоолойны өнгө аясыг өөрчлөхөд хүүхдүүд дүрүүдийг хөдөлгөн оролцоно.	Сүүдэр үзүүлэн (дүрүүд), ширм, гар чийдэн, дууны бичлэг.	Үлгэрийн үйл явдлыг өгүүлэх зааварчилгаа	Бүтээлчээр сэтгэх.	Тоглолт, үзүүлбэрт оролцдог.
Би хэн бэ?	Тойргийн цаг	Үлгэрийн дүрүүдийн онцлог шинж (биет, дуу хоолой, үйлдэл) -ийг тодорхойлон, багш өөр өөр хоолойгоор хэлэхэд хүүхдүүд таана. ("Би хэн бэ?").	Үлгэрийн дүрүүдийн зурагт үзүүлэн/бодит тоглоом.	Би том биетэй. Би бүүдүүн дуутай. Би ууртай. Би хэн бэ?.	Харилцах Сонсож ойлгох, үгээр илэрхийлэх,	Яриаг сонсоод ойлгосноо үг, үйлдлээр илэрхийлэх
Байрлуулаарай. Үлгэрийн мемотаблицы	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүснэгтэд том, жижиг баавгайг байрлуулж, тэдний ард аяга, сандал, орыг хэмжээгээр нь тохируулан байрлуулах. Хүүхдүүд өөрийн жижиг хүснэгтэд хийнэ.	Охин, 3 баавгай, 3 аяга, 3 сандал, 3 орны зурагт үзүүлэн, хүснэгтэн үзүүлэн.	Зургуудыг хэмжээгээр нь ялган байрлуулах зааварчилгаа	Шүүн тунгаах Ангилал, ялгах	Тоглоом, үзүүлбэрээр үнэлэх боломжтой
Баавгай болж тоглоё	Хөгжөөн баясах	Хүүхдүүд үлгэрийн дүрүүдэд (баавгай, охин) хувиран, үйл явдлыг жүжигчлэн тоглох. Төгсгөлд нь "Гурван баавгай" дууг хамтдаа дуулж, бүжиглэнэ.	Баавгайн баг, хувцас, хүүхдийн хэмжээнд тохируулсан аяга, сандал, ор, дууны ая.	Дүрд хувирах, үйл явдлыг дуурайх зааварчилгаа		Үлгэр, зохиолын үйл явдлыг дүрслэн тоглодог.

Баавгайн үүр	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Мөлхөх хөдөлгөөн: 4 хөллөж цагариган дундуур мөлхөх (20 см-ийн зайтай зураасны хооронд). Том, жижиг бөмбөгийг сонгож, тохирох том, жижиг сагсанд ялгаж хийнэ.	5 цагариг эсвэл мөлхөлтийн хоолой, том жижиг бөмбөг, сагс.	(Мөлхөх, бөмбөг хийх зааварчилгаа).	Бие Дөрвөн мөлхөх, Шүүн Ялгах	бялдар хөллөж Дөрөв хөллөж нуман доогуур мөлхдөг. тунгаах
Баавгайн үүрэнд бөмбөг оруулъя	Хөдөлгөөнт тоглоом	Хүүхдүүд багт хуваагдан, бөмбөгийг хөлөөр өнхрүүлж/өшиглөж, нүх гаргасан цаасан хайрцаг руу оруулна.	Нүх гаргасан цаасан хайрцаг, бөмбөг.	(Бөмбөг өшиглөх зааварчилгаа).		Хувийн хавтас зэрэг арга хэрэгслээр үнэлнэ

12 дугаар сарын I долоо хоног

ГУРВАН БААВГАЙ

Шинэ үг: Баавгай, аяга, сандал, ор

Үйл ажиллагаа 1. “Алтан үст охин ба гурван баавгай” үлгэр (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Үлгэрийн дүрүүдийн тоглоом (Том жижиг бамбарууш, аяга, сандал, ор)

Аргачлал: “Алтан үст охин ба гурван баавгай” зохиолыг багш бодит үзүүлэн ашиглан, дүрүүдийн дуу хоолойны өнгө, үйл хөдлөл, сэтгэл хөдлөлийг тодорхой харуулан, урнаар ярина. Үлгэрийн дүрүүдийн тоглоом болон аяга, сандал, ор ашиглан үлгэрт гарч буй амьтад болон эд зүйлсийг нэрлэнэ. Шинэ үгсийн утгыг тайлбарлана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Аав баавгай аль нь вэ? Заагаарай.
- Ээж баавгай аль нь вэ? Заагаарай.
- Бяцхан бамбарууш аль нь вэ? Заагаарай.
- Аав баавгайн аяга аль нь вэ? Ээж баавгайн сандал хаана байна вэ? Бяцхан бамбаруушийн ор хаана байна вэ? гэж асууж, ярилцана.

Үйл ажиллагаа 2. “Энэ хэнийх вэ?” (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Үлгэрийн дүрүүдийн тоглоом (Том жижиг бамбарууш, аяга, сандал, ор)

Аргачлал: Хүүхдүүд 3 баавгайн гэрийн эд зүйлсийг нэрлэж, том, жижиг хэмжээгээр нь ялгаж сонгон байрлуулна. Аав баавгай том учраас том сандал, том ор, том аяга гэж ялгаж зэрэгцүүлж өрнө. Бяцхан бамбарууш жижиг учраас жижиг аяга, жижиг, сандал, жижиг, орыг сонгож зэрэгцүүлнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ юу вэ? гэж асуухад юмсыг нэрээр нь тод хэлж нэрлэнэ.
- Том аяга хэнийх вэ? Тэгвэл том аягыг аав баавгайд өгөөрэй.
- Жижиг сандал хэнийх вэ? Тэгвэл бяцхан бамбаруушийг сандал дээр нь суулгаарай.
- Харин ээж баавгайн ор аль нь вэ? ээж баавгайг орон дээр нь тавиарай гэж асууж, ярилцана.

Үйл ажиллагаа 3: Хоолны ширээ засъя (Өөртөө үйлчлэх хөдөлмөр)

Хэрэглэгдэхүүн: Хоолны хэрэгслийн зураг бүхий дэвсгэр, хоолны аяга, халбага, цайны аяга

Аргачлал: Багш тавиур дээр хоолны дэвсгэр, цайны аяга, хоолны аяга, халбага, бэлтгэсэн байна. Хоолны хэрэгслийг нэг бүрчлэн танилцуулан, нэрлэнэ. Ширээн дээр хоолны зураг бүхий дэвсгэр тавина. Зургийн дагуу хоолны хэрэгслийг нэг бүрчлэн нэрлэж, зурагт тохируулан тавина. Хүүхдүүд нэг нэг дэвсгэр аваад ширээн дээр тавина. Хоолны аяга, цайны аяга, халбагыг дэвсгэр дээр зургийн дагуу байрлуулна. Хүүхдүүд ширээндээ сууж, сайхан хооллохыг ерөөнө. Хооллож дуусаад аяга, таваг, халбагаа хураана. Хураах үед нь аяга, халбагаа зөв бариад, болгоомжтой явж хураахыг сануулж, дэмжлэг үзүүлнэ.

АЛТАН ҮСТ ОХИН

Шинэ үг: Дээр, доор

Үйл ажиллагаа 1. Алтан үст охин (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хормогч, ханцуйвч, будгийн нийлүүр, гуаш, гарын алчуур, хэвлэмэл зурагт хуудас

Аргачлал: Хүүхэд бүрийн урд алтан үст охины зураг байх ба зургийг ажиглана. Охины нүд, хамар, ам үс хаана байна вэ? заагаарай гэхэд хүүхэд бүр охины зураг дээр зааж нэрлэнэ. Алтан үст охины үсийг хурууны өндгөөр толболж будна. Найруулж бэлтгэсэн будагт хүүхэд хуруугаа дүрж охины үсийг багшийн дэмжлэгтэй толболон будна. Үсийг толболон будах явцдаа гарын алчуур хэрэглэнэ. Дууссаны дараа хичээлийн хэрэгслээ хурааж, гараа угааж цэвэрлэнэ.

Үйл ажиллагаа 2. Зутан (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хүүхэд бүрийн аяга, халбага, хоолны дэвсгэр, овьёос, сүү

Аргачлал: Багш асуултаар чиглүүлэн ярилцана.

- Аав баавгайн хоол ямар байсан бэ?
- Ээж баавгайн зутан ямар байсан бэ? ярилцана.

Хүүхэд бүрд хоолны дэвсгэр, аяга, халбага, ширээний голд саванд овьёос бэлтгэсэн байна. Хүүхдүүд овьёосноос өөрийн аяганд хийнэ. Овьёостой аягандаа бүлээн сүү хийж сайтар хутгана.

Багш хүүхдүүд хамтран үлээх дасгал хийж, аягатай овьёосоо үлээж хөргөнө. Халуун хоол идэхдээ үлээж хөргөж иднэ. Хэтэрхий халуун хоол гар, ам түлэх аюултай гэдгийг тайлбарлана. Аягатай овьёосоо амтархан идэж дуусаад аяга, халбага, хоолны дэвсгэрээ хураана.

Үйл ажиллагаа 3. Дээр доор (Хөгжөөн баясах)

Хэрэглэгдэхүүн: Үлгэрийн дүрүүдийн тоглоом (Хүүхэлдэй, бамбарууш, аяга, сандал, ор)

Аргачлал: Үлгэрийн дүрүүд ба эд зүйлсийг ажиглуулж ярилцана. Багш хүүхэлдэйг дээш өргөн дээр, доош буулгаж доор гэсэн үгийг хэрэглэн үзүүлнэ. Баавгайг орон дээр тавилаа, аягыг ширээн дээр байрлууллаа. Ширээн доор сандлыг хийлээ. Сандал доор бөмбөгийг байрлууллаа гэж хэлээд биечлэн хийж үзүүлнэ. Багш Алтан үст охиныг сандал дээр суулгаарай гэхэд хүүхдүүд өөрсдийн хүүхэлдэйг сандал дээрээ тавина. Алтан үст охиныг сандал доор тавиарай гэхэд хүүхдүүд өөрсдийн хүүхэлдэйг сандал доор байрлуулна. Зааврыг дахин давтан хийнэ. Үлгэрийн дүрүүдийн эд зүйлсийн байршлыг заасан үгийг (дээр доор) дагаж дуурайн хэлж дасгалыг гүйцэтгэнэ.

БААВГАЙН ДУУ

Шинэ үг: Хурдан, удаан

Үйл ажиллагаа 1. Гурван баавгай дуу (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Зурагт үзүүлэн, хуруун хүүхэлдэй, гурван баавгай дууны ая

Аргачлал: Үлгэрт дүрслэгдсэн байшингийн зургийг харуулна. Хаалга тогших чимээ гаргаж, “Байшинд хэн байна вэ?” гэж аяархан, чанга дуудна.

- “Аав баавгай би байна”, “Ээж баавгай би байна”, “Хүү баавгай би байна” гэж дуу хоолойгоо өөрчилж хуруун хүүхэлдэйг тоглуулж хэлнэ. “Гурван баавгай” дууг хөгжмийн аянд тохируулан хөдөлгөөнийг зохиомжлон дуулна.

Цахим холбоос 1-ийг ашиглаж болно.

Үйл ажиллагаа 2. Сэрсэн баавгай (Чиглүүлэгт тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Зураг, “Сэрсэн баавгай” дууны ая, баавгайн баг, өмсгөл

Аргачлал: “Сэрсэн баавгай” хөгжимт тоглоомыг үлгэрт тохируулан зохиомжилж тоглоно. Хүүхдүүд тойрог болж зогсоно. Хүүхдүүдээс нэг нь тойргийн голд унтаж байгаа баавгай болж сууна. Багш “Аав баавгай гохх гохх гээд унтаж байна, сэрчихнэ шүү чшш гэж хэлээд, хүүхдүүдийг дагуулж өлмий дээрээ зөөлөн гишгэж тойргоор удаан алхана. “Сэрсэн баавгай” дууг аяархан дуулна. Баавгай болсон хүүхэд суниах хөдөлгөөн хийхэд багш “Баавгай сэрчихлээ, зугтаарай” гэж хэлээд хүүхдүүдтэй хамт хурдан гүйн сандлын ард орж нуугдана. Цахим холбоос 2-ыг ашиглаж болно.

12 дугаар сарын II долоо хоног

БААВГАЙ ЯАГААД УУРЛАСАН БЭ?

Шинэ үг: Том, жижиг

Үйл ажиллагаа 1. Баавгай яагаад уурласан бэ? (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Хүүхэд тус бүр гэрээсээ бамбарууш авчрах, леги тоглоом

Аргачлал: Багш асуулт асууж ярилцана. 3 баавгай яагаад уурласан бэ? Чиний тоглоомыг булаагаад авбал чамд ямар санагдах вэ? гэж ярилцана. 3 баавгайны хоолыг идэж, сандлыг эвдэлж, орон дээр нь унтсан учир уурласан. Аав баавгай уурлаж архирсан. Ээж баавгай үглэсэн. Бамбарууш уйлсан. Ширээн дээр нүүрний хувирал, сэтгэл хөдлөлийн зурагт үзүүлэн байна. Хүүхдүүд 3 баавгай тус бүрийн нүүрний хувирлыг илэрхийлэн үзүүлэнг сонгож өргөөд, өөрсдөө нүүрээ хувиргаж тоглоно. Хүний эд зүйлсэд зөвшөөрөлгүй хүрэхгүй, найзаасаа тоглоом авахдаа хэрхэн гуйж авах вэ? гэдгийг багш жүжигчлэн тоглож үзүүлж, ярилцана.

Үйл ажиллагаа 2. Аяга урлацгаая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хормогч, ханцуйвч, 3 өнгийн баримлын шавар, баримлын суурь
Аргачлал: 3 өнгийн баримлын шавар нь том, дунд, жижиг хэмжээтэй хувааж бэлтгэсэн байна. Баримлын шаврыг атгаж, зөөллөж, бөөрөнхийлнө. Хамгийн том баримлын шаврыг атгаж зөөллөж, бөөрөнхийлөөд хавтгайлж аяга хийнэ. дараа нь дунд болон жижиг хуваасан баримлын шаврыг атгаж зөөллөж, бөөрөнхийлөөд хавтгайлж аяга хийнэ.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Аав баавгайн том аяга нь аль вэ? Заагаарай. Том аягыг тавиур дээр байрлуулаарай.
- Бяцхан бамбаруушийн жижиг аяга аль нь вэ? Тавиурын доор байрлуулаарай гэх мэт асуултаар чиглүүлнэ. Баримлаар бүтээл хийсний дараа хэрэглэгдэхүүнийг хурааж, гараа угаана.

Үйл ажиллагаа 3. Гэрэл сүүдрээр тоглоцгооё (Хөгжөөн баясах)

Хэрэглэгдэхүүн: Үлгэрийн дүрүүдийн сүүдэр үзүүлэн, дууны бичлэг, ая, дүрүүд, скок, өнгийн маркер, гар чийдэн

Аргачлал: Гэрэл сүүдрээр тоглох ширэм, үлгэрийн дүрүүдийг хайчилж бэлтгэнэ. Ширэмний араас гэрэл тусган үлгэрийн үйл явдал, дүрүүд хоорондын харилцаа, ярианы өнгө аяс, дуу хоолойн өнгийг өөрчилж жүжигчилж үзүүлнэ. Багш үлгэрийг өгүүлэхэд хүүхэд бүр ширэмний ард үлгэрийн дүрүүдийг хөдөлгөн, жүжиглэн тоглоход оролцоно.

БИ ХЭН БЭ?

Үйл ажиллагаа 1. Би хэн бэ? (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Үлгэрийн дүрүүдийн зурагт үзүүлэн/ бодит тоглоом

Аргачлал: Багш үлгэрийн дүрүүдийг онцлогийг хэлнэ. Хэлэхдээ тухайн дүрийн дуу хоолойгоор ярихыг хичээнэ.

- Би том биетэй. Би бүдүүн дуутай. Би ууртай-Би хэн бэ? гэж асуухад хүүхдүүд дүрийг таамаглаж нэрлэнэ. Би бол аав баавгай гэж хэлээд дүрийн зургийг харуулна.
- Би нарийхан биетэй, нарийн дуутай, хоол сайн хийдэг. Би хэн бэ? гэж асуухад хүүхдүүд дүрийг таамаглаж нэрлэнэ. Би бол ээж баавгай гэж хэлээд дүрийн зургийг харуулна.
- Би бол жижигхэн, хамгийн жижиг орон дээр унтдаг, хамгийн жижиг аяганд зутан иддэг. Би хэн бэ? гэж асуухад хүүхдүүд дүрийг таамаглаж нэрлэнэ. Би бол бяцхан бамбарууш гэж хэлээд дүрийн зургийг харуулна.
- Би алтан шаргал үстэй. Гоёмсог даашинзтай. Би гэрээсээ төөрсөн. Би бамбаруушийн сандлыг эвдэлсэн. Би хэн бэ? гэж асуухад хүүхдүүд дүрийг таамаглаж нэрлэнэ. Би бол алтан үст охин гэж хэлээд дүрийн зургийг харуулна.

Үйл ажиллагаа 2. Байрлуулаарай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Охин, 3 баавгай, 3 аяга, 3 сандал, 3 орны зурагт үзүүлэнг тойруулан хайчилж, бүрж бэлтгэх, хүснэгтэн үзүүлэн.

Аргачлал: Том хүснэгтэн үзүүлэнг самбар дээр нааж тогтоосон байна. Босоо 2 нүд, хөндлөн 2 нүд байна. Хүснэгтийн босоо нүдэнд том, жижиг баавгайг байрлуулна. Баавгайн зургийн ард нь том, жижиг аяга, сандал, орыг нэг нэгээр нь ээлжлэн олж тохируулж байрлуулна.

Хүүхэд бүрд жижиг хүснэгт, 3 баавгай, аяга, сандал орны зураг байх ба хүүхдүүд мөн адил тохируулан эд зүйлийг ээлжлэн нэг нэгээр нь дахин давтаж байрлуулна.

Үйл ажиллагаа 3. Баавгай болж тоглоё. (Хөгжөөн баясах)

Хэрэглэгдэхүүн: Баавгайн баг, маск, хувцас, охин, аяга, сандал, ор, гурван баавгай дууны ая

Аргачлал: Баавгай тус бүрд тохирох аяга, сандал, орыг хүүхдүүдийн биеийн хэмжээнд тохирохоор хийж бэлтгэхдээ эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо дэмжлэгийг аваарай. Хүүхдүүд алтан үст охин, аав баавгай, ээж баавгай, бяцхан бамбаруушийн дүрд хувирна. Багш үлгэрийн өгүүлэхэд хүүхдүүд үлгэрийн үйл явдлыг жүжигчлэн тоглоно. Үлгэрээ жүжигчлэн тоглосны дараа бүгд хамтдаа “Гурван баавгай” дууны аянд дуулж, бүжиглэнэ.

БААВГАЙН ҮҮР

Шинэ үг: Тойргоор алхах, гүйх

Үйл ажиллагаа 1. Баавгайн үүр (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Цагариг 5 ш эсвэл мөлхөлтийн хоолой, том жижиг бөмбөг, гарааны шугам, барианы шугам, том жижиг сагс

Аргачлал: Тоглоомын талбайд 5 ш цагаригийг босоогоор нь хөдөлгөөнгүй байрлуулна. Эсвэл мөлхөлтийн хоолой байж болно. Барианы шугамын хажууд том, жижиг бөмбөг, сагс байрлуулсан байна. Хүүхдүүд цагариган дундуур 4 хөллөж мөлхөн барианд ирж том, жижиг бөмбөгийг сонгож, тохирох том, жижиг сагсны аль нэгэнд нь бөмбөгийг ялгаж хийнэ. Дараагийн хүүхдүүд үргэлжлүүлэн тоглоно.

2. Баавгайн үүрэнд бөмбөг оруулъя. (Хөдөлгөөнт тоглоом)

Хэрэглэгдэхүүн: Том нүхтэй, ирмэг нь зөөлөн цаасан хайрцаг (баавгайн үүр мэт зурагтай байвал сонирхолтой) Том хэмжээтэй, зөөлөн бөмбөг

Аргачлал: Багш хүүхдүүдэд хайрцгаа “баавгайн үүр” гэж танилцуулна.

“Баавгай их унтамхай, үүр рүү бөмбөг өнхрүүлж тоглоцгооё! Баавгайд бөмбөг их таалагддаг шүү.” гэж ярьж сонирхлыг өдөөнө. Хүүхдүүд 2 багаар тоглоомд оролцоно. Том нүхтэй хайрцгийг ойр байрлуулж, эхний тоглогч бөмбөгийг хөлөөр өнхрүүлж, цаасан хайрцаг руу чиглүүлэн өнхрүүлнэ. Хөлөөр өнхрүүлэхэд хүндрэлтэй бол хүүхдэд гараараа өнхрүүлж тоглож болно.

Тайвшруулах дасгал: Гар, хөлийг дээш, доош сунгаж, гүнзгий амьсгал авч сунана.

Хүүхдийн хөгжлийн явцын үнэлгээ:

Багш та хүүхдүүдийг суралцахуйн үр дүнг эзэмшсэн байдлын явцын үнэлгээг зохион байгуулахдаа дараах арга хэрэгслээс сонгож хэрэглэж болно.

Суралцахуйн үр дүнгийн явцын үнэлгээ нь тасралтгүй үргэлжлэх бөгөөд дараагийн сард хүүхэд тухайн суралцахуйн үр дүнг эзэмшсэн байдалд ахиц гарч байгаа эсэхийг анхаарч ажиллахыг санал болгож байна.

Сонсьё, дэмжье/ Туслалцаа:

Хэлэхийг оролдож буй үгсийг баталгаажуулж, давтан хэлүүлэх, хувцсаа өмсөх, тоглоомоо сонгох сонголтыг хамтдаа хийх, оролцохгүй татгалзаж байвал хүлээн зөвшөөрч, дараа дахин оролдож үзэх боломж олгох

Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг оролцоо:

Хамтдаа ном үзэх, чанга тодоор уншиж, номын хуудас зураг дахь үгнүүдийг тайлбарлаж ярьж, давтаж хэлэх

Гэрийн орчинд байгаа эд зүйлийг нэрлэх, гэртээ саадтай зам хийж гүйж тоглох
Аягаа хураах, гутлаа зэрэгцүүлж тавих, тоглоомоо хураах зэрэг эерэг үйлийг нь магтаж
урамшуулах;

Цахим холбоос:

1. <https://youtu.be/hKp8SnszTHM>
2. <https://www.youtube.com/watch?v=kiRIQD2A78s>

<p>Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/ Амжилттай хэрэгжүүлсэн: Сул хэрэгжүүлсэн:..... Цаашид сайжруулах:..... Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:</p>

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - I САР

ӨНГӨТ САВХААР НААДЪЯ

Хүүхдийн эзэмших чадамж

Харилцах: Бусадтай ярилцах, сонсох, тоглох

Хамтран ажиллах: Бусадтай хамтран тоглох

Аюулгүй байдлын зөвлөмж:

Хөдөлгөөнт тоглоомын үед хүүхдийн аюулгүй байдалд анхаарч, тоглоомын дүрмийг биелүүлэхэд хяналт тавина. Зургийн хэрэгслийг сонгох, ажиллах үед аюулгүй ажиллагааны зааварчилгааг сануулна.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Багш болон найз нартайгаа мэндчилгээний олон хэлбэрээр мэндлэх, мөн сэтгэл хөдлөлөө үгээр болон зургаар илэрхийлэх боломж олгож, эерэг уур амьсгал бүрдүүлээрэй

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа.

- Кюизинер савхыг ашиглан том жижиг, дээр доор, дэс дараалуулан өрөх, өнгөөр ялгах, ангилах үйлдлийг хийх, тэмдэг тэмдэглэгээг ашиглах, тоглох, дуулах, хамтран бүтээл хийх явцыг чиглүүлж дэмжээрэй.

Зугаалга:

- Хүүхдийн аюулгүй байдлыг хангана. Багш, багшийн туслах хүүхэд бүрийг ажиглаж байх. Хүүхдийн анхаарал, сонирхолд нийцүүлэн үйл ажиллагааг уян хатан удирдана.

Номын цаг:

- Том зурагтай, богино өгүүлбэртэй ном уншиж өгөх. Асуулт асууж харилцан яриаг өрнүүлээрэй

Хөгжөөн баясах цаг:

- Хүүхдүүд дүрд тоглохдоо нүүрний хувирлыг илэрхийлэх, амьтдын дүрээр хөдөлгөөн хийж жүжигчилж тоглоход нь хамтран оролцоорой.

Боломжууд:

Хамтран тоглох үед тоглоомоо булаацалдах, муудалцах тохиолдол гарвал хүүхдүүдэд өөрсдөө шийдвэрлэх боломж олгоорой.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
<p>ХЯ1.1б. Ярианд хэлсэн үгийг сонсож, давтан хэлнэ.</p> <p>БНО1.1г. Байгалийн үзэгдлийг зааж нэрлэнэ.</p> <p>ХЭМ1.1л. Шатны бариулаас барьж 10 гишгүүрт өгсөж уруудна</p>	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн нэрийг дуудах, дуу чимээг ялган сонсох, тоглоом тоглох; - Байгалийн үзэгдэлтэй холбоотой хувцас сонгох, тохируулан үйлдэл хийх - Шатны бариулаас бариад, бусдын тусламжтайгаар 10 гишгүүрт өгсөж уруудах 	Өнгө
<p>МАТ1.3а. Тоглоом юмсаас тодорхой шинжтэй зүйлийг ялгана.</p> <p>ЗУ1.3в. Өрж байгуулах, эвлүүлэх аргаар тоглоом, эд юмсыг бусдын дэмжлэгтэй бүтээнэ.</p> <p>ХЭМ1.1г. Байрандаа болон чиглэлээ өөрчилж алхаж, гүйнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Нэрлэсэн тоглоомоос дуртай нэг өнгийн (шар гэх мэт) тоглоом сонгож авах; - Цаасан аяга, таваг, савхыг эгнүүлж, өрөх; - Тойргоор алхах, гүйх хөдөлгөөнийг давталттай гүйцэтгэх; 	Савхаар тоглоё
<p>ХЭМ1.2е. Хүрээлэн буй орчинд байгаа болгоомжлох зүйлсийг мэднэ. ялгана</p> <p>ХЯ1.3б. Зурган тэмдэгт тэмдэглэгээг таньж заана.</p>	<ul style="list-style-type: none"> - Зурагт үзүүлэн ашиглан анхааруулсан дүрмийг ойлгож нэрлэх - Шал болон хананд наасан зурган тэмдэглэгээг дагаж явах, мөлхөх, доогуур, дээгүүр нь гарах зэрэг зурган тэмдэгт ашигласан хөдөлгөөнт тоглоом тоглох; 	Өнгөөр тэмдэглэе
<p>ХЭМ1.1д. Сэдэвт алхалт, гүйлтийг багшийн зааврын дагуу даган дуурайж гүйцэтгэнэ.</p> <p>ХЭМ1.1о. Бөмбөгийг 1,5 м зайд өшиглөх өнхрүүлж, дамжуулна</p> <p>НСХ1.3а. Насанд хүрэгчийн тусламжтайгаар байнга хэрэглэдэг эд зүйлсийг хураадаг болно</p>	<ul style="list-style-type: none"> - Хөгжимт гимнастик, бие хөгжүүлэх цогц дасгалыг хийхдээ даган дуурайж гүйцэтгэх - Суугаа байрлалд бөмбөгийг гараар өнхрүүлнэ, барьж авах - Тоглоом эд зүйлсийн байршлыг таньж, зөв байршилд хураах 	Хөдөлгөөн
<p>ХЯ1.2в. Танил эд юмсыг нэрлэнэ</p> <p>БНО1.2в. Гэрт болон ангидаа эд зүйлсийн байрлалыг мэдэж, багшийн өгсөн энгийн зааврыг биелүүлнэ.</p> <p>НСХ1.3а. Насанд хүрэгчийн тусламжтайгаар байнга хэрэглэдэг эд юмсыг байранд нь хураана.</p>	<ul style="list-style-type: none"> - Анги, гэрийн орчинд байдаг эд зүйлсийг таньж, байрлалыг мэдэж хэлэх - Танил орчны юмс, тоглоом, эд зүйлс, амьтны нэр, энгийн үйлдэл зэргийг нэрлэх, үйл хийх - Тоглоом эд зүйлсийн байршлыг таньж, зөв байршилд хураах; 	Юмсыг байрлуулцгаая
<p>ЗУ1.2д. Бэлдэц дүрсээр бусдын дэмжлэгтэй нааж бүтээл урлана.</p> <p>НСХ1.1а. Биеийн зарим мэдрэмжээ нүүр, гар, биеийн хөдөлгөөн, дуу авиа, үгээр илэрхийлдэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Хоёр гараа үрж, халуу оргиж байгааг ажиглах, биеийн мэдрэмжээ илэрхийлэх; - Бэлэн дүрсийг бусдын дэмжлэгтэй цавуудаж наах; 	Бидний царай

<p>ХӨГ1.1в.Дуу,аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийдэг болно</p> <p>ХЭМ1.1г. Байрандаа болон чиглэлээ өөрчилж алхаж, гүйнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Дууны аялгууг сонсоод алга таших, найгах ганхах, дороо дэвсэх, дороо эргэх хөдөлгөөнийг хийх - Хөгжмийн аянд багшийг дуурайн алга таших, ширээ товших хөдөлгөөнөөр хэмнэлийг дагаж тоглох - Алхалт, гүйлтийн үед аюулгүй байдалд анхаарч, хоорондын зайг тохируулах 	<p>Алгаа таш</p>
--	---	------------------

Албан хэрэгцээнд

1 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Өнгийн хувцас	Тойргийн цаг	Багш болон найзуудтайгаа нэрээр нь мэндлэх, цаг агаар болон өвлийн хувцасны талаар ярилцах. Өмссөн хувцасны өнгийг ялгаж танихад чиглүүлнэ.	Хувцас, эд зүйлс	Өвөл ямар хувцас өмсдөг вэ? Чи ямар өнгөтэй гутал өмсөж ирсэн бэ? Хэн улаан өнгөтэй цамцтай байна вэ?	Харилцах, Нийгэм, сэтгэл хөдлөл	Асуулт, хариулт
Өнгөт савх	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд өнгийн савхнаас 3 ширхгийг сонгож авах, багшийн заавраар үйлдлийг гүйцэтгэх Өнгөөр дараалуулан байрлуулна.	Өнгийн савх (Кюизинер)	Хэнд улаан өнгөтэй савх байна вэ? Шар өнгийн савхтай хүүхдүүд юу хийх вэ?	Шүүн тунгаах, ерөх, өнгөөр ялгах, ангилал Суралцахууд суралцах багшийн зааврыг ойлгох	Тоглоом юмсаас тодорхой шинжтэй зүйлийг ялгадаг.
Өнгийн шат	Зугаалга	Цэцэрлэгээр аялах, шатны 10 гишгүүрийг тоолж, бариулаас барьж өгсөж уруудах. Шатны гишгүүрийг өнгөөр нь нэрлэх, аюулгүй байдлыг сануулна.	Шат, ханан дээрх зураг, тэмдэглэгээ	Тухайн гишгүүрийн өнгө, тоог асуух	Хамтран ажиллах, Суралцахууд суралцах	Шатны бариулаас барьж 10 гишгүүрт өгсөж урууддаг.
Амьтдын байшингууд	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Савхыг өнгө, том, жижгээр ангилан байрлуулж, савхыг эгнүүлж өрж тоглоно.	Кюизенерийн өнгөт савх (2-3 өнгө) амьтдын маркет	Бүтээлийн талаар ярилцах	Бүтээлчээр сэтгэх, Хамтран ажиллах	Тоглоомыг том жижгээр ангилдаг.
Савхан зам	Хөгжөөн баясах цаг	Өнгийн туузын дагуу савхыг зэрэгцүүлэн тавьж зам үүсгэх. Зам дээгүүр алхах, гүйх, мөлхөх, үсрэх зэрэг хөдөлгөөнөөр тоглоно.	Өнгийн савх, өнгийн тууз	Тоглоомын явцыг чиглүүлэх асуултууд		

Тэмдэг тэмдэглэгээ	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Ангийн болон ариун цэврийн өрөөний зурган тэмдэглэгээг таньж, утгыг нь ойлгох. "Гэрлэн дохио" хөдөлгөөнт тоглоомоор тоглон дохионы утгыг ойлгуулна.	Ангийн дүрмийн зурган тэмдэглэгээ, гэрлэн дохио	Энэ зураг дээр юу байна вэ? Энэ тэмдэглэгээг харвал юу хийх хэрэгтэй вэ?	Шүүн тунгаах Зургийг ялгах, Суралцахууд суралцах тэмдэг тэмдэглэгээ таних	
Номын булан	Номын цаг	Номын булан дахь тэмдэглэгээг ажиглан ярилцах, номтой хэрхэн харьцах талаар асуултаар чиглүүлэх. Дуртай номыг сонгон авч, чанга уншлагаар уншиж танилцуулна.	Ном	Номын буланд ямар тэмдэглэгээ байсан бэ? Номоо яаж хураах ёстой билээ?	Харилцах, Суралцахууд суралцах	Ярилцлагын тэмдэглэл
Өнгөт тойрог/савхаа таш таш/ савхыг онож тоглоё	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Алхах, гүйх дасгал хөдөлгөөнийг энгийн тоглоом хэрэглэгдэхүүнтэй дууны ая хэмнэлд тохируулан даган дуурайж хийнэ.	Өнгийн тууз/парабалон, өнгийн савх, Баавгай, бөмбөг, шоо, тоглоомын хайрцаг, тавиур	(Зогс дохиог хэлэх)	Шүүн тунгаах, хамтран ажиллах	Алхах гүйх хөдөлгөөнийг дуурайдаг.
Эд зүйлсээ байранд нь тавья	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Анги доторх тоглоом, эд зүйлсийг нэрлүүлэх. Тэдгээрийг тавиур, хайрцагт буцааж хураах, зөв байрлалыг тайлбарлана.	Баавгай, бөмбөг, шоо, тоглоомын хайрцаг, тавиур	Энэ юу вэ? Бөмбөгийг хаана хийх вэ?	Харилцах, эд зүйлийг нэрлэх, хураах	Эд юмсыг байранд нь хураадаг.
Өнгийн савхыг ялгая	Хөгжөөн баясах цаг	Өнгөт савхнуудыг харуулж, өнгийг нэрлүүлэх. Өнгөөр ялгасан савнуудад (улаан, шар, ногоон, цэнхэр) хураах, ангилах.	Кюизенирийн өнгөт савхнууд, өнгөөр ялгасан жижиг савнууд	Ямар өнгөтэй байна вэ? Улаан савх аль хайрцагт орох вэ?	Шүүн тунгаах Ангилах ялгах, Суралцахууд суралцах хураах	Тоглоомыг заасан байрлалд тавьдаг.
Тоглоомын аялал	Зугаалга	Хүүхдүүд өөрсдийн сонгосон тоглоомоо (бөмбөг, машин г.м.) авч гарах, тоглоомын зааврыг танилцуулах.	Бөмбөг, машин, хүүхэлдэй, хувин, сагс	Бөмбөг хаана байна вэ? Машин, хүрз, хувинг хаана хурааж тавих вэ?	Хамтран ажиллах, хамтарч хураах Харилцах тоглоомоо сонгох	Ажиглалт

		Тоглож дууссаны дараа хамтран хураах.				
Баавгай хаана байна вэ?	Номын цаг	"Баавгай хаана байна вэ?" зурагт номыг чанга уншлагаар унших. Байршлын үгсийг (дээр, доор г.м.) ойлгож, зөөлөн тоглоомыг байрлуулах даалгаврыг гүйцэтгэх	Зурагт ном, зөөлөн тоглоом (Баавгай)	Баавгай хаана байна вэ? Чи сандлын доор тавина уу?	Суралцахууд суралцах, зааврыг ойлгох, дагах Харилцах Хамтдаа ном унших	Юмсыг дээр доор байрлуулдаг.
Миний царай	Чиглүүлэгтэй тоглоом, ажиллагаа үйл	Дугуй цаасан дээр нүд, хамар, ам, хөмсгийг цавуудаж, нүүр царай бүтээн урлах. Сэтгэл хөдлөлийн талаар ярилцаж, бүтээлээ тайлбарлана.	Царайны хэлбэртэй дугуй цаас, нүд, ам, хамар, хөмсөгний дүрс, цавуу	Баяртай, ууртай, гунигтай аль нь байсан бэ? Чиний хийсэн царай ямар байна вэ?	Бүтээлчээр сэтгэх. Наах, бүтээх Нийгэм, сэтгэл хөдлөл сэтгэлийн хөдлөлөө нүүрний хувирлаар илэрхийлэх	Бэлдэц дүрсээр бусдын дэмжлэгтэй нааж бүтээл урладаг.
Миний сэтгэл хөдлөл ба царай	Тойргийн цаг	Мэндчилэх, гар үрж биеийн мэдрэмжээ хэлэх. Сэтгэл хөдлөлийн зураг үзүүлж, нүүрний хувирал, дуу авиа, үгээр илэрхийлэхийг дэмжинэ.	Самбар, нүүр царайны хувирлын зургууд, хөгжим	Гар нь юу мэдэрч байна вэ? Чи уурласан царай гаргаж чадах уу?	Нийгэм, сэтгэл хөдлөл: сэтгэлийн хөдлөлөө нүүрний хувирлаар илэрхийлэх	
Алгаа таш таш	Чиглүүлэгтэй тоглоом, ажиллагаа үйл	Дууны аянд тохируулан алга таших, дороо алхах, эргэх, алга ташиж хэмнэлийн дасгал хийнэ.	"Алгаа таш" дууны ая, Цахим холбоос 2, Цагариг, хэмнэлийн дасгалын ая, цахим холбоос 4	Багшийн хөдөлгөөнийг дуурайхыг чиглүүлэх	Хамтран ажиллах, хөдөлгөөнийг хэмнэлд тохируулах	Хөгжмийн аянд тохируулан хөдөлгөөн хийдэг.

1 дүгээр сарын I долоо хоног

ӨНГӨ

Шинэ үг: Өнгө, шатны гишгүүр

Үйл ажиллагаа 1. Өнгийн хувцас (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Хувцас

Аргачлал: Багш болон хүүхдүүд бие биетэйгээ нэрээр нь дуудаж, “Сайхан амарсан уу?” гэж мэндэлнэ. Хүүхэд бүр мэндчилгээ болон найзынхаа нэрийг давтаж хэлнэ. Тухайн өдрийн цаг агаарын талаар ярилцана. Өвөл ямар хувцас өмсдөг талаар ярилцана. Багш өнөөдөр хийх үйл ажиллагааг танилцуулж, сонирхлыг нь төрүүлнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Өвөл ямар хувцас өмсдөг вэ?
- Чи ямар өнгөтэй гутал өмсөж ирсэн вэ?
- Найзын чинь цамц ямар өнгөтэй байна вэ?
- Хэн улаан өнгөтэй цамцтай байна вэ? Гараа өргөөрэй.

Үйл ажиллагаа 2. Өнгөт савх (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Өнгийн савх

Аргачлал: Хүүхдүүд өнгийн савхнаас 3 ширхгийг сонгож авна. Багшийн зааврын дагуу үйлдлийг гүйцэтгэж тоглоно.

- Хэнд улаан өнгөтэй савх байна вэ? өргөөрэй.
- Шар өнгийн савхтай хүүхдүүд сандал дээр суугаарай.
- Ногоон өнгийн савхтай хүүхдүүд ногоон сагсанд хийгээрэй
- Улаан, цэнхэр, шар өнгийн дарааллаар савхаа ширээн дээр байрлуулаарай

Үйл ажиллагаа 3. Өнгийн шат (Зугаалга)

Аргачлал: Бүгдээрээ цэцэрлэгээр аялцаа. Хүүхдүүд шатны 10 гишгүүрийг тоолж, өгсөж алхана. Хоёрдугаар давхарт гармагц ханан дээрх зураг, тэмдэг тэмдэглэгээ болон коридорт байрласан тоглоомыг хамтдаа ажиглан ярилцана.

Бидний аялал дууслаа, одоо анги руугаа буцъя гэж багш уриална. Шатаар буухдаа хүүхдүүд гишгүүр бүрийг өнгө өнгөөр нь нэрлэн, болгоомжтой алхахад багш дэмжлэг үзүүлнэ. Ангидаа орсны дараа гараа угааж, амарна.

САВХААР ТОГЛОЁ

Шинэ үг: Том, жижиг

Үйл ажиллагаа 1. Амьтдын байшингууд” (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Кюизенерийн өнгөт савх (2-3 өнгө) амьтдын маркет

Аргачлал: Савхыг өнгө, том, жижгээр ангилан байрлуулна. 2–3 өнгийн савх, 2–3 амьтны маркет гаргаж тавина. “Энд савхнууд байна. “бас амьтад байна.” гэж харуулж танилцуулна. “Амьтдад байшин барья, “Энэ улаан савх улаан савхаар улаан байшин барья.” “Энэ байшин дугуй хэлбэртэй” шар савхаар барья (Савхнуудыг тойруулж тавина) “Энэ нь дөрвөлжин байшин.” Амьтдыг сонгож байшинд байрлуулж тоглох, бүтээлийн талаар ярилцах “Туулайд том байшин хийе.” “Бид дөрвөлжин байшинг урт байшин болгож өөрчилж тоглоцгооё.

Үйл ажиллагаа 2. Савхан зам (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Өнгийн савх, өнгийн тууз

Аргачлал: Хүүхэд бүр өнгийн савхнаас нэгийг сонгон авна. Багш өнгийн туузын дагуу савхыг зэрэгцүүлэн хэрхэн байрлуулахыг үзүүлнэ. Хүүхдүүд багшийн зааврын дагуу савхаа өнгийн туузын дагуу тэгш, зэрэгцүүлэн тавьж савхан зам үүсгэнэ. Савхан зам дээгүүр хөлөө солбиж цуварч алхана. Тоглоомоо үргэлжлүүлэн тууз, савх хоёрын дундуур зам үүсгэж гүйх, мөлхөх, үсрэх зэрэг хөдөлгөөнөөр баяжуулан тоглоно.

ӨНГӨӨР ТЭМДЭГЛЭЭ

Шинэ үг: Анхааруулах, хориглосон тэмдэглэгээ

Үйл ажиллагаа 1. Тэмдэг тэмдэглэгээ (чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ангийн дүрмийн зурган тэмдэглэгээ, гэрлэн дохио

Аргачлал: Багш анги болон ариун цэврийн өрөөний зурган тэмдэглэгээг тайлбарлана. Хүүхэд ариун цэврийн өрөөний эрэгтэй, эмэгтэй тэмдэглэгээ, гэрлэн дохионы зураг, тоглоомоо булаацалдаж болохгүй гэх мэт ангийн дүрмийн зурган тэмдэглэгээг таньж богино хариулт өгөх, дохио зангаа, хуруугаар зааж тайлбарлан ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ зураг дээр юу байна вэ?
- Энэ тэмдэглэгээг харвал юу хийх хэрэгтэй вэ?

Хөдөлгөөнт тоглоом: “Гэрлэн дохио”

Багш гэрлэн дохионы тэмдэглэгээг нэг нэгээр нь өргөж үзүүлнэ. Хүүхдүүд багшийн зааврын дагуу ногоон гэрлийн дохиог өргөвөл хурдан алхана, шарыг өргөвөл гараа алдалж зогсоно. Улааныг өргөвөл гараа буулгаж зогсож тоглоно.

Үйл ажиллагаа 2. Номын булан (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Ном

Аргачлал: Номын булан дахь тэмдэглэгээг ажиглаад ярилцана. Хүүхдүүд өөрсдийн дуртай номоо сонгон авч тойргоор сууцгаана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Номын буланд ямар тэмдэглэгээ байсан бэ?
- Хориглосон тэмдэглэгээ байсан уу?
- Номоо яаж хураах ёстой билээ?

Хүүхдүүдийн сонирхсон номыг чанга уншлагын арга зүйгээр уншиж танилцуулна.

ХӨДӨЛГӨӨН

Шинэ үг: Анхаар, зогс

Үйл ажиллагаа 1. Өнгөт тойрог

Хэрэглэгдэхүүн: 2-3 метр урттай өнгийн тууз эсвэл парабалон, цахим холбоос 1 аяыг ашиглана,

Аргачлал: Багш “АЛХААРАЙ”, “ГҮЙГЭЭРЭЙ”, “ЗОГС” дохиогоор удирдана. Хөгжмийн аянд гүйцэтгэж болно. Өнгийн туузуудын нэг үзүүрийг багцлан холбож багш барина, нөгөө үзүүрийг хүүхэд бүр барьж (гэр хэлбэртэй) тойргоор зогсоно.

Алхаарай гэхэд дороо алхана. Зогс – дороо хөдөлгөөнгүй зогсоно.

Тойроод алхаарай гэхэд тойргоор алхана. Зогс.

Хурдан алхаарай гэхэд дороо хурдан алхана. Зогс.

Гүйгээрэй – гэхэд дороо хөнгөн гүйнэ. Зогс.

Ал-хаад гэж удаан хэлэхэд дороо удаан жингүйдэх мэт алхана. Зогс.

Хүүхдийн гүйцэтгэх чадвараас хамаарч дасгалын давтамжийг тохируулна. Зогс дохиог ойлгуулснаар хүүхдийн анхаарлыг төвлөрөлтийг нэмэгдүүлэхээс гадна осол гэмтлээс урьдчилан сэргийлэхэд дадал болоход тусална.

2. Савхаа таш таш

Хэрэглэгдэхүүн: Өнгийн савх

Аргачлал: Хүүхдүүд тойргоор алхаж өнгийн савхнаас хоёрыг аваад зогсоно. Багш дасгалыг биечлэн хийж тайлбарлана. Хүүхдүүд багшийг даган дуурайж тайлбарыг давтаж хэлнэ.

1-2. Товш товш (өнгөт савхаа товшино)

3-4. Алх, алх

5-6. Товш товш

7-8. Үсэр үсэр

Багш дасгалыг үргэлжлүүлэн зохиомжлон баяжуулна. Хэрэглэгдэхүүнээ багшийн чиглүүлэгтэй хурааж байрлуулна.

3. Өнгөт савхыг оноё

Хэрэглэгдэхүүн: Өнгийн савх, жижиг бөмбөг

Аргачлал: Өнгийн савхыг босоо байрлалд эгнүүлэн газарт тавина. Хүүхэд бүр гурван бөмбөг авч газар суугаад жижиг бөмбөгөө өнхрүүлж ононо. Бөмбөгийг хэт хүчтэй өнхрүүлэхгүй байхыг сануулна. Найзыгаа хүлээж бөмбөгөө ээлжлэн өнхрүүлэхийг тайлбарлана.

Тайвшруулах дасгал тоглоом. Хургачин хүү
Хүүхдүүд тойргоор газар хөлөө жийж сууна.

- Хургачин хүү хургаа хариулаад явлаа гэхэд гараа урагш өргөсөн байрлалаас ээлжлэн өргөж буулгана
- Хурганууд ийш тийш гүйлдэнэ гэхэд хөлийн өлмийг ээтийлгэж жийнэ
- Хургачин хүү хургаа барилаа гэхэд урагш бөхийж хөлийн хуруунуудыг барина
- Хэдэн хурга барьсан бэ? гэж асуухад хөлийн хурууг тоолно.

Намуухан аянд хүүхдүүд амьсгалын дасгал хийнэ.

1 дүгээр сарын II долоо хоног

ЮМСЫГ БАЙРЛУУЛЦГААЯ

Шинэ үг: Шоо

Үйл ажиллагаа 1. Эд зүйлсээ байранд нь тавья (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Баавгай, бөмбөг, шоо, ном гэх мэт тоглоомын хайрцаг, номын тавиур, тоглоомын шургуулга, танил эд зүйлсийн зураг

Аргачлал: Багш анги доторх тоглоом, эд зүйлсийг зааж нэрлүүлнэ. Дараа нь “Эд зүйлсээ байранд нь буцааж тавья” гэж уриалан, байрлалыг зааж хамтдаа хураана. Хүүхэд андуурвал багш зөв байрлалыг тайлбарлан тусалж, зөв хийсэн тохиолдолд урамшуулна

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ юу вэ?
- Баавгай хаана байх ёстой вэ?
- Бөмбөгийг хаана хийх вэ?
- Номоо хаана тавих вэ?”

Үйл ажиллагаа 2. Өнгийн савхыг ялгая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Кюизенирийн өнгөт савхнууд, өнгийн савнууд (улаан, шар, ногоон, цэнхэр)

Аргачлал: Багш өнгөт савхнуудыг харуулж, өнгийг нэрлүүлнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ юу вэ?, Ямар өнгөтэй байна вэ?
- Хөх савхыг хаана тавивал зөв бэ?

Улаан савх аль хайрцагт орох вэ? асуултаар чиглүүлж ярилцана. Дараа нь “Өнгөөр нь ялгая” гэж уриалан, савх болон өнгийн савнуудыг талбайд байрлуулна. “Савхнууд гэртээ харьж байна” гэж хэлэхэд Улаан савх аа — улаан гэртээ! Хөх савх аа — хөх савандаа! Ногоон савх аа — ногоон гэрт суугаарай гэж аялгуулан дуулж тоглож, өнгөөр нь ялган сав, хайрцагт хийж тоглож хураана.

Үйл ажиллагаа 3. Тоглоомын аялал (Зугаалга)

Хэрэглэгдэхүүн: Бөмбөг, машин, хүүхэлдэй, хүрз, хувин, сагс

Аргачлал: Хүүхдүүд хувцаслахыг хянах, аюулгүй байдлын санамж өгнө. Хүүхдүүд тоглоомуудаас сонгон авч гарах боломж олгоно, багш тоглоомын зааврыг танилцуулна. Тоглоомыг нэрлүүлэх, тавьсан байрлалыг ажиглах, асууж тодруулан ярилцана. Үйл ажиллагааны дараа хамтран тоглоомоо хурааж, зөв хийж байгаа хүүхдийг урамшуулна. Зугаалгын төгсгөлд тойргоор зогсож, хүүхдүүд хэрхэн тоглосон талаар санаа бодлоо хуваалцах, дараа юу хийх хүсэлтэй байгааг ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ юу вэ?, Бөмбөг хаана байна вэ?
- Яаж тоглосон бэ? Бөмбөгийг хаана хийсэн бэ?
- Машин, хүрз, хувинг хаана хурааж тавих вэ?

Үйл ажиллагаа 4. Баавгай хаана байна вэ? (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: “Баавгай хаана байна вэ?” сэдэвт зурагт ном (ижил төстэй ном), зөөлөн тоглоом

Аргачлал: Баавгай хаана байна вэ? зурагт номыг чанга уншлагаар уншиж өгнө. "Баавгай ширээн доор байна" модны дээр гарчхаж гэм мэт өгүүлбэртэй хуудас үзүүлж, асууж ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Баавгай хаана байна вэ?
- Чи хаана сууж байна вэ? сандал дээр үү, газар дээр үү?
- Би баавгайг сандал дээр тавилаа. Чи сандлын доор тавина уу?.

Хүүхдүүд ээлжлэн баавгайг өөрсдөө байрлуулна. Зөв байрлуулахад дэмжлэг үзүүлж урамшуулна.

БИДНИЙ ЦАРАЙ

Шинэ үг: Царай, гунигтай

Үйл ажиллагаа 1 Миний царай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Царайны хэлбэртэй дугуй цаас, нүд, ам, хамар, хөмсөгний жижиг дүрснүүд, цавуу

Аргачлал: Хүүхдүүд дугуй цаасан дээр нүд, хамар, ам, хөмсгийг цавуудаж нүүр царай бүтээнэ. Багш сэтгэл хөдлөлийн талаар ярилцаж, хүүхдэд өөрийн хийсэн царайгаа тайлбарлуулахыг дэмжинэ. "Энэ бол би. Би баяртай байна" гэх мэт хэллэгийг хэрэглүүлж, зөв хэлсэн болон бүтээлдээ урам өгч магтана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Өнөөдөр чи баяртай, ууртай, гунигтай аль нь байсан бэ?
- Баяртай царай хийх үү, эсвэл гунигтай царай юу?
- Чиний хийсэн царай ямар байна вэ?"

Үйл ажиллагаа 2. Миний сэтгэл хөдлөл ба царай (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Самбар, нүүр царайны хувирлын зургууд, хөгжим

Аргачлал: Хүүхдүүд тойргоор дэвсгэр дээр сууж, багш мэндэлж, нэрээ хэлэх мэндчилгээний үг хэлнэ. Гараа үрж, хацартаа нааж халуун эсвэл хүйтэн байгаа мэдрэмжээ хэлнэ. Дараа нь сэтгэл хөдлөлийн зураг үзүүлж, хүүхдүүдээс тухайн царай ямар байгааг асууж ярилцана. Зургийг харж нүүрний хувирал, хөдөлгөөн, дуу авианы тусламжтайгаар сэтгэл хөдлөлөө илэрхийлэхийг дэмжинэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Сайхан амарцгаасан уу?
- Гар нь юу мэдэрч байна вэ?
- Энэ хүүхэд ямар царайтай байна вэ?
- Чи уурласан царай гаргаж чадах уу?
-

АЛГАА ТАШ

Шинэ үг: Алга таших

Үйл ажиллагаа 1. Алгаа таш таш (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: "Алгаа таш" орчуулгын дууны ая,

Аргачлал: Багш "Алгаа таш" дууг дуулж хөдөлгөөн үзүүлэхэд хүүхдүүд аяны хэмнэлд тохируулан дуурайн алга ташиж, дороо алхаж, эргэн хөдөлгөөн хийнэ. Цахим холбоос 2-ыг ашиглаж болно.

2. Аяыг сонсоорой

Хэрэглэгдэхүүн: Цагариг, "Алгаа таш" дууны ая

Аргачлал: Хүүхэд бүрийг нэг нэг цагариганы голд зогсохыг сануулна. "Алгаа таш" дууны аяыг явахад цалгираг дотор алхах, алга таших хөдөлгөөнийг багшийг дагаж хийнэ. Ая зогсоход доош сууна. Цахим холбоос 3-ыг ашиглаж болно.

3. Хэмнэлээр наадъя

Хэрэглэгдэхүүн: Хэмнэлийн дасгалын ая

Аргачлал: Хүүхдүүд ширээнд суусан байна. Дууны ая, хэмнэлд тохируулж багшийг даган, ширээн дээр гараа зөөлөн тогшиж тоглоно.

Цахим холбоос 4-ийг ашиглаж болно.

Сонсъё, дэмжье/ Туслалцаа:

- Бүрэг, ичимхий, өөрийгөө илэрхийлэхэд дэмжлэг хэрэгтэй хүүхдийг ажиглан, түүний сонирхол, дуртай тоглоомоор тоглуулах замаар бусадтай хамтран оролцох нөхцөлийг бүрдүүлнэ
- Нүдээр харилцах, инээмсэглэх, энгийн үг, дохио, үйлдлээр ойлголцох харилцааг тогтвортой байлгаж, итгэлцлийг бий болгоно.

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Өдөр тутмын үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход хүүхдэдээ дэмжлэг үзүүлж, дуу шүлэг хамтдаа давтах
- Эцэг эх цэцэрлэгээс харих үедээ хамтдаа юу хийх, хэрхэн цагийг үр бүтээлтэй өнгөрөөх талаар тайлбарлаж өгөх
- Хүүхэдтэйгээ харилцан ярилцах, үлгэрийн дүрд хувирч хувцаслахад дэмжих

Цахим холбоос:

1. https://www.youtube.com/watch?v=NweJhoEmnfY&list=PLCu9eixEqKMuopPi_1e3pnbJVfITmftjL
2. https://www.youtube.com/watch?v=tWT_xoG0ums
3. https://www.youtube.com/watch?v=Ldx8bSrmSDE&list=RDLdx8bSrmSDE&start_radio=1
4. <https://www.youtube.com/watch?v=5he1sCixSLM>

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/
 Амжилттай хэрэгжүүлсэн:
 Сул хэрэгжүүлсэн:.....
 Цаашид сайжруулах:.....
 Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - II САР**ЦАГААН САР****Хүүхдийн эзэмших чадамж:**

Нийгэм сэтгэл хөдлөлийн хөгжил: Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөл, мэдрэмжийг ойлгох, илэрхийлэх;

Үндэсний өв соёл: Мэндлэх, золгох зан үйлийг даган дуурайх, бие даан хийхийг оролдох

Аюулгүй байдлын зөвлөмж:

Сургалтын хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу хэрэглэх, тоглоомоо хураах, зугаалгаар гарах үед болгоомжлох үйлийг биечлэн үзүүлнэ.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Багш олон найз нартайгаа мэндлэх, золгох үйлийг даган дуурайж хийнэ.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Хүүхдийн сонирхол оролцоог дэмжих, хүүхдийн үйлдлийг анзаарах, сонирхож буй зүйлсийг чиглэл болгон ашиглах, асуулт тавьж харилцан ярилцах, тэдний мэдрэмж, илэрхийлэмжийг дэмжинэ.

Зугаалга:

- Цэцэрлэгийн номын сангаар аялж ном үзэх, зан заншлын өргөө, ахлах анги бүлгүүдээр орж сонирхон, тоглоно.

Номын цаг:

- Өөрийн сонирхсон зурагт номоо үзэх, номын хуудсыг эргүүлж, амьтан, өнгө, эд зүйлсийг нэрлэх, заах, нэрлэсэн зүйлийг олоход нь дэмжлэг үзүүлнэ.

Хөгжөөн баясах цаг:

- Хөгжимт хөдөлгөөнийг даган дуурайх, биеийн хөдөлгөөнөө удирдах, үлгэрийн баатрууд, амьтдын хөдөлгөөн, дуу хоолойг даган дуурайх, төрөл бүрийн наадгай хэрэглэгдэхүүнээр дүрслэн тоглох үйлийг хамтран хийнэ.

Боломжууд:

Хүүхэд дээл, малгай, бүсийг ялгаж таних, нэрлэж сурахад нь дэмжлэг үзүүлэн бодит дээл өмсөж үзүүлэх, өмсөхөд нь туслах, зурагт үзүүлэнг харуулах, ярилцах.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
БНО1.2д. Үндэсний хувцас (малгай, дээл, гутал)-ыг таньж нэрлэнэ. МАТ1.3в. Юмсын байршлыг танина. (дээр, доор) ХЯ1.1а. Бусдын яриаг сонсоод ойлгосноо үг үйлдлээр илэрхийлнэ.	<ul style="list-style-type: none"> - Малгай, дээл, гутлыг бусад хувцсаа ялгаж заах, нэрлэх, ярих; - Хүүхэлдэйг хувцаслах, өөрөө дээл өмсөж үзэх, үндэсний хувцсаа өмсөж баярын үйл ажиллагаанд оролцох; - Нэрлэсэн байршилд (дээр, доор) юмсыг тавих; - Танил хүмүүсийн үгийг давтаж хэлэх, үйлдлийг дагаж хийх, хийж буй үйлдлийг үгээр илэрхийлэх, хэлсэн зүйлийг авчрах, зааврыг биелүүлэх үгэн болон хөдөлгөөнт тоглоом тоглох; 	Монгол хувцас
ХЯ1.3.а. Номыг сонирхож үзнэ. НСХ1.3в. Насанд хүрэгчийн тусламжтай өдрийн дэглэмийн үйл ажиллагаанд дасан зохицож оролцдог болно.	<ul style="list-style-type: none"> - Том тод зурагтай, хүрч мэдэрдэг, эвлүүлдэг, онгойлгодог хэсэгтэй, энгийн өгүүлэмжтэй, дахин давтагддаг үг хэллэгтэй ном үзэх сонирхох үйлийг дэмжих; - Номын хуудсыг эргүүлж, амьтан, өнгө, эд зүйлийн зургийг ажиглаж, хуруугаар зааж, чанга дуугаар нэрлэх, нэрлэсэн зүйлийг олох; 	Номын хуудас
МАТ1.3а. Тоглоом, юмсыг тодорхой нэг шинжээр ялгана. ХЯ1.1б. Ярианд хэлсэн үгийг сонсож, давтан хэлнэ.	<ul style="list-style-type: none"> - Багшийн зааврын дагуу улаан өнгийн тоглоомыг хайрцаг, сагсанд ялган хийх; - Үгийг удаан, тод, ойлгомжтой хэлэх, танил үгсийг сонсоод дуурайх, давтан хэлэх, зургийг заах, зөв дуудлагаар хэлэх, тогтоох зэрэг үйл хийх; 	Өнгөтэй танилцъя
ХӨГ1.1б. Дууг анхааралтай сонсож, зарим үг, авиаг дуурайн хэлж, аялна. ХӨГ1.1в. Дуу, аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Дууг сонсоод дагаж аялахыг оролдох, бувтнах; - Дууны аялгууны хурд, хэмнэлийг мэдэрч, алхах, гүйх, алга таших, гар эргүүлэх гэх мэт хөдөлгөөнийг бусдыг дагаж хийх; 	Дуулж бүжиглэе

<p>НСХ1.2в. Насанд хүрэгчийн тусламжтай зарим зан үйлүүдийг таньдаг болно. ХЯ1.1б. Хэлсэн үгийг сонсож, давтан хэлнэ. ХЯ1.1а. Бусдын яриаг сонсоод ойлгосноо үг үйлдлээр илэрхийлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Зан үйлтэй зургийг харж ярилцах, нэрлэсэн зургийг заах, зурагтай адил хөдөлгөөн хийж тоглох; - Золгох үйлдлийг дагаж хийх, хийж буй үйлдлийг үгээр илэрхийлэх, хөдөлгөөнөөр илэрхийлэх; - Үгийг удаан, тод, ойлгомжтой хэлэх, танил үгсийг сонсоод дуурайх, давтан хэлэх; 	<p>Амар байна уу?</p>
<p>ЗУ1.2в. Бусдын дэмжлэгтэйгээр толбо, дардсаар зурна. ЗУ1.3а. Баримлын шавраар нэг бүтэцтэй зүйлийг бусдын дэмжлэгтэй барьж бүтээнэ. ХЭМ1.2а. Хувийн ариун цэврийг сахих үйлийг насанд хүрэгчийн дэмжлэгтэйгээр хамтран хийнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Өөрийн бүтээлээ харж баярлах, аарцаар ааруул хэвлэх - Баримлын шаврыг тасалж, базаж, зөөллөж гарын алганд бөөрөнхийлөх, хавтгайлах; - Насанд хүрэгчдийн тусламжтайгаар гар нүүрээ угаах 	<p>Зурж урлая</p>
<p>ХЭМ1.1г. Байрандаа болон чиглэлээ өөрчилж алхаж, гүйнэ. ХЭМ1.1м.Бөмбөгийг ойр зайд шидэж дамжуулна, барьж авна. ХӨГ1.1в Дуу, аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Дасгалыг зэрэг болон ээлжлэн хийх; зааврыг биелүүлэх үгэн болон хөдөлгөөнт тоглоом тоглох; - Хөгжмийн аянд багшийг дуурайн, алга таших, ширээ товших хөдөлгөөнөөр хэмнэлийг дагаж тоглох; - Дууны аялгууг сонсоод, алга таших, найгах ганхах, дороо дэвсэх, дороо эргэх гэх мэт хөдөлгөөнийг хийх; 	<p>Чийрэг болцгооё</p>

2 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Миний дээл	Тойргийн цаг	Монгол үндэсний хувцас болох дээл, бүс, малгай, гутлыг таньж нэрлэх, өмсөх Багшийг ажиглан даган дуурайж хувцаслахыг оролдох. Юмсыг нэрлэсэн байршилд (дээр, доор) тавих үйлийг давтана.	Монгол үндэсний хувцас.	Дээлээ эвхээд сандал дээр тавиарай. Дээлэн дээр бүс, бүсэн дээр малгайгаа тавиарай.	Үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах, өвлөх. Харилцах Асуулт, хариулт	Үндэсний хувцсыг зураг болон бусад хувцаснаас таньж нэрлэдэг
Хос гутал	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Монгол гутлын зургуудыг анги дотор энд тэнд (ширээ/сандал/тавиурын доор) байршуулж, ижил гутлыг олно. Юмсын байршлыг таних (дээр, доор).	Монгол гутлын зураг (хүүхэд бүрд).	Хаанаас олсноо бие биедээ хэлж зааж ярилцана.	Шүүн тунгаах Тоглоомыг тодорхой нэг шинжээр ялгах	Тоглоом эд зүйлсийг дээр, доор нэрлэсэн байршилд байрлуулдаг.
Найзаа хувцаслая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхэлдэйг үндэсний хувцсаар хувцаслах, хувцасны нэрийг давтаж хэлэх. Үндэсний хувцсаа өмсөж баярын үйл ажиллагаанд оролцохыг чиглүүлнэ.	Эрэгтэй, эмэгтэй хүүхэлдэй, зурагт хуудас (наадаг зангуутай).	Энэ юу вэ?	Үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах, өвлөх үндэсний хувцсыг таних	Олон төрлийн хувцаснаас дээл, малгай, бүс, гутлыг таньж нэрлэдэг.
Номын хуудас эргүүлэх	Номын цаг	Том, тод, энгийн өгүүлэмжтэй ном үзэх сонирхлыг дэмжих. Номын хуудсыг эргүүлж, амьтан, өнгө, эд зүйлсийг нэрлэх, олох.	Том, жижиг зурагт ном.	Хуудсаа эргүүлээрэй. Ямар зураг гарч ирсэн бэ? Нэрлээрэй. Дараагийн хуудас дээр юу байна вэ?	Суралцахууд суралцах	Номын хуудсыг өөрөө эргүүлж, зургийн үйл явдлыг дуурайж, дүрсэлдэг.
Өнгөт зайрмаг	Хөгжөөн баясах цаг	Улаан, шар, хөх өнгөөр танилцах. Зайрмагийн аяганы өнгөтэй ижил өнгийн бөмбөг сонгож байрлуулах.	Хуванцар бөмбөгнүүд, зайрмагийн аяга (улаан, шар, хөх).		Шүүн тунгаах Тоглоом, юмсыг тодорхой шинжээр ялгах Харилцах: Үгийг сонсож давтан хэлэх	Улаан, шар, хөх өнгийг ялгадаг
Өнгөөр ялгая	Чиглүүлэгтэй	Улаан, шар, хөх өнгийн	Хуванцар		Хамтран ажиллах	Ижил өнгийг

	тоглоом, үйл ажиллагаа	бөмбөлгийг ижил өнгийн цаасан аяганд ялган хийнэ.	бөмбөгнүүд (улаан, шар, хөх), цаасан аяга (улаан, шар, хөх).		(хамтран тоглох) Шүүн тунгаах.ялгах ангилал	ажиглан байрлуулж тоглодог.
Алгаа ташаарай	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Алгаа ташаарай" дууг сонсож, зарим үг, авиаг дуурайн хэлж, аялах, хэмнэлд тохируулан хялбар хөдөлгөөн хийнэ.	Дууны ая, гэр бүлийн тухай зурагт үзүүлэн.	Аав ээж, эмээ өвөө, ах эгч аль нь вэ?	Бүтээлчээр сэтгэх Хялбар хөдөлгөөн зохиомжлох	Хөгжмийн аян, дууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийдэг.
Бидний хувцас	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Монгол хувцасны хөдөлгөөнүүдийг (малгай өмсөх, бүс бүслэх, гутлын өсгий товших) дууны аянд хийх.	"Бидний хувцас" дууны ая.	Энэ юу вэ?	Үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах, өвлөх; Харилцах. Асуултыг ойлгох	Хөгжмийн аян, дууны хэмнэлд тохируулан хөдөлгөөнөөр дагадаг
Золгоцгооё	Тойргийн цаг	Багш, багшийн туслахын мэндлэх, золгох үйлийг даган дуурайх. Хос хосоороо золгож тоглох, ямар баяраар золгодог талаар ярилцана.	Хадаг.	"Амар байна уу?" та гэж мэндлэх, "Мэндээ" гэж хариулах. Ямар баяраар золгодог талаар ярилцана.	Үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах, өвлөх Мэндлэх, золгох зан үйлийг хийхийг оролдох	Багштайгаа мэндэлдэг.
Ах нартайгаа зочлоё	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Ахлах, бэлтгэл бүлэгт зочлон айлчилж, тэдэнтэй мэндлэх, золгох, хооллох үйлийг хийж, цагаан сар сэдэвт тоглоомоор хамтран тоглож баярын зан үйлд суралцана.	Ахлах/бэлтгэл бүлгийн анги (үндэсний хувцас, идээ зассан орчин).		Хамтран ажиллах; Үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах, өвлөх.	Баярын зан үйлд оролцдог.
Усан доторх зураг	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Амны цаасаар далдлагдсан монгол хувцас, сүү гэх мэт хэвлэмэл зургийг савтай усанд хийж, цаас норж зураг тодорч гарахыг ажиглана.	Савтай ус, амны цаас, монгол хувцас/сүүний зураг.		Суралцахууд суралцах Туршилт хийх; Харилцах Тодорсон зургийг нэрлэх.	Зургийн ажиглан нэрлэдэг.
Шидэт зураг	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Лаагаар зурсан монгол хувцсыг усан будгаар будах үед зураг тодорч гарахыг ажиглана.	Лаагаар зурсан монгол хувцасны зураг, бийр, усан	Будаж дуусахад юуны зураг тодорсныг нэрлэнэ.	Бүтээлчээр сэтгэх зурах будах Харилцах (нэрлэх).	Бийр, усан будгаар зурж урлахыг оролддог.

			будаг.			
Ааруул	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Аарцыг гялгар уутанд хийж шахах, төрөл бүрийн хэлбэртэй хэвээр хэвлэнэ.	Аарц, гялгар уут, хэв, таваг, элсэн чихэр, амны халбага		Бүтээлчээр сэтгэх барих наах	Баримлын шавраар нэг бүтэцтэй зүйлийг барьж бүтээдэг.
Бяцхан амьтдын алхаа	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	12 жилийн амьтдын алхааг дуурайж, саадыг сүлжиж/давж алхана.	Конус хэлбэртэй өнгийн саад, 5-10 см-ын өндөртэй саад.	Та нар ямар ямар амьтан мэддэг вэ? 12 жилд ямар амьтад байдаг вэ? Тэр амьтан яаж алхдаг вэ? Алхаж үзүүлээрэй. Хамтдаа дуурайж алхъя.	Бүтээлчээр сэтгэх хөдөлгөөнийг дуурайх Хамтран ажиллах.	Амьтдын хөдөлгөөний дуурайн хийхийг оролддог.
Гараар наадъя	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Сарвууны үеэр тойргоор эргүүлэх, атгах, хуруунуудыг салгах зэрэг дасгалуудыг бие эрхтний нэрийг хэлж гүйцэтгэнэ.	Хөгжим дасгал.		Харилцах нэрлэх асуултыг ойлгох Нийгэм, сэтгэл хөдлөл.	Биеийн хэсгүүдийг нэрлэх Дасгалын дуурайн хийхийг оролддог.
Хурдан дамжуулъя	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд бие биедээ бөмбөг дамжуулан өгөх тоглоом тоглоно.	Бөмбөг (5-10см-ын диаметр)	Багшийн "Дамжуулаарай" дохио.	Хамтран ажиллах хамтран тоглох	Бөмбөгийг дамжуулж тоглодог.

2 дугаар сарын I долоо хоног

МОНГОЛ ХУВЦАС

Шинэ үг: Дээл, бүс, малгай, гутал

Үйл ажиллагаа 1. Миний дээл (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Монгол үндэсний хувцас

Аргачлал: Монгол үндэсний хувцсаа авч ирсэн байна. Монгол үндэсний хувцсаа хэрхэн өмсдөгийг багш биечлэн үзүүлнэ. Хүүхдүүд багшийг ажиглан даган дуурайж хувцаслахыг оролдоно. Өмсөж чадахгүй хүүхдэд багш дэмжлэг үзүүлнэ. Хүүхэд бүр өөрийн дээл, малгай, бүс, гутал гэж нэрлэнэ.

Багш сандал дээр дээлээ эвхээд тавиарай, дээлний дээр бүс, бүсэн дээр малгай, үсний гоёлоо тайлж тавиарай гэж чиглүүлнэ. Сандал дээр байрлуулсан хувцсаа дэс дараалан нэрлэнэ.

Үйл ажиллагаа 2. Хос гутал (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Монгол гутлын зураг хүүхэд бүрийн тоогоор бэлдэх

Аргачлал: Багш монгол гутлын зургуудыг анги дотор ширээн доор, сандал доор, тавиурын доор гээд янз бүрийн байрлалд ижил буруугаар байрлуулна. Хүүхэд нэг гутал сонгож аваад тухайн гутлын ижлийг олох даалгавар өгнө. Олсон гутлаа ижил байгаа эсэхийг ажиглана. Хаанаас олсноо бие биедээ хэлж зааж ярилцана.

Үйл ажиллагаа 3. Найзаа хувцаслая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Монгол дээл, малгай, гутал өмсөж бүс бүсэлсэн, эрэгтэй эмэгтэй хүүхэлдэй, зурагт хуудас (Зурагт хуудсанд наадаг зангуутай байж болно.)

Аргачлал: Багш эрэгтэй, эмэгтэй хүүхэлдэйд дээл, бүс, малгай, гутал өмсгөж харуулна. Өмссөн хувцсыг давтаж нэрлэнэ. Хүүхдүүд зурагт хуудаснаас сонголт хийж хүүхэлдэй дээр нааж байрлуулан тоглоно.

НОМЫН ХУУДАС

Шинэ үг: Хуудас

Үйл ажиллагаа 1. Номын хуудас эргүүлэх (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Номын тавиур, сандал, ширээ, зөөлөн дэр, майхан, том, жижиг зурагт ном.

Аргачлал: Хүүхэд бүр сонгосон зурагт номоо авна. Номын хуудсаа хэрхэн эргүүлэхийг багш биечлэн үзүүлнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хуудсаа эргүүлээрэй.
- Ямар зураг гарч ирсэн бэ? Нэрлээрэй.
- Дараагийн хуудас дээр юу байна вэ? гэж хэлээд, хуудас эргүүлж байхдаа ямар амьтан, өнгө, үйл явдал гарч байгааг асууж, хариултыг хүлээнэ.

Тэдний анхаарлыг татаж, номын зурагтай холбож зургуудын тухай асуух, зааж харуулах, номын хуудас тус бүрийг тайлбарлан, ярилцана. Хүүхдүүд номын хуудсыг эргүүлнэ. Номын тавиурт үзсэн номоо өрж, хураана.

ӨНГӨТЭЙ ТАНИЛЦЬЯ

Шинэ үг: Шар, улаан, хөх

Үйл ажиллагаа 1: Өнгөт зайрмаг (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хуванцар бөмбөгнүүд, зайрмагийн аяга бэлтгэх

Аргачлал: Хүүхэд бүрийг гэрийнхэнтэйгээ хамт хайрцгаар зайрмагийн аяга хийж ирэх даалгавар өгнө. Зайрмагийн аяга нь улаан, шар, хөх өнгөтэй байх ба хүүхдүүд өөрийн сонгосон зайрмагийн аяганы өнгөтэй ижил бөмбөгийг сонгож байрлуулан тоглоно. Цахим холбоос 1-ийг ашиглаж болно.

Үйл ажиллагаа 2: Өнгөөр ялгаарай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хуванцар бөмбөгнүүд, цаасан аяга

Цаасан аягыг улаан, шар, хөх өнгөөр будаж бэлтгэнэ. Сагсанд улаан, шар, хөх өнгийн бөмбөлөг байх ба зүй тогтлын зурагт үзүүлэнг хүүхдийн өмнө байрлуулна. 3 хүүхэд

зэрэг тоглож болно. Дундаа бөмбөгөө тавиад ээлжилж бөмбөгийг байрлуулна. Багш чиглүүлэн, дэмжлэг үзүүлж урамшуулна.

ДУУЛАН БҮЖИГЛЭЭ

Шинэ үг: Бүжиг

Үйл ажиллагаа 1. Алгаа ташаарай дуу (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Д.Пунцагдоржийн ая, З.Юмчинсүрэнгийн үг “Алгаа ташаарай” дууны ая, гэр бүлийн тухай зурагт үзүүлэн

Аргачлал: Зургаас аав, ээж, эмээ, өвөө аль нь болохыг заана. Багш дууны үг аянд тохируулж энгийн хөдөлгөөн зохиомжилж хийж үзүүлнэ. Хүүхдүүд дууны аяыг сонсож, үгийг дагаж хэлэхийг оролдоно. “Алгаа ташаарай” гэж хэлэхдээ багшийг дагаж 3 удаа алга ташна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Аав, ээж, эмээ, өвөө, ах, эгч аль нь вэ?

2. Бидний хувцас

Хэрэглэгдэхүүн: Бидний хувцас дууны ая.

Аргачлал: Багш, хүүхдүүд монгол дээл хувцсаа өмссөн байна. Багш малгай өмсөх, бүсээ бүслэх, гутлын өсгийг товших зэрэг хөдөлгөөнүүдийг үзүүлж, тайлбарлаад “Бидний хувцас” дууны аянд хялбар хөдөлгөөн зохиомжилно. Хүүхдүүд багшийг дуурайж, дууны аянд хялбар хөдөлгөөнийг хийхийг оролдоно.

Багш дээл хувцсыг зааж “Энэ юу вэ?” гэж асууна.

2 дугаар сарын II долоо хоног

АМАР БАЙНА УУ?

Шинэ үг: Золгох, хэвийн боов

Үйл ажиллагаа 1. Золгоцгооё (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Хадаг

Аргачлал: Золгох үйлийн талаар ярилцаж багш, багшийн туслах мэндлэх үгийг хэлж биечлэн харуулна. Хүүхдүүд хос хосоороо зогсоно. “Амар байна уу?” та гэж мэндлэх, “Мэндээ” гэж хариултыг хэлж золгох үйлийг даган дуурайж тоглоно. Ямар баяраар золгодог талаар ярилцана.

Үйл ажиллагаа 2. Ах эгчтэйгээ золгоё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Зассан идээ, дээл хувцас.

Аргачлал: Багш урьдчилан ахлах, бэлтгэл бүлгийн багш нарт Цагаан сар сэдэвт тоглоом” хамтдаа тоглохыг хэлж бэлтгэсэн байна. Хүүхдүүдийг хэсэг хэсгээр ээлжлэн авч явж бусад бүлэгт айлчлан зочилж ах, эгч нартайгаа цагаан сар сэдэвт тоглоомоор тоглоход дэмжлэг үзүүлж хамтран тоглоно. Ахлах, бэлтгэл бүлгийн багш, хүүхдүүд ангидаа идээ засаж, үндэсний хувцсаа өмсөж дүү нараа угтан авах, мэндлэх, золгох, хүндлэх, дайлж тоглоход бэлтгэнэ. Бага бүлгийн хүүхдүүд зугаалгын цаг, тоглоомын цагаараа ахлах, бэлтгэл бүлэгт зочлон ах, эгч нартайгаа мэндлэх, золгох, хооллох, үйлийг хийж цагаан сар сэдэвт тоглоомоор хамтран тоглож баярын зан үйлд суралцана.

ЗУРЖ УРЛАЯ

Шинэ үг: Ааруул

Үйл ажиллагаа 1. Усан доторх зураг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Савтай ус, амны цаас, монгол гутал, дээл, малгай, сүү гэх мэт хэвлэмэл зураг

Аргачлал: Хэвлэж бэлтгэсэн зургийн хэмжээтэй ижил хэмжээтэй амны цаасыг зураг дээр давхарлан тавьж дөрвөн талд нь үдээсний машинаар үднэ. Амны цаасны араас зураг нэвт харагдахгүй байхад анхаарна. Туршилт хийх зургийг олноор нь бэлтгэнэ. Хүүхэд хэдэн ч удаа туршилт хийж болно. Хуудас цаасыг авч савтай усанд хийж

ажиглана. Цаас усанд норж цаад зураг тодорч гарахыг ажиглаж юуны зураг гарсныг нэрлэнэ.

Үйл ажиллагаа 2. Шидэт зураг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Монгол хувцсыг лаагаар зурж бэлтгэнэ. бийр, найруулж бэлтгэсэн усан будаг

Аргачлал: Багш цаасан дээр монгол гутал, дээл, малгайг зурж хүүхэд бүрд хүртээмжтэй бэлдэнэ. Хүүхэд хормогч, ханцуйвч өмсөж, усан будгийг найруулж будахад бэлтгэнэ. Хуудас цаасыг ширээн дээр хөдөлгөөнгүй байрлуулна. Хүүхэд бийрээр найруулж бэлтгэсэн будагт дүрээд цаасыг жигд дүүргэж будна. Будаг дуусахад юуны зураг тодорсныг нэрлэнэ. Будаг дуусаад бийрээ бусдын дэмжлэгтэй цэвэрлэж байранд нь хураана. Гараа сайтар угаана.

Үйл ажиллагаа 3. Ааруул (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Аарц, гялгар уут, хэв, таваг, элсэн чихэр, амны халбага

Аргачлал: Олон төрлийн ааруулын зураг харуулна. Аарцыг гялгар уутанд хийж шахах, төрөл бүрийн хивэнд хийж хэвлэх үйлийг хийнэ.

- Ааруул хэвлэхийн өмнө гараа угаах, аарцыг амандаа ихээр хийхгүй байх зэрэг аюулгүй байдлыг анхааруулж сануулна.
- Чихэртэй, чихэргүй аарцыг сонгон халбагаар хивэнд хийж хэвлэнэ.
- Гялгар уутанд чихэртэй, чихэргүй аарц хийж, үзүүрийг нь цоолж аарцаа шахан гаргаж ааруул хэвлэнэ. Хийсэн ааруулаа хатаана. Хатсаны дараа ааруулаа амтална.

ЧИЙРЭГ БОЛЦГООЁ

Шинэ үг: Саад, цуваа

Үйл ажиллагаа 1. Бяцхан амьтдын алхаа (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Конус хэлбэртэй өнгийн саад 9 ширхэг, 5-10 см-ын өндөртэй саад 9 ширхэг,

Аргачлал: Хүүхдүүдийг 3 цуваанд зогсооно. Цуваа бүрд 3 ширхэг саадыг 2м зайтай байрлуулна. Багшийн чиглүүлэх асуулт:

- Та нар ямар ямар амьтан мэддэг вэ?
- 12 жилд ямар амьтад байдаг вэ?
- Тэр амьтан яаж алхдаг вэ?
- Алхаж үзүүлээрэй. Хамтдаа дуурайж алхъя.

Хүүхдийн сонирхсон, хүссэн, мэддэг амьтныг даган дуурайлгаж алхуулна. Саадыг сүлжиж/давж амьтдын алхааг дуурайж алхана.

2. Гараар наадъя

Хэрэглэгдэхүүн: “Гараар наадъя” дасгалыг цахим холбоос 2

Аргачлал: Багш дасгалыг тайлбарлахдаа сарвууны үеэр тойргоор эргүүлэх, атгаж нийлүүлэх, хуруунуудыг салгаж нийлүүлэх, баруун, зүүн гар, их бие, хөл г.м бие эрхтнүүдийг нэрлэж гүйцэтгэнэ. Хүүхдүүдэд дасгалыг удаан тайлбарлан гүйцэтгэсний дараа хөгжимтэй хийнэ. Хүүхдийн гүйцэтгэх чадвараас хамаарч дасгалын давтамжийн тоог тохируулна.

“Гараар наадъя” дасгалыг цахим холбоос 2-ыг харна уу. Үүнтэй ижил төстэй дасгалыг багш зохиомжлон гүйцэтгүүлж болно. Энэхүү дасгалаа өглөөний дасгал дээр бататгаж гүйцэтгэнэ.

3. Хурдан дамжуулъя

Хэрэглэгдэхүүн: бөмбөг (5-10 см-ын диаметр)

Аргачлал: Хүүхдүүд өөд өөдөөс харж зогсоно. Багшийн “Дамжуулаарай” дохиогоор хүүхдүүд бөмбөгийг бие биедээ дамжуулан өгч тоглохыг тайлбарлан биечлэн үзүүлнэ. Багшийн дохиогоор бие биедээ дамжуулан өгч тоглоно.

Тайвшруулах дасгал. Тоглож дууссаны дараа хүүхдүүд завилан сууцгаана, амьсгалаа авахдаа гараа урагш нэг нэгээр зөөж тавин, амьсгалаа гаргахдаа бөхийж

сунгана. Амьсгалаа авахдаа гараа нэг нэгээр өөр лүүгээ тавин, өвдгөн дээрээ тавьж амьсгалаа гаргана.

Сонсъё, дэмжье /Туслалцаа:

Бүрэг, ичимхий, өөрийгөө илэрхийлэхэд дэмжлэг хэрэгтэй хүүхдийг ажиглан, түүний сонирхол, дуртай тоглоомоор тоглуулах замаар бусадтай хамтран оролцох нөхцөлийг бүрдүүлнэ.

Нүдээр харилцах, инээмсэглэх, энгийн үг, дохио, үйлдлээр ойлголцох харилцааг тогтвортой байлгаж, итгэлцлийг бий болгоно.

Дэмжлэг шаардлагатай хүүхдэд өөрийн сонирхлоор тоглох боломжийг олгоно. Багш, хүүхдээс ямар санаачилга гарч байна, хэрхэн тоглохыг хүсэж байгаа зэргийг ажиглаж тэмдэглэнэ.

Эцэг эхтэйгээ хамтаръя

Үндэсний ёс заншил, гэр бүлийн үнэт зүйлс, өв уламжлалыг мэдэрч ойлгох, дагаж биелүүлэхэд үлгэрлэх.

Гэр бүлээрээ хүүхдэд зориулсан үзвэр үзэж соёлд үлгэрлэх, шинээр сурсан дуу, хөгжимт хөдөлгөөнийг тоглолтыг үзээд магтан сайшаах, алга таших зэргээр урамшуулан талархах;

Үндэсний баяр, уламжлалт ёслолд хамтдаа оролцох, урам өгч, эерэг мэдрэмж төрүүлэх;

Цахим холбоос:

1. https://www.youtube.com/watch?v=Pc7GZogAznE&ab_channel=UNICEFMK
2. https://drive.google.com/file/d/1ya7fhcYIHSyuYlKF8VzIXFlyC07TNRQG/view?usp=s_haring

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./

Амжилттай хэрэгжүүлсэн:

Сул хэрэгжүүлсэн:.....

Цаашид сайжруулах:.....

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - III САР

ГУРВАН ТООРОЙ

Хүүхдийн эзэмших чадамж

Харилцах: Бусадтай ярилцах, сонсох, ойлгох, давтаж хэлэх, дуурайн гүйцэтгэх, өөрийн санааг дохио зангаа, үгээр илэрхийлэх, бусдын үгийг хүлээж авах, ойлгох, үг үйлдлээр илэрхийлэх

Суралцахуйд суралцах: Орчны юмс, байгалийн үзэгдлийг сонирхон ажиглах, бусдыг сонсох, анхаарлаа төвлөрүүлэх, дуурайж давтах, өөрийгөө илэрхийлэх, тоглоом, багаж хэрэгслээ сонгож хэрэглэх, хурааж цэгцлэх,

Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил: Өөрийн болон бусдын биеийн мэдрэмжийг анзаарах, үг, үйлдлээр илэрхийлэх, дуу хоолой, өнгө аяс, сэтгэл хөдлөлийг ялган мэдэрч, үг, дохио зангаа, үйлдлээр илэрхийлэх

Шүүн тунгаах: Ойр орчны эд зүйлсийг ажиглаж нэрлэхийг оролдох, багаж, хэрэгслээ таних, сонгож хэрэглэх

Бүтээлчээр сэтгэх: Эд юмсыг урлахыг оролдох

Хамтран ажиллах: Бусадтай зэрэгцэж зураг зурах, бүтээл хийх, тоглоом хэрэгслийг хуваалцахад суралцах, бусдын хөдөлгөөн, тоглохыг ажиглах, хамтрагч болох, тоглохдоо дүрмийн дагуу тоглох

Аюулгүй байдлын зөвлөмж:

Багш дулаан, найрсаг харилцаагаар хүүхдийг хүлээн авах, хүүхдийн яриаг анхааралтай чин сэтгэлээсээ сонсох, хүүхдийн үзүүлж буй хариу үйлдэлд заавал хариу өгч харилцана.

Тоглоом, үйл ажиллагааны үед аюулгүй тоглох зөвлөмж санамжийг тогтмол өгч ажиллана.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Гурван торой үлгэрийн зураг дээрх үйлдлийг дуурайх, үгийг дагаж хэлэх, багшийн асуусан асуултад хариулах, асуулт асуух оролдлогыг дэмжээрэй.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Хүүхдүүд дууг сонсох, дагаж дуулах, үлгэрийн дүрийг хэв дардсаар будах, наамал хийх үйлийг дэмжиж хүүхэд бүрийн оролцоог хангаарай. Мөн юмсын шинж чанарыг таниулж, сониуч байдлыг дэмжих хялбар туршилт хийгээрэй.

Номын цаг:

- Бусдын яриаг сонсох, ажиглах чадварыг дэмжих, номын хуудсыг эргүүлж үзэх, үлгэр, зохиолыг хамтдаа сонсох дадалтай болоход дэмжлэг үзүүлнэ.

Хөгжөөн баясах цаг:

- Бээлийн хүүхэлдэй, баг маскаар дүрд орж тоглоход дэмжин, үлгэрийн үйл явдлыг хөдөлгөөнт тоглоомоор дамжуулан бататгаарай.

Боломжууд:

Хүүхдээс асуулт асууж, хариулт авах, номын зургийг заах, нэрлэх, харилцан яриаг дэмжинэ. Тоглосон тоглоом, хэрэглэсэн эд зүйлээ байранд нь хураах дадалд үлгэрлэнэ. Бие даан тоглох, тоглох явцдаа бусадтай харилцах, хамтран тоглох, хуваалцах ойлголтыг дэмжин чиглүүлнэ.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
ХЯ1.1а. Бусдын яриаг сонсоод ойлгосноо үг үйлдлээр илэрхийлнэ. ХӨГ1.1в Дуу, аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийнэ. ЗУ1.2в. Бусдын дэмжлэгтэйгээр толбо, дардсаар зурна	<ul style="list-style-type: none"> - Ном, үлгэр зохиолын зураг дээрх үйлдлийг дуурайх, нэрлэх, таах, дүрүүдийн үгийг дагаж хэлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах - “Хамтдаа тоглоё” багш хүүхэд хамтдаа дууны аянд чөлөөтэй хөдөлж, хөгжимт тоглоомоор чөлөөтэй тоглож хөгжилдөх; - Эд юмсаар дардаслах 	Гурван торой
НСХ1.2а. Бусдын биеийн зарим мэдрэмжийг ойлгодог болно. ХЯ1.2б. Ярилцахдаа асуулт асуух оролдлого хийнэ. БНО1.1в. Ойр орчны эд зүйлс, тоглоомыг мэдэрч нэрлэнэ. ЗУ1.2д. Бэлдэц дүрсээр бусдын дэмжлэгтэй нааж бүтээл урлана.	<ul style="list-style-type: none"> - Нэг нэгнийхээ гаргасан нүүрний хувирлыг дуурайж тоглох; - Бусад хүмүүсийн хэлсэн энгийн асуултыг сонсож, давтан хэлэх тоглоом тоглож, дүрд орж, асуулт асууж тоглох; - Өдөр тутам хэрэглэдэг зүйлсийн дүрслэл бүхий зурган карт, тоглоом ашиглан таних, нэрлэх үйлд оролцох, эд зүйлсийг барьж мэдрээд хэмжээ, өнгө, зөөлөн хатуу шинжээр нь ялгаж, хэлэх, эд зүйлс, тоглоомыг дуртай үзэх, барьж туршиж үзэх - Наамлаар урлаж дуусаад багаж, хэрэгслийг байранд нь хураах 	Гурван торойн байшин
ХӨГ1.1а. Хүн, амьтны дуу авиаг ялган таньдаг болно. ХӨГ1.1б. Дууг анхааралтай сонсож, зарим үг авиаг дуурайн хэлж аялна. ХӨГ1.1в. Дуу, аялгууны хэмнэлд	<ul style="list-style-type: none"> - Амьтдын дуу авиаг сонсоод дүрд орж хөгжилдөх - Аа-оо-уу гэх мэт авиаг анхаарч сонсоод дуурайж дуугарах - Дуу, ая, аялгуунд тохируулж амьтны 	Гурван торойн дуу

<p>тохируулан хөдөлгөөн хийдэг болно. НСХ.1.3б. Бусад хүмүүс ижил зүйл хийж байгааг ажиглаж мэддэг болно.</p>	<p>хөдөлгөөнийг даган дуурайн хийх</p> <ul style="list-style-type: none"> - “Эхлээд би, дараа нь чи” гэсэн өөрийгөө хянах, дараалал ойлгох төрөл бүрийн тоглоомын тоглох 	
<p>ХЯ1.1а. Бусдын яриаг сонсоод ойлгосноо үг үйлдлээр илэрхийлнэ. ЗУ1.2е. Өрж байгуулах, эвлүүлэх аргаар тоглоом, эд юмсыг бусдын дэмжлэгтэй бүтээнэ. БНО1.1г. Байгалийн үзэгдлийг зааж нэрлэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Үлгэрийн үйл явдлыг хөдөлгөөнөөр илэрхийлэн тоглох - Өрж байгуулах тоглоомыг давхарлан өрөх - “Нар гарлаа”, “Бороо орлоо”, “Салхи салхиллаа” зэрэг хөдөлгөөнт тоглоомоор тоглох, салхи, борооны дуу чимээ гаргаж тоглох 	<p>Хамтдаа тоглоцгооё</p>
<p>ЗУ1.2д. Бэлдэц дүрсээр бусдын дэмжлэгтэй нааж бүтээл урлана. ЗУ1.3а. Баримлын шавраар нэг бүтэцтэй зүйлийг бусдын дэмжлэгтэй барьж бүтээнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Бэлэн дүрсийг бусдын дэмжлэгтэй цавуудаж наах - Наамлаар урлаж дуусаад багаж, хэрэгслийг байранд нь хураах; - Баримлын шаврыг тасалж, базаж, зөөллөж гарын алганд бөөрөнхийлөх, хавтгайлах 	<p>Хамтдаа урлацгаая</p>
<p>ХЭМ1.1г. Байрандаа болон чиглэлээ өөрчилж алхаж, гүйнэ. ХЭМ1.1е. Дөрвөн хөллөж 20 см-ын зайтай зураасны хооронд мөлхөнө. МАТ1.1а. Гэр, цэцэрлэгийн орчин тойронд байх юмсаас 1 эсвэл 3 ширхэг тоглоом, юмсыг заах, нэг гэж хэлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Алхалт, гүйлтийн үед аюулгүй байдалд анхаарч, хоорондын зайг тохируулах - Мөлхөлтийн нум, олсон доогуур дөрөв хөллөж мөлхөх дасгалыг давтах; - Цуглуулж байрлуулсан олон тоглоомоос нэг хүүхэлдэйг сонгож аваад хэд байгааг хэлэх 	<p>Хамтдаа хөгжилдье</p>

3 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
“Гурван торой” үлгэр	Номын цаг	Багш "Гурван торой" үлгэрийг зурагт үзүүлэн ашиглан, дүрүүдийн дуу хоолой, үйл хөдлөл, сэтгэл хөдлөлийг харуулан, урнаар ярина. Үлгэрийн үйл явдлыг асуултаар дэмжин ярилцана. Шинэ үгс болох Торой, Чоно-ын утгыг тайлбарлана.	Үлгэрийн дүрүүдийн хайчилбар зураг, самбар, зурагт үзүүлэн.	Аль нь чоно вэ? Заагаарай. Аль нь торой вэ? Заагаарай.	Харилцах-Бусадтай ярилцах, сонсох, ойлгох, давтаж хэлэх, дуурайн гүйцэтгэх	Бусдын яриаг сонсоод ойлгодог.
“Бяцхан торойг будаарай”	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Гахайн торойн хэвлэмэл зургийг хөвөн эсвэл эсвэл дугуй дардасны бэлдэц ашиглан дардаслан будах аргыг багш үзүүлнэ. Хүүхдүүд гуашид дүрсэн хөвөн эсвэл дардсаар будна. Будаг дуусаад хичээлийн хэрэгслээ хурааж, гараа угаана.	Цаас, будаг (гуаш), хөвөн, дардас.	Гахайн торой яаж дуугардаг вэ? Гахайг ямар өнгөөр будмаар байна вэ? Будаг сонгоорой.	Суралцахууд суралцах-Сургалтын хэрэглэгдэхүүнээ хурааж цэгцлэх	Бусдын дэмжлэгтэйгээр дардсаар зурна. Хичээлийн хэрэгслийг байранд нь хураадаг.
“Хөгжилтэй гурван торой”	Тойргийн цаг	Үлгэрийн дүрүүдээс хамгийн ууртай болон баяр хөөртэй амьтны зургийг нэрлэж, харилцан ярилцана. Дүрүүдийн сэтгэл хөдлөлийг тодорхой үзүүлж, зурагт карттай ижилсүүлэн тоглоход чиглүүлнэ.	“Гурван торой” үлгэрийн дүрүүдийн сэтгэл хөдлөлийн зурагт үзүүлэн, сэтгэл хөдлөлийн карт.	I ба II торой яагаад чононоос айсан бэ? III торой яагаад айгаагүй вэ? Хамгийн ууртай амьтан ямар амьтан бэ? Уурлаад үзүүлээрэй. Хамгийн эелдэг найрсаг торой аль нь вэ? Инээж үзүүлээрэй.	Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил-Өөрийн болон бусдын биеийн мэдрэмжийг анзаарах, үг, үйлдлээр илэрхийлэх	Бусдын сэтгэл хөдлөлийг дуурайдаг.
“Торойн байшинг	Чиглүүлэгтэй тоглоом, үйл	Гурван торой тус бүрийн барьсан байшинг харгалзуулан	Үлгэрийн дүрүүд ба гурван байшингийн	Нэгдүгээр торой юугаар байшин	Шүүн тунгаах: Ажиглаж нэрлэх	Ойр орчны эд зүйлс,

олоорой”	ажиллагаа	байрлуулах. Нэгдүгээр торой өвсөн, хоёрдугаар торой мөчрөн, гуравдугаар торой тоосгон байшин барьсныг ярилцана.	зураг.	барьсан бэ? Хоёрдугаар торой юугаар байшин барьсан бэ? Гуравдугаар торой юугаар байшин барьсан бэ? (Байшингийн зургийг заагаарай). Аль байшин амархан нурж унасан бэ? Тоосгон байшин яагаад нураагүй вэ?.	Харилцах-Өөрийн санааг дохио зангаа, үгээр илэрхийлэх	тоглоомыг мэдэрч нэрлэдэг.
“Аль нь хийсэх вэ?” (Туршилт)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Чоно шиг хүчтэй үлээх амьсгалын дасгал хийнэ. Ширээн дээрх өвс, мөчир, тоосго/лего блокийг үлээж туршина. Өвс хийсэж, мөчир хөдөлж, тоосго/лего хийсэхгүй байгааг ажиглан учир шалтгааныг ярилцана.	Өвс, мөчир, тоосго эсвэл леги блок.	Үлээхэд аль нь хийсэж байна вэ? (Заагаарай, өргөөрэй). Үлээхэд аль нь хийсэхгүй байна вэ? (Заагаарай, өргөөрэй).	Шүүн тунгаах-Ойр орчны эд зүйлсийг ажиглаж нэрлэхийг оролдох Суралцахууд суралцах-Орчны юмс, байгалийн үзэгдлийг сонирхон ажиглах	Байгалийн үзэгдлийг зааж нэрлэнэ.
“Гурван торойн байшин” (Наамал)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Гурван байшингийн бэлэн зураг дээр өвс, мөчир, өнгийн цаас ашиглан наамал хийж байшин бүтээнэ. Цавуу ашиглах аргыг үзүүлнэ. Хийж дуусаад хэрэгслээ хурааж, гараа угаана.	Өвс, мөчир, өнгийн цаас, цавуу.	Нэгдүгээр торойн байшин аль нь вэ? Юугаар байшин барьсан бэ? Хоёрдугаар торойн байшин аль нь вэ? Юугаар байшин барьсан бэ? Гуравдугаар торойн байшин аль нь вэ? Юугаар байшин	Бүтээлчээр сэтгэх барих, наах Суралцахууд суралцах-сонгож хэрэглэх, хураах	Бэлдэц дүрсээр бусдын дэмжлэгтэй наамал хийнэ. Хичээлийн хэрэгслийг байранд нь хураадаг.

				барьсан бэ?			
“Хөгжилтэй торойнууд”	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	“Гурван торой” дууг сонсож, дууны ая, хэмнэлд тохируулан гахайн торой, чоныг дуурайж, байшин барих хөдөлгөөнийг хийж, багшийг дагаж дуулахыг оролдоно.	“Гурван торой” дууны ая (Цахим холбоос 1).	Чоно байшинг яаж үлээсэн бэ?	Суралцахуйд Бусдыг сонсох, төвлөрүүлэх, давтах, илэрхийлэх	суралцах-анхаарал дуурайж өөрийгөө	Дууг анхааралтай сонсож, аялгууны хэмнэлд тохируулан багшийг дуурайн хөдөлгөөн хийдэг.
“Чоно ба торой”	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд торой, чонын зургийг сонгож, чихтэй даруулга зүүнэ. Түгшүүртэй, удаан аянд чоно болсон хүүхдүүд "аа-уу" гэж чангаар дуугарна (цаасан аяга ашиглан). Хөнгөн, хөгжилтэй аянд торой болсон хүүхдүүд нидрүүлэгтэй дуут мод хөгжим нидэрч, торойны дуу авиаг гаргана.	Чоно, торойг дүрсэлсэн чихтэй даруулга, нидрүүлэгтэй дуут мод, цаасан аяга, амьтдын дуу хоолойны аудио бичлэг (Цахим холбоос 2).	Чоно яаж дуугарсан бэ? Торой яаж дуугарсан бэ?	Суралцахуйд Бусдыг сонсох, төвлөрүүлэх, давтах, илэрхийлэх	суралцах-анхаарлаа дуурайж өөрийгөө	Амьтны дуу авиаг ялган танина, дуурайж дуугардаг.
“Гурван торой” үлгэр	Номын цаг/ Хамтдаа тоглоцгооё	Багш бээлийн хүүхэлдэйгээр үлгэрийг давтан ярих. Хүүхдүүд бээлийн хүүхэлдэйг барьж, дүрд хувиран үлгэрийн үйл явдлыг жүжигчлэн тоглох.	“Гурван торой” үлгэрийн бээлийн хүүхэлдэй.	Чоно эхлээд юугаар барьсан байшинг нураасан бэ? Дараа нь юугаар барьсан байшинг нураасан бэ? Тоосгон байшин нурсан уу? Аль байшин бат бөх байсан бэ?.	Харилцах: Анхааран сонсох, ойлгох, давтаж хэлэх, дуурайн гүйцэтгэх; Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил- Дуу хоолой, өнгө аяс, сэтгэл хөдлөлийг ялган мэдэрч, үг, дохио зангаа, үйлдлээр илэрхийлэх		Бусдын яриаг сонсоод ойлгосноо үг үйлдлээр илэрхийлдэг.
“Байшин барьж тоглоё”	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд лега блок болон өрж байгуулах тоглоомоор байшин барьж тоглоно. Тоглох явцад	Лега блок, өрж байгуулах тоглоом.	Чи юугаар байшинг барьж байна вэ? Чи байшин аль	Бүтээлчээр сэтгэх-Эд юмсыг урлахыг оролдох, Хамтран ажиллах		Өрж байгуулах, эвлүүлэх аргаар тоглоом, эд

		үлгэрийн үйл явдал, дүрүүдийг дуурайна.		торойны байшинтай ижилхэн бэ?	Бусадтай зэрэгцэж бүтээл хийх, тоглоомоо хуваалцах	юмсыг бусдын дэмжлэгтэй бүтээдэг.
“Салхи салхиллаа” хөдөлгөөнт тоглоом	Хөгжөөн баясах цаг	Багш цаг агаарын нөхцөлийг хэлж, тохирох хөдөлгөөнүүдийг хийнэ (Салхи салхиллаа: үүү-үүү гэж үлээх; Бороо: өвдгөө цохих; Нар: гараа дугуйлах). Хөдөлгөөнийг баяр баясгалантай, хөгжилтэй хийнэ.	Багш хөдөлгөөнийг биечлэн хийж үзүүлэх	Хөдөлгөөнт тоглоом	Харилцах-Бусдын үгийг хүлээж авах, ойлгох, үйлдлээр илэрхийлэх	Байрандаа болон чиглэлээ өөрчилж алхаж, гүйдэг.
“Гахайн торой” наамал	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа / Хамтдаа урлацгаая	Цаасан таваг/том дугуй дүрс дээр гахайн чих, хамар, нүдийг (гурвалжин, дугуй дүрс) сонгож байрлуулан наана.	Цаасан таваг, өнгийн цаас, цавуу.	Гахайны хамар нь аль вэ? Заагаарай. Гахайны нүд нь аль вэ? Заагаарай. Гахайны ам нь аль вэ? заагаарай. Гахайны чих нь аль вэ? Заагаарай.	Бүтээлчээр сэтгэх-Эд юмсыг зурж, урлахыг оролдох Суралцахууд суралцах-Зураг, урлалын багаж хэрэгслээ сонгож хэрэглэх, хураах	Бэлдэц дүрсээр бусдын дэмжлэгтэй наамал хийнэ. Хичээлийн хэрэгслийг байранд нь хураадаг.
“Миний байшин” шигтгэмэл	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд баримлын шаврыг базаж зөөллөөд, байшингийн бэлдэц зураг дээр тарааж наана. Хавтгайлсан шавар дээр мод, өвс, жижиг чулууг сонгож шигтгэнэ. Өөрийн бүтээлийг юугаар хийснийг тайлбарлана.	Баримлын шавар, чүдэнзний мод, өвс, жижиг чулуу.	Чи байшингаа юугаар чимэглэсэн бэ? Чи хэддүгээр торойн байшинг хийсэн бэ?	Шүүн тунгаах-Багаж, хэрэгслээ таних, сонгож хэрэглэх Бүтээлчээр сэтгэх-Эд юмсыг урлахыг оролдох Суралцахууд суралцах-Зураг, урлалын багаж хэрэгслээ сонгож хэрэглэх, хураах	Баримлын шаврыг базаж, тасалж, хавтгайлна. Хичээлийн хэрэгслийг байранд нь хураадаг.
“Том байшин” хамтын бүтээл	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Цаасан хайрцгаар хүүхэд багтах 3 том байшин хийхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог хангана. Том байшинг чимэглэхдээ гадаргууг цавуугаар түрхэж	Цаасан хайрцаг, цавуу (тарган цавуу), өвс, мөчир, өнгийн цаас.	Нэгдүгээр торойн байшинг барьсан бэ? Хоёрдугаар торойн байшинг барьсан бэ? Гуравдугаар торойн	Хамтран ажиллах-Бусадтай зэрэгцэж зураг зурах, бүтээл хийх, тоглоом хэрэгслийг хуваалцахад суралцах Суралцахууд суралцах-Зураг, урлалын багаж	Бусад хүмүүс ижил зүйл хийж байгааг ажиглаж дуурайдаг.

		бэлдээд, хүүхдүүд өвс, мөчир, улаан өнгийн цаасыг цавууны дээр тарааж, нааж чимэглэнэ.		байшинг юугаар барьсан бэ?	хэрэгслээ сонгож хэрэглэх, хураах	
Бөмбөг түүж тоолъё Наалдан пад	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд олон бөмбөгөөс нэгийг авч ижил өнгийн сагсанд хийн “нэг” гэж хэлнэ. Дараа нь тойрог болж сандал дээр суугаад биед нь ороосон наалддаг туузан дээр 3 бөмбөг тоолж нааж, дамжуулан тоглоно.	Сагс эсвэл цаасан өнгийн бөмбөг, тууз, жижиг наалддаг сандал,	Чи хэдэн бөмбөг авч ирсэн бэ? “Нэг” гээд дагаад хэлээрэй. Чиний бөмбөгтэй ижил өнгийн сагс хаана байна вэ? Хэдэн бөмбөг байна вэ? Тоолоорой.	Харилцах-Хүүхэд бусдын үгийг хүлээж авах, ойлгох, үг үйлдлээр өөрийгөө илэрхийлэх Хамтран ажиллах- Хүүхэд бусдын хөдөлгөөн, тоглохыг ажиглах, хамтрагч болох, тоглохдоо дүрмийн дагуу тоглох	Тоглоом, юмсыг заах, нэг гэж хэлж, нэг ширхэг зүйлийг авчирдаг.
Би чадна	Хөгжөөн баясах цаг	Цагариг, саад, мөлхөлтийн хаалга бүхий 2 багт хуваагдан тоглох. Хүүхдүүд цагаригаас цагаригт үсрэх, саад сүлжин гүйх, мөлхөлтийн хаалга дундуур мөлхөх. Буухиа хэлбэрээр уралдахгүй байхад анхаарах.	Цагариг, шон, мөлхөлтийн хоолой эсвэл мөлхөлтийн хаалга.	Хөдөлгөөнт тоглоом	Хамтран ажиллах- Хүүхэд бусдын хөдөлгөөн, тоглохыг ажиглах, хамтрагч болох, тоглохдоо дүрмийн дагуу тоглох	Дөрвөн хөллөж 20 см-ын зайтай зураасны хооронд мөлхдөг.

3 дугаар сарын I долоо хоног

ГУРВАН ТОРОЙ

Шинэ үг: Торой, чоно

Үйл ажиллагаа 1. “Гурван торой” үлгэр (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Үлгэрийн дүрүүдийн хайчилбар зураг, самбар

Аргачлал: “Гурван торой” зохиолыг багш зурагт үзүүлэн ашиглан, дүрүүдийн дуу хоолойны өнгө, үйл хөдлөл, сэтгэл хөдлөлийг тодорхой харуулан, урнаар ярина. Үлгэрийн дүрүүдийн зурагт хуудас ашиглан үлгэрт гарч буй амьтдыг нэрлэнэ. Шинэ үгсийн утгыг тайлбарлана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Аль нь чоно вэ? Заагаарай.
- Аль нь торой вэ? Заагаарай.

Үйл ажиллагаа 2. Бяцхан торойг будаарай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Цаас, будаг (гуаш), хөвөн, дардас.

Аргачлал: Багш гахайн торойн хэвлэмэл зургийг самбарт наагаад, хөвөн эсвэл дугуй дардас ашиглан дардаслан будах аргыг үзүүлнэ. Хүүхдүүд хөвөн эсвэл дардсаа бэлдсэн гуашинд дүрээд, гахайн хэвлэмэл зургийг дардаслан будна. Будаг дууссаны дараа хичээлийн хэрэгслээ хурааж, гараа угаана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Гахайн торой яаж дуугардаг вэ?
- Гахайг ямар өнгөөр будмаар байна вэ? Будгаа сонгоорой.

ГУРВАН ТОРОЙН БАЙШИН

Шинэ үг: Өвс, мөчир, тоосго

Үйл ажиллагаа 1. “Хөгжилтэй гурван торой” (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: “Гурван торой” үлгэрийн дүрүүдийн сэтгэл хөдлөлийн зурагт үзүүлэн

Аргачлал: “Гурван торой” үлгэрийн дүрүүдээс хамгийн ууртай амьтан ба баяр хөөртэй амьтны зургийг нэрлэж, харилцан ярилцана. Үлгэрийн дүрүүдийг зааж, асуулт асууж, сэтгэл хөдлөлийн карттай ижилсүүлнэ. Ууртай чонын зурагт үзүүлэнг уурласан сэтгэл хөдлөлийн картын хажууд тавина.

Багшийн чиглүүлэх асуулт:

- I ба II торой яагаад чононоос айсан бэ?
- III торой яагаад айгаагүй вэ?
- Хамгийн ууртай амьтан ямар амьтан бэ? Уурлаад үзүүлээрэй.
- Хамгийн эелдэг найрсаг торой аль нь вэ? Инээж үзүүлээрэй.

Үйл ажиллагаа 2. Торойн байшинг олоорой (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Үлгэрийн дүрүүд ба гурван байшингийн зураг

Аргачлал: Гурван торой тус бүрийн барьсан байшинг харгалзуулан байрлуулна. Нэгдүгээр торой өвсөн байшин барьсан, хоёрдугаар торой мөчрөн байшин барьсан. Харин гуравдугаар торой ажилсаг учраас бат бөх тоосгон байшин барьсан.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Нэгдүгээр торой юугаар байшин барьсан бэ? Байшингийн зургийг заагаарай.
- Хоёрдугаар торой юугаар байшин барьсан бэ? Байшингийн зургийг заагаарай.
- Гуравдугаар торой юугаар байшин барьсан бэ? Байшингийн зургийг заагаарай.
- Аль байшин амархан нурж унасан бэ?
- Тоосгон байшин яагаад нураагүй вэ? ярилцана.

Үйл ажиллагаа 3. Аль нь хийсэх вэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Өвс, мөчир, тоосго эсвэл леги блок

Аргачлал: Чоно шиг хүчтэй үлээе гээд хамраараа гүнзгий амьсгаа аваад, гараа нүүрний өмнө барина. Үлээхдээ гараа урагш аажмаар тэнийлгэн, амьсгаагаа хүчтэй

үлээж амаараа гаргаж дасгал хийнэ. Ширээн дээр өвс, мөчир, тоосгоны хэлтэрхий эсвэл леги блок тавьж үлээвэл хийсэх болов уу? хийсэхгүй болов уу? гэж таамаглал дэвшүүлэн, багш болон хүүхдүүд үлээж туршина. Үлээхэд өвс хийсэж, мөчир бага зэрэг хөдөлж, харин тоосго болон леги хийсэхгүй байгааг ажиглан учир шалтгааныг нь ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Үлээхэд аль нь хийсэж байна вэ? Заагаарай, өргөөрэй.
- Үлээхэд аль нь хийсэхгүй бана вэ? Заагаарай, өргөөрэй гэх мэт асууж, харилцан ярилцана.

Үйл ажиллагаа 4. Гурван торойн байшин (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Өвс, мөчир, өнгийн цаас, цавуу

Аргачлал: Өвс, мөчир, өнгийн цаасыг бэлтгэн саванд хийж, ширээн дээр тавина. Гурван байшин зурж бэлдсэн цаасан дээр хүүхдүүд цавуу түрхэж өвс, мөчир, цаасыг нааж наамал хийнэ. Багш цавуу ашиглах аргыг тодорхой үзүүлнэ. Хийж дуусаад хичээлийн хэрэгслээ хурааж, гараа сайтар угаана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Нэгдүгээр торойн байшин аль нь вэ? Юугаар байшин барьсан бэ?
- Хоёрдугаар торойн байшин аль нь вэ? Юугаар байшин барьсан бэ?
- Гуравдугаар торойн байшин аль нь вэ? Юугаар байшин барьсан бэ?

ГУРВАН ТОРОЙН ДУУ

Шинэ үг: Дуурайх, хөгжим

Үйл ажиллагаа 1. Хөгжилтэй торойнууд (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: “Гурван торой” дууны ая

Аргачлал: Гурван торой дууг сонсож, дууны ая, хэмнэлд тохируулан гахайн торой, чоныг дуурайж, байшин барих хөдөлгөөнийг дүрслэн хийж, багшийг дагаж дуулахыг оролдоно. Цахим холбоос 1-ийг ашиглаарай.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чоно байшинг яаж үлээсэн бэ?

2. Чоно ба торой

Хэрэглэгдэхүүн: Чоно, торойг дүрсэлсэн чихтэй даруулга, нидрүүлэгтэй дуут мод, цаасан аяга, амьтдын дуу хоолойны аудио бичлэг, үлгэрийн дүрүүдийн зурагт үзүүлэн

Аргачлал: Хүүхдүүд торой, чонын зургаас аль нэгийг сонгоно. Хүүхдүүд сонгосон амьтны чихтэй даруулгыг толгойдоо зүүнэ. Түгшүүртэй, удаан ая явахад чоно болсон хүүхдүүд чоныг дүрсэлсэн чихтэй даруулга зүүж чонын дуу авиаг дуурайж “аа-уу” гэж дуугарна. Илүү чанга дуугаргахын тулд цаасан аягыг амандаа барьж дуугарна. Хөнгөн хөгжилтэй ая явахад торой болсон хүүхдүүд нидрүүлэгтэй дуут мод хөгжмийг нидэрч дуугарган торойны дуу авиаг гаргаж торой болж тоглоно. Цахим холбоос 2-ыг ашиглаарай.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чоно яаж дуугарсан бэ?
- Торой яаж дуугарсан бэ?

3 дугаар сарын II долоо хоног

ХАМТДАА ТОГЛОЦГООЁ

Шинэ үг: Байшин, салхи

Үйл ажиллагаа 1. “Гурван торой” үлгэр (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: “Гурван торой” үлгэрийн бээлийн хүүхэлдэй

Аргачлал: Багш бээлийн хүүхэлдэйгээр “Гурван торой” үлгэрийг дуу хоолой, нүүрний хувирал, дохио зангаа, хөдөлгөөнөөр илэрхийлэн, дүрүүдийн сэтгэл хөдлөлийг

тодорхой харуулан ярина. Багш үлгэрийг давтан өгүүлэхэд, хүүхдүүд бээлийн хүүхэлдэйг барин, дүрд хувиран үлгэрийн үйл явдлыг үзүүлэн жүжигчлэн тоглоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чоно эхлээд юугаар барьсан байшинг нураасан бэ?
- Дараа нь юугаар барьсан байшинг нураасан бэ?
- Тоосгон байшин нурсан уу? Аль байшин бат бөх байсан бэ? гэх мэт асууж ярилцана.

Үйл ажиллагаа 2. Байшин барьж тоглоё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Лего блок, өрж байгуулах тоглоом

Аргачлал: Хүүхдүүд лего блок болон өрж байгуулах тоглоомоор байшин барж тоглоно. Тоглох явцад үлгэрийн үйл явдал, дүрүүдийг дуурайх ба багш чиглүүлэн, хамтран тоглоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи юугаар байшинг барьж байна вэ?
- Чи байшин аль торойны байшинтай ижилхэн бэ?

Үйл ажиллагаа 3. “Салхи салхиллаа” хөдөлгөөнт тоглоом (Хөгжөөн баясах цаг)

Аргачлал: Багш цаг агаарын нөхцөлийг хэлж, тохирох хөдөлгөөн хийнэ. Хүүхдүүд багшийг дуурайн тохирсон хөдөлгөөн хийж тоглоно. Хөдөлгөөнт тоглоомыг баяр баясгалантай, хөгжилтэй хийж 4-5 удаа давтана.

- Салхи салхилаа гэхэд үүү-үүү гэж уруулаа цорвойлгон үлээнэ.
- Тэнгэр дуугарлаа гэхэд 2 хөлөө дороо дэвсэнэ.
- Бороо зөөлөн шивэрлээ гэхэд 2 гараараа өвдгөө зөөлөн цохино.
- Бороо ширүүслээ гэхэд 2 гараараа өвдгөө хурдан цохино.
- Нар гарлаа гэхэд 2 гараа өргөж толгой дээрээ дугуйлна.
- Солонго татлаа гэхэд 2 гараа тойрог болгон буулгаж газарт явган сууна.

ХАМТДАА УРЛАЦГААЯ

Шинэ үг: Будаг, цавуу

Үйл ажиллагаа 1. “Гахайн торой” наамал (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Цаасан таваг, өнгийн цаас, цавуу

Аргачлал: Гахайны толгойг илэрхийлсэн нэг удаагийн цаасан таваг эсвэл том дугуй дүрсийг хүүхэд бүрд өгнө. Хүүхдүүд гахайны чихийг 2 ширхэг гурвалжин дүрс, хамрыг 1 ширхэг дугуй дүрс, нүдийг 2 ширхэг жижиг дугуй дүрс, амыг гурвалжин дүрс сонгож байрлуулан наана. Нааж дуусаад хичээлийн хэрэглэгдэхүүнийг хураана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Гахайны хамар нь аль вэ? Заагаарай.
- Гахайны нүд нь аль вэ? Заагаарай.
- Гахайны ам нь аль вэ? заагаарай.
- Гахайны чих нь аль вэ? Заагаарай.

Үйл ажиллагаа 2. “Миний байшин” (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Баримлын шавар, өвс, чүдэнзний мод, жижиг чулуу

Аргачлал: Хүүхдүүд өвс, жижиг модон савх, жижиг чулууг барьж, мэдэрнэ. Хүүхдүүд баримлын шаврыг базаж зөөллөөд, байшингийн бэлдэц зураг дээр тарааж наана. Хавтгайлсан наасан баримлын шавар дээр өвс, мод, чулууг сонгож шигтгэнэ. Өөрийн бүтээлээ юугаар хийснийг тайлбарлана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи байшингаа юугаар чимэглэсэн бэ?
- Чи хэддүгээр торойн байшинг хийсэн бэ?

Үйл ажиллагаа 3. “Том байшин” хамтын бүтээл (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Цаасан хайрцаг, цавуу (тарган цавуу), өвс, мөчир, өнгийн цаас.

Аргачлал: Цаасан хайрцгаар хүүхэд багтах хэмжээтэй 3 том байшин хийнэ. Хүүхдүүд хуваагдан байшин тус бүрийг чимэглэнэ. Байшинг чимэглэхдээ гадаргууг цавуудаж бэлдээд, хүүхдүүд өвс, мөчир, улаан өнгийн цаасыг цавууны дээр тарааж, нааж чимэглэнэ. Нэгдүгээр байшингийн гадна талыг өвс нааж чимэглэнэ. Хоёрдугаар байшингийн гадна талыг нарийн мөчир нааж чимэглэнэ. Гуравдугаар байшинг улаан өнгийн цаасаар чимэглэж наана. Хүүхдүүд байшинг чимэглэхэд багш, багшийн туслах хамтран дэмжинэ. Ингээд гурван торойн байшинг хамтдаа бүтээлээ. Байшингаа дараагийн үйл ажиллагаандаа ашиглаарай.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Нэгдүгээр торойн байшинг юугаар барьсан бэ?
- Хоёрдугаар торойн байшинг юугаар барьсан бэ?
- Гуравдугаар торойн байшинг юугаар барьсан бэ?

ХАМТДАА ХӨГЖИЛДЬЕ

Шинэ үг: Амьсгал авах, гаргах

Үйл ажиллагаа 1. Бөмбөг түүж, тоолъё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Сагс эсвэл цаасан хайрцаг, бөмбөг

Аргачлал: Ангийн төв хэсэгт олон бөмбөг тараасан байна. Өнгийн цаасан хайрцаг/сагс бэлтгэж ангид тарааж байрлуулна. Багш хүүхэд бүр 1 ширхэг бөмбөг авч ижил өнгөтэй сагсанд хийгээрэй гэж хэлнэ. Хүүхдүүд 1 бөмбөг авч хайрцагт хийхдээ “Нэг” гэж тоолж хийнэ.

Бөмбөгийг дуустал сагсанд хийх бөгөөд бөмбөг сагсанд хийх бүрдээ “Нэг” гэж давтан хэлнэ. Бүх бөмбөгийг хийж дуусаад “Олон” бөмбөг байгааг хэлнэ.

Тайвшруулах, амьсгалын дасгал хийнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи хэдэн бөмбөг авч ирсэн бэ? “Нэг” гээд дагаад хэлээрэй.
- Чиний бөмбөгтэй ижил өнгийн сагс хаана байна вэ?

Үйл ажиллагаа 2. Наалдан пад (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Өнгийн жижиг бөмбөг, наалддаг тууз, сандал

Аргачлал: Хүүхдүүдийн их биеийн хэсэгт наалддаг туузыг гадагш харуулан ороож, сандлыг тойрог хэлбэрт байрлуулан сууцгаана. Багш тоглоомын дүрмийг танилцуулна. Эхний хүүхдийн их бие хэсэгт 3 ширхэг жижиг бөмбөгийг наахдаа 1, 2, 3 гэж тоолно. Хүүхэд наалдсан жижиг бөмбөгийг гараараа авч дараагийн хүүхдийн их бие хэсэгт тоолж наана. Энэ мэтчилэн дамжуулсаар сүүлийн хүүхэд бөмбөгийг сагсанд хийнэ. Тоглоомыг давтан тоглоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хэдэн бөмбөг байна вэ? Тоолоорой.

Үйл ажиллагаа 3. Би чадна (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Цагариг, шон, мөлхөлтийн хоолой эсвэл мөлхөлтийн хаалга

Аргачлал: Хоёр эгнээгээр 4-5 цагариг цувуулж тавих, саад эсвэл сандал 2 ширхэг, мөлхөлтийн хаалгыг байрлуулна. Хүүхдүүд 2 багт хуваагдана. Багш хүүхдүүдэд биечлэн хийж үзүүлнэ.

- Хүүхдүүд цагаригаас цагаригт үсэрнэ.
- Саад сүлжин гүйнэ.
- Мөлхөлтийн хаалга дундуур мөлхөнө.

Хүүхэд бүрийн оролцоог дэмжиж, гүйцэтгэж дуусахыг хүлээнэ, Буухиа хэлбэрээр уралдахгүйг анхааруулна. Тайвшруулах, амьсгалын дасгал хийнэ.

Сонсьё, дэмжье/ Туслалцаа:

Зурагт ном, тоглоом, эсвэл зурагт самбар ашиглан түлхүүр үйл явдал бүрийг зурагтай холбож үг хэллэгийг ойлгомжтой, богино өгүүлбэрээр үлгэрийг ярина.

Асуулт тавих буюу үйл явдлыг дахин давтах, ойлгосон эсэхийг бататгаж харилцан ярилцана.

Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг оролцоо:

Оройн цагаар хамтдаа дуу дуулах, ном уншихдаа асуулт асууж, зургаар тайлбарлах, хүүхэд асуулт асуувал бага багаар тайлбарлаж, давтаж хэлэх, үгнүүдийг энгийн үгээр тайлбарлаж таниулаарай. Хүүхэдтэй хамтран зурах, будах үйлийг хийж дэмжээрэй.

Гэр орчинд байгаа эд зүйлийг нэрлэх, давтан хэлүүлэхээс гадна чөлөөтэй тоглох, аюулгүй орчныг бүрдүүлээрэй.

Гэр бүлээрээ хөдөлгөөнт тоглоом тоглох, дуулах, хөдөлгөөн хийх, дүрд тоглох боломжийг олгох, дэмжих, зоригжуулаарай.

<p>Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/ Амжилттай хэрэгжүүлсэн: Сул хэрэгжүүлсэн:..... Цаашид сайжруулах:..... Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:</p>

Цахим холбоос:

1. “Гурван торой” дуу https://www.youtube.com/watch?v=uNfbzt-Uops&list=RDuNfbzt-Uops&start_radio=1
2. https://www.youtube.com/watch?v=nDkp073u_eU

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - IV САР

БАЛХҮҮ

Хүүхдийн эзэмших чадамж:

Суралцахуйд суралцах: Сонирхсон зүйлээ асууж анхааралтай сонсох, төвлөрөх, зааврыг ойлгож биелүүлэх;

Нийгэм сэтгэл хөдлөл: Өөрийн болон бусдын биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг анзаарах, үг, үйлдлээр илэрхийлэх;

Хамтран ажиллах: Бусдын үйлдлийг даган дуурайх, хамт тоглох, энгийн хөдөлмөрт оролцох;

Харилцах: Асуултад хариулж ярилцах;

Шүүн тунгаах: Болох болохгүйг ялгах;

Бүтээлчээр сэтгэх: зурж урлах;

Аюулгүй байдлын зөвлөмж:

Гуаштай ажиллах, усаар угааж арчих үйлийн үед ус, гуашийг амандаа хүргэхгүй байхыг сануулна. гадаа талбайд зугаалахын өмнө орчны аюулгүй байдлыг шалгаж, цаг агаарын байдалд тохируулж хувцаслана.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Зохиолын сургамж, дүрүүдийн үйл явдлыг асуугаарай.
- Зохиолын дүрүүдийн үйлдэл, сэтгэл хөдлөлийг дуурайж үзүүлээрэй.
- Асуулт асуух, асуултад хариулж, санаа бодлоо илэрхийлэхэд нь дэмжлэг үзүүлээрэй.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Багшийн чиглүүлэгийн ойлгон зурж урлах, асуултад хариулах, биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх, дуу дуулах, хамтран тоглох, дүрэм зааврыг ойлгож биелүүлэх, биеийн хөдөлгөөнийг даган дуурайх үйлийг дэмжээрэй.

Зугаалга:

- Орчны байдал, цаг агаар, байгалийн үзэгдлийг зааж, асууж ярилцаарай
- Зураг зурах боломжтой талбайг бэлдээрэй.

Номын цаг:

- Зохиолын үйл явдал, утга санааг ярилцана. Асуулт асуух, асуултад хариулж, санаа бодлоо илэрхийлэх, номыг зургийг харж богино өгүүлбэрээр бусдад ярьж өгөх боломж бүрдүүлээрэй.

Өөртөө үйлчлэх хөдөлмөр:

- Тоглоом болон орчин тойрны эд зүйлсийг угааж цэвэрлэх, цэгцэлж хураахад оролцуулж, бусдын хийж буй үйлдлийг даган дуурайхыг дэмжээрэй.

Хөгжөөн баясах цаг:

- Зохиолыг үйл явдал, дүрийн нүүрний хувирлыг харуулж жүжиглэж үзүүлээрэй.
- Жүжигчилсэн тоглолтыг сонирхон үзэх, сэтгэл хөдлөлөө илэрхийлэхэд урамшуулаарай.

Боломжууд:

Хүүхдийн сэтгэл хөдлөлд хариу үйлдэл үзүүлэн тайвшруулах, асуулт асууж ярилцана. Хүүхдүүдийн тоглоомоо булаацалдах, муудалцах үед эергээр шийдвэрлэж, бие биеэ ойлгоход тусална.

Хүүхдийн ангидаа үзэх дуртай номыг зөөврийн номын сангаар гэр бүлд нь явуулж хүүхдэдээ ном уншиж өгөх боломж олгоорой.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
НСХ1.2в. Насанд хүрэгчийн тусламжтай зарим зан үйлүүдийг таньдаг болно. ХЯ1.3а. Номыг сонирхож үзнэ. НСХ1.3а. Насанд хүрэгчийн тусламжтайгаар байнга хэрэглэдэг эд юмсыг байранд нь хураадаг болно.	<ul style="list-style-type: none">- Хэн юу хийцгээж байна вэ?, Ямар зан үйл вэ? гэсэн зурган карттай тоглоомууд тоглох;- Номд гарч буй үйл явдлуудыг дуурайх, үйл явдлын дүрслэлийг тоглоомын эд зүйлс ашиглан тоглох;- Тоглоом эд зүйлсийн байршлыг таньж, зөв байршилд хураах;	Балхүү тоглоомоо хураасан нь
БНО1.2в. Гэрт болон ангидаа эд зүйлсийн байрлалыг мэдэж, багшийн өгсөн энгийн зааврыг биелүүлнэ. ЗУ1.2в. Бусдын дэмжлэгтэйгээр толбо, дардсаар зурна. БНО1.2г. Өөрийн хэрэглэсэн эд зүйлс, тоглоомоо байранд нь хурааж, зориулалтын саванд хог хаяхыг оролдоно.	<ul style="list-style-type: none">- Анги, гэрийн орчинд байдаг эд зүйлсийг таньж, байрлалыг мэдэж хэлэх- Эд юмсаар дардаслах;- Анги болон гэрийн орчинд энгийн хөдөлмөр хийхийг ажиглах, өөрөө дуурайн хийхийг оролдох;	Бидний тоглоом
ХӨГ1.1б. Дууг анхааралтай сонсож зарим үг, авиаг дуурайж хэлж, аялна. НСХ1.3б. Бусад хүмүүс ижил зүйл хийж байгааг ажиглаж мэддэг болно	<ul style="list-style-type: none">- Танил, сурсан дууны хөдөлгөөнийг хийх, хэсэг үг авиаг хэлж аялан дуулах;- Хөгжилтэй бүлгийн тоглоомоор тоглох.	Бөмбөрөөр тоглоё
ХЯ1.3а. Номыг сонирхож үзнэ. ЗУ1.2а. Зурах хэрэгслүүдийг ашиглан зурааслаж, дүрсэлнэ. НСХ1.2в. Насанд хүрэгчийн тусламжтай зан үйлүүдийг таньдаг болно.	<ul style="list-style-type: none">- Номд гарч буй үйл явдлуудыг дуурайх, үйл явдлын дүрслэлийг тоглоомын эд зүйлс ашиглан тоглох;- Зургийн цаасан (А3, А2) дээр тосон харандаагаар зурааслана, бийрээр дүрслэх;	Балхүү зураг зурсан нь

	- Хэн юу хийцгээж байна вэ?, Ямар зан үйл вэ? гэсэн зурган карттай тоглоомууд тоглох;	
НСХ1.2а. Бусдын биеийн зарим мэдрэмжийг ойлгодог болно. МАТ1.3а. Тоглоом, юмсыг тодорхой нэг шинжээр ялгана. ЗУ1.2а. Зурах хэрэгслүүдийг ашиглан зурааслаж, дүрсэлнэ.	- Нүүрний хувирал, биеийн хөдөлгөөнөөр дүрсэлсэн зурагт үзүүлэнг ажиглаж ярилцах; - Нэрлэсэн тоглоомоос дуртай нэг өнгийн (шар гэх мэт) тоглоом сонгож авах; - Тосон харандааг атгаж бариад зурааслах;	Зураг зурцгаая
МАТ1.3а. Тоглоом, юмсыг тодорхой нэг шинжээр ялгана. ХЭМ1.1г. Байрандаа болон чиглэлээ өөрчилж алхаж, гүйнэ. ХЭМ1.1ж. Хэвтээ байрлалд хажуу тийш (харандаа) 2 удаа дараалан өнхөрнө.	- Багшийн зааврын дагуу улаан өнгийн тоглоомыг хайрцаг, сагсанд ялган хийх; - Алхалт, гүйлтийг хослуулан жижиг бөмбөг цуглуулах дасгалыг давтах; - Дээш харж таван хошуу болох доош харж таван хошуу болж 360 градус өнхөрч тоглох.	Тамирчин Балхүү

4 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Зөв үү? буруу юу?	Тойргийн цаг	Багш, багшийн туслах жүжигчилсэн тоглолтоор хийж болох ба болохгүй үйлдлүүдийг тайлбарлан үзүүлж, зурагт үзүүлэн дээр харилцан ярилцана.	Тоглоомууд, зурагт үзүүлэн.	Тоглоомоо шидэж, дээр нь гишгэх нь зөв үү? буруу юу?. Тоглоомоо найзтайгаа хуваалцаж тоглох нь зөв үү? буруу юу?.	Шүүн тунгаах: Зөв, буруу үйлүүдийг таньж заах, хэлэх	Зөв бурууг ялгадаг.
Балхүү тоглоомоо хураасан нь	Номын цаг	“Балхүү тоглоомоо хураасан нь” зохиолыг багш номын зургийг харуулж, дүрийг нүүрний хувирал, дуу хоолойгоороо тодотгон, урнаар ярина.	“Балхүү тоглоомоо хураасан нь” ном.	Чи тоглож дуусаад тоглоомоо хураадаг уу?	Суралцахуйд суралцах: зохиолыг анхааралтай сонсох, төвлөрөх. Нийгэм, сэтгэл хөдлөл: Зохиолын дүрүүдийн сэтгэл хөдлөлийг ойлгох.	Зохиолыг анхааралтай сонсдог:
Тоглоомоо хураагаарай	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Чөлөөтэй тоглуулсны дараа дуу явж эхлэхэд тоглоомоо хурааж, сагс, тавиур дээр тавих. Хүүхдүүд хамтдаа тоглоомоо ангилж, зориулалтын саванд (зурагтай сагс) хийж хураана.	Төрөл бүрийн тоглоомууд, сагс (тоглоомын зурагтай), “Тоглоомоо хураагаарай” дууны ая.	Энэ тоглоомыг аль сагсанд хийх вэ?	Хамтран ажиллах: Тоглоомоо хамтарч хураах. Суралцахуйд суралцах: Дүрэм зааврыг ойлгож биелүүлэх.	Тоглосон тоглоомоо хураадаг:
Тоглоомоо угаацгаая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хормогч, ханцуйвчаа өмсөн, тоглоомуудыг бүлээн усанд хийж угаах, хатаах, ангилж хураах. Угааж цэвэрлэхийн ач холбогдлыг ярилцана.	Том сав, бүлээн ус, хормогч, ханцуйвч, том алчуур.	Тоглоом нь хатсан байна уу?	Хамтран ажиллах: Бусдын үйлдлийг даган дуурайх, энгийн үйлийг хийх.	Тоглоомоо угаахыг оролддог.
Манай ангийн тоглоом	Тойргийн цаг	Ангид байдаг тоглоомуудын зургийг нэг нэгээр харуулж, тоглоом болон түүний байрлалын талаар ярилцана	Бүлгийн тоглоомуудын зураг.	Энэ ямар тоглоом бэ? Ямар өнгөтэй вэ? Ангийн аль хэсэгт байдаг вэ?.	Харилцах: Асуултад хариулж ярилцах.	Асуултад хариулж байгаа эсэх

Машины мөр	Чиглүүлэгтэй тоглоом	Цаасан дээр гуашнаас дусааж, жижиг машинаараа түрж мөр гарган тоглох. Тоглож дуусаад машинаа болон гараа угаана.	Хормогч, ханцуйвч, машин, ватум цаас. жижиг гуаш.	Чи аль өнгийг сонгож авсан бэ? Энэ ямар өнгө вэ? Угаасан машинаа хаана тавих вэ?	Бүтээлчээр сэтгэх: Зурж урлах, Гуаш хольж өнгө үүсгэх.	Зураас үүсгэж чадаж байгаа эсэх
Ширээгээ цэвэрлэе	Өөртөө үйлчлэх цаг	Зурах үйл ажиллагааны дараа хүүхдүүд ширээн дээрх будгийг алчуураар арчиж, цэвэрлэнэ.	Хормогч, ханцуйвч, устай сав, алчуур.	Ширээ нь цэвэрхэн болсон уу? Будаг хаана наалдсан байна.	Хамтран ажиллах: Ширээ арчих энгийн хөдөлмөрт оролцох.	Ширээг арчиж чадаж байгаа эсэх
Бүгдийг чадна би	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Дууны утга санааг зурагт үзүүлэн харуулж тайлбарлах. Дууны үгийг мөр мөрөөр хөдөлгөөнөөр дүрслэн үзүүлж, хүүхдүүд даган дуулахыг оролдох. Багш бөмбөрийг танилцуулж, алгаар зөөлөн тогшиж үзүүлнэ. Хүүхдүүд багшийг дуурайж “Том жижиг” дууны аянд бөмбөр тогшиж хөгжилдөнө.	“Бүгдийг чадна би” дууны ая, зурагт үзүүлэн, бөмбөр	Энэ зураг дээр хүүхэд юу хийж байна вэ? Та нар ямар хөгжмөөр тоглосон бэ?	Суралцахуйд суралцах: Багшийн хөдөлгөөнийг даган дуурайх Хамтран ажиллах: Бусадтай зэрэгцэн тоглох	Дууны утга санааг хөдөлгөөнөөр үзүүлдэг.
Балхүү зураг зурсан нь	Номын цаг	Балхүү зураг зурсан нь” зохиолыг номын зургийг харуулж, үйл явдлыг нүүрний хувирал, биеийн хөдөлгөөн, дуу хоолойгоороо тодотгон, урнаар ярина.	“Балхүү зураг зурсан нь” ном.	Балхүү хаана зурсан бэ?	Суралцахуйд суралцах: Зохиолын үйл явдлыг сонсож ойлгох. Нийгэм, сэтгэл хөдлөл: Дүрүүдийн сэтгэл хөдлөлийг ойлгох.	Зохиолыг анхааралтай сонсож байгаа эсэх
Том цаасан дээр зуръя	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Том дэлгэц цаасыг шалан дээр бэхлэн, хүүхдүүд усан будгаар дуртай зүйлээ зурж, дүрсэлнэ. Зурсан зүйл, өнгөө нэрлэнэ. Хэрэгслээ	Хормогч, ханцуйвч, будаг, бийр, ус, дэлгэц цаас, наалддаг тууз.	Зураг зурахдаа юун дээр зурах хэрэгтэй вэ?. Хана, шал, хувцас дээрээ зурж болох уу?.	Бүтээлчээр сэтгэх: Зурж урлах. Хамтран ажиллах: хамт бүтээх	Өнгийг нэрлэдэг.

		хурааж, гараа угаана.				
Болно, болохгүй	Хөгжөөн баясах цаг	Багш, багшийн туслах жүжигчилсэн тоглолтоор дамжуулан зурахтай холбоотой зөв, буруу үйлдлүүдийг үзүүлж ярилцах.	Баг, өмсгөл.	Сандал, ширээ, шалан дээр зурах нь зөв үү? буруу юу?.	Шүүн тунгаах: Болох, болохгүй үйлийг ялгах,	Болох болохгүй үгийг ойлгож мэддэг.
Миний царай	Тойргийн цаг	Зохиолын дүрүүд (Балхүү, ээж, ах) болон сэтгэл хөдлөлийн картуудыг ашиглан дүрүүдийн нүүрний хувирал, сэтгэл хөдлөлийг нэрлэх, дуурайх. Жижиг толь ашиглан өөрийн сэтгэл хөдлөлийг ажиглах.	Дүрүүдийн зураг, сэтгэл хөдлөлийн карт, жижиг толь.	Чи өглөө босоод уйлсан уу? Эсвэл инээсэн үү?. Хана, цаасан дээр зураг зурвал багш нь баярлах уу? гомдох уу?.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Өөрийн болон бусдын мэдрэмжийг анзаарах, үг, үйлдлээр илэрхийлэх. Харилцах: Асуултад хариулж ярилцах.	Нүүрний хувирал сэтгэл хөдлөлийг нэрлэдэг.
Том жижиг тоглоом будаарай	Чиглүүлэгтэй тоглоом	Том ба жижиг тоглоомуудыг харьцуулан ялгах. Хэвлэмэл зурагтай хуудсыг багшийн чиглүүлгийн дагуу (жишээ нь: Том бөмбөгийг шар өнгөөр, жижиг бөмбөгийг улаан өнгөөр усан будгаар будах.	Хормогч, ханцуйвч, усан будаг, бийр, ус, хэвлэмэл зурагтай цаас.	Энэ шар өнгө мөн үү? Аль нь том бөмбөг вэ?	Суралцахууд суралцах: Зааврыг ойлгож биелүүлэх.	Багшийн асуултад хариулдаг.
Шохойгоор зурцгаая	Зугаалгын цаг	Тэнгэр, цаг агаарыг ажиглан ярилцах. Бөмбөгөөр тоглож, хураах. Цэцэрлэгийн талбайд шохойгоор хүссэн зураг, дүрсээ (бөмбөг, дугуй дүрс) зурж тоглох.	Өнгийн шохой, нойтон алчуур, бөмбөг, сагс.	Тэнгэр ямар өнгөтэй байна вэ?.	Бүтээлчээр сэтгэх: Чөлөөтэй зурах. Хамтран ажиллах: Бөмбөгөөр тоглох, хураах.	Дугуй дүрс зурдаг.
Балхүүгийн аялал	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өнгийн саадыг сүлжиж, давж алхах/гүйх, хос хосоороо хөтлөлцөх. Өнгийн бөмбөгнүүдийг 3 өнгийн	Улаан, шар, цэнхэр өнгийн саад ба дарцаг, өнгийн бөмбөг, 3	Улаан сагс аль нь вэ? Энэ ямар өнгөтэй бөмбөг вэ?	Суралцахууд суралцах: Зааврыг ойлгож биелүүлэх. Хамтран ажиллах:	Саадыг сүлжиж алхаж гүйдэг. Бөмбөгийг

		сагсанд цуглуулж хураах. Багшийн гарын дуурайж хөдөлгөөнийг гүйцэтгэнэ. Хэвтээ байрлалд бүтэн эргэж өнхөрнө.	өнгийн сагс, жижиг алчуур, хөгжмийн аян ая, зөөлөн хивсэнцэр	Та нар харандаа болж өнхөрч чадсан уу?	Хосоороо хөтлөлцөх.	өнхрүүлдэг.
--	--	--	---	---	---------------------	-------------

Албан хэрэгцээнд

4 дүгээр сарын I долоо хоног

БАЛХҮҮ ТОГЛООМОО ХУРААСАН НЬ

Шинэ үг: Хуваалцах, булаацалдах

Үйл ажиллагаа 1. Зөв үү? буруу юу? (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Тоглоомууд, зурагт үзүүлэн

Аргачлал: Багш, багшийн туслах жүжигчилсэн тоглолтоор дамжуулан хийж болох ба болохгүй зүйлийг хүүхдүүдэд тайлбарлан үзүүлнэ.

- Тоглоомоо хуваалцах-Тоглоомоо булаацалдах
- Тоглоомоо хураах-Тоглоомыг гишгэх, шидэх

Болно, болохгүй үйлдлийг харуулсан зурагт үзүүлэн дээр харилцан ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Тоглоомоо шидэж, дээр нь гишгэх нь зөв үү? буруу юу?
- Тоглоомоо хураахгүй үлдээх нь зөв үү? буруу юу?
- Тоглоомоо найзтайгаа хуваалцаж, хамтдаа тоглох нь зөв үү? буруу юу?
- Тоглоомоо хоорондоо булаацалдаж уйлах нь зөв үү? буруу юу? гэж асууж ярилцана.

Үйл ажиллагаа 2. Балхүү тоглоомоо хураасан нь (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: “Балхүү тоглоомоо хураасан нь” ном

Аргачлал: “Балхүү тоглоомоо хураасан нь” зохиолыг багш номын зургийг харуулж урнаар ярина. Өгүүллэгийн дүр, үйл явдлыг нүүрний хувирал, биеийн хөдөлгөөн, дуу хоолойгоо тохируулан өөрчлөн тодотгоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи тоглож дуусаад тоглоомоо хураадаг уу?

Үйл ажиллагаа 3. Тоглоомоо хураагаарай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Төрөл бүрийн тоглоомууд, сагс, “Тоглоомоо хураагаарай” дууны ая

Аргачлал: Бөмбөг, леги, бусад тоглоомуудаас сонголт хийлгэж чөлөөтэй тоглуулна. Тоглож дуусах үед “Тоглоомоо хураагаарай” дуу явж эхлэхэд тоглоомоо хурааж сагсанд хийж, тавиур дээр тавихыг сануулна. Сагс эсвэл сав нь тухайн тоглоомын зурагтай байна. Хүүхдүүд хамтдаа тоглоомоо ангилж тус тусын сагс, саванд хийж хураана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ тоглоомыг аль сагсанд хийх вэ?

Үйл ажиллагаа 4. Тоглоомоо угаацгаая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Аргачлал: Том саванд бүлээн ус хийж бэлтгэнэ. Хүүхдүүд хормогч, ханцуйвчаа өмсөнө. Тоглоомоо савтай усанд хийж булхан угааж тоглоно. Угаасан тоглоомоо том алчуур дээр тавьж хатаана. Тоглоомоо угааж, цэвэрлэхийн ач холбогдлыг тайлбарлан, ярилцана. Хатсан тоглоомуудаа ангилж хураана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Тоглоом нь хатсан байна уу?

БИДНИЙ ТОГЛООМ

Шинэ үг: Мөр, ханцуйвч

Үйл ажиллагаа 1. Манай ангийн тоглоом (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Бүлгийн тоглоомуудын зурагт үзүүлэн

Аргачлал: Багш ангид байдаг тоглоомын зургийг авч хэвлэж бэлдсэн байна. Зургийг нэг нэгээр харуулж асууж ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ ямар тоглоом бэ?
- Ямар өнгөтэй байна вэ?
- Энэ тоглоом ангийн аль хэсэгт байдаг вэ?
- Хаана хураадаг вэ?

Үйл ажиллагаа 2. Машины мөр (Чиглүүлэгтэй тоглоом)

Хэрэглэгдэхүүн: Хормогч, ханцуйвч, жижиг машин, гуаш, ватум цаас

Аргачлал: Багш ширээн дээр цаас дэвссэн байна. Гуашнаас 3 өнгө сонгож цаасан дээр дусаана. Хүүхдүүд цаасан дээр машинаараа түрж мөр гаргаж тоглоно. Хүүхдүүд тоглож дуусаад тоглоомын машинаа болон гараа угаана. машинаа хатааж, тавиур дээр байранд нь тавина.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи аль өнгийг сонгож авсан бэ?
- Энэ ямар өнгө вэ?
- Угаасан машинаа хаана тавих вэ?

Үйл ажиллагаа 3. Ширээгээ угаая (Өөртөө үйлчлэх цаг)

Хэрэглэгдэхүүн: Хормогч, ханцуйвч, устай сав, алчуур

Аргачлал: Зурах будах үйл ажиллагааны дараа ширээнд наалдсан будгийг арчиж цэвэрлэнэ. Багш хүүхэд бүрд алчуур өгнө. Хүүхдүүд ширээн дээр байгаа савтай усанд алчуураа дүрж базаж мушгин, дэлгээд ширээгээ арчиж будаг, толбыг арилгаж цэвэрлэнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Будаг хаана наалдсан байна?
- Ширээ нь цэвэрхэн болсон уу?

БӨМБӨРӨӨР ТОГЛОЁ

Шинэ үг: Бөмбөр, тогш

Үйл ажиллагаа 1. Бүгдийг чадна би (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ая Санжаа, Үг Отгонбаяр “Бүгдийг чадна би” дууны ая, зурагт үзүүлэн

Аргачлал: Багш дууны утга санааг зурагт үзүүлэн харуулж, тайлбарлаж, ярилцана.

“Бүгдийг чадна би” дууны үгийг мөр мөрөөр хөдөлгөөнөөр дүрслэн үзүүлж, дуулна.

Хүүхдүүд багшийг дагаж хөдөлгөөнийг хийж, дуулахыг оролдоно.

- Багшийн чиглүүлэх асуулт:
- Энэ зураг дээр хүүхэд юу хийж байна вэ?

2. Бөмбөрчин

Хэрэглэгдэхүүн: Жижиг том бөмбөр, Ая Д.Болор-Эрдэнэ, Үг Ө.Ууганбаяр “Том жижиг” дууны ая

Аргачлал: Багш хүүхдүүдэд бөмбөр хөгжмийг танилцуулж алгаар зөөлөн тогшиж тоглож үзүүлнэ. Хүүхдүүд багшийг болон бусдыгаа дуурайж бөмбөрийг алгаар тогшиж дуугаргаж хөгжилдөнө. “Том жижиг” дууны аянд нийтээрээ бөмбөрийг алгаар тогшиж дуугаргаж хөгжилдөнө.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Та нар ямар хөгжмөөр тоглосон бэ?

4 дугаар сарын II долоо хоног

БАЛХҮҮ ЗУРАГ ЗУРСАН НЬ

Шинэ үг: Зураас, баг

Үйл ажиллагаа 1. Балхүү зураг зурсан нь (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: “Балхүү зураг зурсан нь” ном

Аргачлал: “Балхүү зураг зурсан нь” зохиолыг багш номын зургийг харуулж урнаар ярина. Өгүүллэгийн дүр, үйл явдлыг нүүрний хувирал, биеийн хөдөлгөөн, дуу хоолойгоо тохируулан өөрчлөн тодотгоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Балхүү хаана зураг зурсан бэ?

Үйл ажиллагаа 2. Том цаасан дээр зуръя (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хормогч, ханцуйвч, усан будаг, бийр, ус, дэлгэц цаас, наалддаг тууз

Аргачлал: Багш том дэлгэц цаасыг шалан дээр дэлгэж, хоёр талыг нь наалддаг туузаар бэхэлж тогтооно. Хүүхдийн тооноос хамаарч цаасаа бэлтгээрэй. Хүүхдүүд дэлгэц цаасан усан будгаар дуртай зүйлээ зурж, дүрсэлнэ. Юу зурж, дүрсэлснээ ярилцана. зурсан зургийн өнгийг нэрлэнэ. Зурж дуусаад хичээлийн хэрэгслээ хурааж, гараа угаана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Зураг зурахдаа юун дээр зурах хэрэгтэй вэ?
- Хана, шал, ор, хувцас, шүүгээ, тоглоом дээрээ зурж болох уу?

Үйл ажиллагаа 3. Болно, болохгүй (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Баг, өмсгөл

Аргачлал: Багш, багшийн туслах жүжигчилсэн тоглолтоор дамжуулан болох, болохгүй зүйлийг үзүүлж ярилцана.

- Ханан дээр зурах
- Цаасан дээр зурах
- Гар болон бие дээрээ зурах
- Дэвтэр дээр зурах
- Тоглоом дээр зурах
- Сандал, ширээ, шалан дээр зурах нь зөв үү? буруу юу? гэж асууж ярилцана.

ЗУРАГ ЗУРЦГААЯ

Шинэ үг: Будах зурах

Үйл ажиллагаа 1. Миний царай (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Зохиолын дүрүүд Балхүү, Балхүүгийн ээж ба ахын зураг, сэтгэл хөдлөлийн карт

Аргачлал: Зохиолын дүрүүдийн зургийг хараад, сэтгэл хөдлөлийг нь дуурайна. Хүүхдүүд дүрүүдээс зааж ямар нүүрний хувирал илэрхийлж байгааг нэрлэж, нүүрний хувирал, дуу авиагаар дуурайж илэрхийлнэ. Мөн жижиг толь тараан өгч сэтгэл хөдлөлүүдийг дуурайлган ажиглуулна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи өглөө босоод (ангидаа орж ирэхдээ) уйлсан уу? Эсвэл инээсэн үү?
- Найз чинь уйлсан уу, инээсэн үү?
- Ханан дээр зураг зурвал ээж нь, багш нь баярлах болов уу? гомдох болов уу?
- Харин цаасан дээр зураг зурвал баярлах болов уу? гомдох болов уу?

Үйл ажиллагаа 2. Том жижиг тоглоом будаарай. (Чиглүүлэгтэй тоглоом)

Хэрэглэгдэхүүн: Хормогч, ханцуйвч, усан будаг, бийр, ус, хэвлэмэл зурагтай цаас

Аргачлал: Том ба жижиг тоглоомыг харьцуулан, нэрлэнэ. Том жижиг бөмбөг, том жижиг машин гэх мэт тоглоомын зурагтай хуудсыг хүүхдүүд усан будаг, бийр ашиглан өнгө сонгож будна. “Том, жижиг бөмбөгийг шар өнгөөр будаарай” гэж чиглүүлэхэд хүүхдүүд будна. Будаг дуусаад хичээлийн хэрэгслээ хурааж, гараа угаана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ шар өнгө мөн үү?
- Аль нь том бөмбөг вэ?

Үйл ажиллагаа 3. Шохойгоор зурцгаая (Зугаалгын цаг)

Хэрэглэгдэхүүн: Өнгийн шохой, нойтон алчуур

Аргачлал: Зугаалгын үед тэнгэрийг ажиглан, ярилцана. Том жижиг бөмбөгийг хөөргөж, өнхрүүлж, шидэж, дамжуулан тоглоно. Тоглосон бөмбөгнүүдээ сагсанд хураана. Хүүхэд бүр нэг нэг шохой сонгож авч цэцэрлэгийн талбайд эрээчиж сараачиж, бөмбөг, дугуй дүрс болон хүссэн зургаа зурж тоглоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Тэнгэр ямар өнгөтэй байна вэ?
- Тэнгэрт үүл байна уу?
- Нар мандсан байна уу?

ТАМИРЧИН БАЛХҮҮ

Шинэ үг: Дохио, саад давах

Үйл ажиллагаа 1. Балхүүгийн аялал (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Улаан, шар, цэнхэр өнгийн саад ба дарцаг, өнгийн бөмбөг

Аргачлал: Өнгийн саадыг цувуулан тавина. Багш “би өнөөдөр Балхүү боллоо” гээд дарцгаа өргөнө. “Та нар Балхүүг дагаад алхаарай” гэхэд хос хосоороо хөтлөлцөж өнгийн саадыг сүлжиж алхана.

Өнгийн бөмбөгнүүдийг талбайн голд, 3 өнгийн сагсыг талбайн захад байрлуулна. Багшийн “Бөмбөгөө түүгээрэй” дохиогоор өнгийн сагсанд бөмбөгөө цуглуулна. Багшийн чиглүүлгээр хэрэглэгдэхүүнээ хураана.

2. Алчууртай дасгал.

Хэрэглэгдэхүүн: жижиг алчуур, хөгжмийн ая

Аргачлал: Хүүхдүүд 2 гартаа алчуур барьж багшийн хөдөлгөөнийг даган дуурайж гүйцэтгэнэ. Хөгжмийн хэмнэлд гарын янз бүрийн хөдөлгөөнийг багш зохиомжлон хийнэ.

3. Харандаа өнхрөлт

Хэрэглэгдэхүүн: зөөлөн хивсэнцэр, бөмбөг

Аргачлал: Хүүхдүүд газар хэвтээд гараа дээш өргөхөд багш та нар урт харандаа шиг болсон байна. Багш харандаан өнхрөлтийг биечлэн хийж үзүүлэн тайлбарлана. “Эргээрэй” дохиогоор хүүхдүүд баруун тал руу хэвтээ байрлалд бүтэн эргэнэ.

Тайвшруулах дасгал: Хэвтээ байрлалдаа амьсгалын дасгал хийх, гараа өргөөд хэвлий дээрээ тавих, гараа алдлаад хэвлий дээрээ тавина.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Улаан сагс аль нь вэ?
- Энэ ямар өнгөтэй бөмбөг вэ?
- Та нар харандаа болж өнхөрч чадсан уу?

Сонсьё, дэмжье/ Туслалцаа:

- Зурагт ном, тоглоом, эсвэл зурагт самбар ашиглан түлхүүр үйл явдал бүрийг зурагтай холбож үг хэллэгийг ойлгомжтой, богино өгүүлбэрээр үлгэрийг ярина.
- Асуулт тавих буюу үйл явдлыг дахин давтах, ойлгосон эсэхийг бататгаж харилцан ярилцана.

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Цэцэрлэгтээ өөрийн дуртай номоо авч очих, бусадтай хамтран үзэж ярилцах
- Гэрээ тоглосон тоглоомоо хувааж хэвшүүлэхэд үлгэрлэх
- Гэр бүлээрээ гадаа салхинд гарахдаа тоглоомын талбайд бусадтай хамтран тоглож байгааг ажиглах

<p>Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ/ Амжилттай хэрэгжүүлсэн: Сул хэрэгжүүлсэн:..... Цаашид сайжруулах:..... Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:</p>

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - V САР

ЦЭЦЭРЛЭГИЙН ДУРСАМЖ

Хүүхдийн эзэмших чадамж:

Суралцахуйд суралцах: Сонирхсон зүйлээ асууж анхааралтай сонсох, төвлөрөх;

Нийгэм сэтгэл хөдлөл: Өөрийн болон бусдын биеийн мэдрэмжийг анзаарах, үг, үйлдлээр илэрхийлэх;

Аюулгүй байдлын зөвлөмж:

Болно болохгүйг ойлгож, бусдын зааврыг биелүүлнэ. Хатуу хавтастай номын хуудсыг болгоомжтой эргүүлж үзэх, амандаа хийхгүй байх, ном үзээд байранд нь хураана.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Тухайн өдөр ямар үйл ажиллагаанд юу хийх тухай ярилцана.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Багшийн чиглүүлэгийг ойлгон зурж урлах оролдлого хийх, асуултад биеийн хөдөлгөөн, энгийн өгүүлбэрээр хариулах, дуу дуулах, өрж байгуулах тоглоом тоглох, биеийн хөдөлгөөнийг даган дуурайж байгааг урамшуулан дэмжинэ.

Зугаалга:

- Цэцэрлэгийн бага бүлгийн орчинд гарч танилцаж, ажиглалт хийх, өөрийн сонирхсон тоглоомоор тоглох, Сайн байна уу?, баяртай үгийг хэрэглэнэ. Цаг агаарын байдлыг ажиглан дулаан өдөр тоглоомын талбайд тоглоно.

Номын цаг:

- Дуртай номоо сонгон авч гэр бүлийнхэнтэйгээ ном уншиж ярилцана. Номыг ариг гамтай цэвэрхэн үзэхийг дэмжих, номын зургийг харж богино өгүүлбэрээр бусдад ярьж өгнө.

Хөгжөөн баясах цаг:

- Жүжигчилсэн тоглолтыг сонирхон үзэх, оролцох бие даасан үйлийг дэмжээрэй. Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, бусдын үйлийг ойлгож хүлээцтэй байхад тусална.

Боломжууд:

Хүүхдийн сэтгэл хөдлөлд хариу үйлдэл үзүүлэн тайвшруулах, асуулт асууж ярилцана. Хүүхдүүд тоглоомоо булаацалдах, хазах, цохих, маажих үед аль болох тэврэх, аргадах, хуваалцах номын зургийг ажиглуулан найзыгаа ойлгодог болоход тусална. Хүүхдийн ангидаа үзэх дуртай номыг зөөврийн номын сангаар гэр бүлд нь явуулж хүүхдэдээ ном уншиж өгөх боломжийг нь олгоно.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
БНО1.2а. Өөрийн нэр, нас, бие, эрхтнээ нэрлэж, тоглоом, эд зүйлсээ танина. МАТ1.3а. Тоглоом, юмсыг тодорхой нэг шинжээр ялгана. ХЯ1.2г. Хүсэл, хэрэгцээгээ тохирох үгс ашиглан илэрхийлнэ.	- Өөрийн нэр, нас, биеийн зарим эрхтнийг нэрлэх, үйлдлээр харуулах, тоглоом эд зүйлсээ ялгаж таних, Энэ юу вэ?, Аль вэ? гэж асуухад нүд, гар, хөлөө заах, хэлэх, толь ашиглан өөрийнхөө нүд, хамар, ам гэх мэт эрхтнээ зааж нэрлэж тоглох - Өөрийн таних тэмдгээ ялган таних, өөрийн эд зүйлээ бусдынхаас ялгаж хэрэглэх - Багшийн зааврын дагуу улаан өнгийн тоглоомыг хайрцаг, сагсанд ялган хийх;	Энэ бол би
БНО1.2а. Өөрийн нэр, нас, бие, эрхтнээ нэрлэж, тоглоом, эд зүйлсээ танина. ЗУ1.3б. Бэлдэц дүрсээр бусдын дэмжлэгтэй нааж бүтээл урлана. ХӨГ1.1а. Хүн, амьтны дуу авиаг ялган таньдаг болно.	- Өөрийн таних тэмдгээ ялган таних, өөрийн эд зүйлээ бусдынхаас ялгаж хэрэглэх - Бэлэн дүрсийг бусдын дэмжлэгтэй цавуудаж наах; - Наамлаар урлаж дуусаад багаж, хэрэгслийг байранд нь хураах; - “Дуурайж дуугараарай” тоглоом тоглох	Миний найзууд
ХЯ1.1б. Ярианд хэлсэн үгийг сонсож, давтан хэлнэ. ХЯ1.2б. Ярилцах явцдаа асуулт	- Үгийг удаан, тод, ойлгомжтой хэлэх, танил үгсийг сонсоод дуурайх, давтан хэлэх, зургийг	Миний цэцэрлэг

<p>асуух оролдлого хийнэ. БНО1.2в. Гэрт болон ангидаа эд зүйлсийн байрлалыг мэдэж, багшийн өгсөн энгийн зааврыг биелүүлнэ.</p>	<p>заах, зөв дуудлагаар хэлэх, тогтоох зэрэг үйл хийх; - Ном үзэх, бусадтай тоглох явцдаа бодит зүйл болон зургийг сонирхон өөрийн хэрэглэдэг эд зүйлийн нэрийг лавлан асуух. - Анги, гэрийн орчинд байдаг эд зүйлсийг таньж, байрлалыг мэдэж хэлэх</p>	
<p>БНО1.1б. Өдөр тутам хэрэглэдэг жимс, хүнсний ногоог таньж нэрлэнэ. ХЭМ1.2в. Хоол хүнсний бүтээгдэхүүнийг угааж, чанаж болгож иддэгийг мэднэ, ялгана. ХЭМ1.2г. Хоолны хэрэгслийг нэрлэж, зориулалтын дагуу хэрэглэнэ.</p>	<p>- Зурган картаас ижил жимс, ногоог хослуулан тавих, өнгөөр нь ялгах; - Бодит үзүүлэн болон зурагт карт ашиглан идэж болох, болохгүй жимс, хүнсний ногоог ялгах - Хоолны хэрэгсэл тавих суурь зургийн дагуу аяга, таваг, халбагыг байрлуулах сургах тоглоом тоглох;</p>	<p>Миний дуртай хоол</p>
<p>ХЭМ1.2ж. Цаг агаарын үзэгдлийг таньж нэрлэн, насанд хүрэгчдийн сануулгыг дуурайн дагана. БНО1.1г. Байгалийн үзэгдлийг зааж нэрлэнэ. ЗУ1.3б. Бэлдэц дүрсээр бусдын дэмжлэгтэй нааж бүтээл урлана.</p>	<p>- Бороо, салхи, нар, цас гэх мэт цаг агаарын үзэгдлийг ялгаж, нэрлэх; - “Бороо орлоо, Салхи салхиллаа, Нар гарлаа” гэх мэт хөдөлгөөнт тоглоом тоглох; - Байгалийн үзэгдэлтэй холбоотой хувцас сонгох, тохируулан үйлдэл хийх - Өнгийн цаасыг базах, урах;</p>	<p>Бороо</p>
<p>ХЭМ1.1и. Хоёр хөл дээр байрандаа үсэрч бууна. ХЭМ1.1о. Бөмбөгийг 1.5 м зайд өшиглөж өнхрүүлж, дамжуулна. ХЭМ1.1л. Шатны бариулаас барьж 10 гишгүүрт өгсөж, уруудна. ХЭМ1.2е. Хүрээлэн байгаа орчны болгоомжлох зүйлсийг мэднэ, ялгана.</p>	<p>- Амьтдын хөдөлгөөнийг дуурайж үсрэх; - Хаалга руу бөмбөг өшиглөж өнхрүүлж тоглоход нь дэмжиж урамшуулах. - Шатны бариулаас бариад, бусдын тусламжтайгаар 10 гишгүүрт өгсөж, уруудах; - Зурагт үзүүлэнгээс болгоомжлох зүйлсийг заах;</p>	<p>Хөдөлгөөнт тоглоом</p>

5 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Миний бие эрхтэн	Тойргийн цаг	Багшийн асуултыг сонсож, өөрийн бие эрхтнээ зааж нэрлэнэ.	Хүүхэлдэй эсвэл биеийн зураг, ая аялгуу	“Энэ хүүхэлдэйд юу байна вэ? Энэ юу вэ?” Нүдээ олж алгаараа зөөлөн даръя Хамраа олж хуруугаараа зөөлөн хүрье Гарын алгаа ташъя, ташъя Хөлөөрөө бөмбөг өнхрүүлье	Харилцах, Заах нэрлэх Суралцахууд суралцах	Биеийн хэсгийг нэрлэх буюу зааж чаддаг. Хөдөлгөөн дагаж хийдэг. Багшийн зааврыг ойлгож оролцдог.
Миний оймс	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өөрийн оймсыг олж ижилсүүлэн хосыг нэрлэнэ (өнгө, хээгээр).	Өнгө, хээ нь өөр өөр оймснууд (Даавуун эсвэл цаасан).	Ижилсүүлэх, нэрлэх үйлийн явцад дэмжлэг үзүүлнэ	Шүүн тунгаах, ижилсүүлэх ялгах Харилцах	
Хувцсыг өнгөөр ялгаарай	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хувцсыг нэрлэж, өнгөөр нь ялгаж, ангилна (Улаан, шар, хөх сагсанд).	Өнгө өнгийн цамц, оймс, малгай, өмд (эсвэл цаасаар хайчилж бэлтгэсэн), Улаан, шар, хөх сагс/хайрцаг.	“Улаан цамцыг улаан сагсанд хийе!” гэх мэт.	Шүүн тунгаах, Хамтран ажиллах	Эд юмсын өнгийг ялгана.
Миний тоглоом	Хөгжөөн баясах цаг	Өөрийн хайртай тоглоомыг танилцуулж, хэрхэн тоглодог тухай бусдад ярьж тайлбарлана.	Хүүхдүүд гэрээсээ авчирсан 1-2 тоглоом.	(Багш өөрөө үлгэрлэн тайлбарлах).	Харилцах, Нийгэм, сэтгэл хөдлөл	
Миний найзын сандал	Тойргийн цаг	Найзуудынхаа таних тэмдэг бүхий сандлыг ялган таньж, нэрлэнэ.	Бүлгийн хүүхдүүдийн таних тэмдэгтэй сандал.	“Энэ хэний сандал вэ?”	Шүүн тунгаах, Харилцах	
Миний найз (Зурах)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл	Хос хосоороо найзынхаа нүүр царайг ажиглаж, бэлдэц	Толгойн хэлбэртэй хэвлэмэл хуудас, нүд,	(Урд байгаа найзынхаа царайг ажиглуулах)	Бүтээлчээр сэтгэх, Хамтран ажиллах,	

	ажиллагаа	цаасан дээр нүд, ам, хамар, чихийг наан, үс болон бусдыг зурж чимэглэнэ.	хамар, ам, чихний дүрс, цавуу, өнгийн харандаа.		Нийгэм, сэтгэл хөдлөл	
Найзаа ольё	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Ижил амьтны зурагтай найзаа олж, тухайн амьтдын дуу авиа, хөдөлгөөнийг дуурайж тоглоно. Мөн зургийн ард талд буй сэтгэл хөдлөлийг дуурайж тоглоно.	Амьтдын хос зураг (ард талд нь сэтгэл хөдлөлийн зурагтай).	Зургийг сайтар ажиглахыг хүсэх	Хамтран ажиллах, Нийгэм, сэтгэл хөдлөл, Шүүн тунгаах	Амьтдын дуу авиаг таньдаг.
“Цэцэрлэгт юу болдог вэ?”	Номын цаг	Зурагт номыг сонсож, утгыг ойлгох, цэцэрлэгт болдог зүйлсийн талаар ярилцах.	Б.Энхжаргал “Цэцэрлэгт юу болдог вэ?” ном.	Бид цэцэрлэгтээ ирээд юу юу хийдэг вэ? Ямар хоолонд дуртай вэ? Багш нартаа, найзууддаа хайртай юу?.	Харилцах, Нийгэм, сэтгэл хөдлөл	Асуултад хариулдаг.
Миний цэцэрлэг	Зугаалга	Цэцэрлэгийн гадна орчин, барилга байгууламжийг ажиглах, “Өнгийн цагариг” тоглоомоор өнгө ижилсүүлэн тоглох.	Өнгийн цагариг, улаан, шар, хөх өнгийн бугуйвч/тууз.	Манай цэцэрлэгийн барилга ямар өнгөтэй вэ? Цэцэрлэг хэдэн давхар вэ? Гадаа ямар тоглоом байна вэ?.	Шүүн тунгаах Өнгө ижилсүүлэх Суралцахуйд суралцах Зааврыг сонсох	
Хүнсний ногоог ижилсүүлье	Тойргийн цаг	Хүнсний ногоог нэрлэн, бодит зүйл болон зурагт картыг ижилсүүлэх, хоолонд хэрхэн хэрэглэдэг талаар ярилцах.	Хүнсний ногооны бодит үзүүлэн ба зурагт үзүүлэн, сагс.	Сонгино хаана байна вэ?, Лууванг хоолонд хийдэг үү? Төмсийг шууд иддэг үү?.	Шүүн тунгаах, Харилцах	Жимс, хүнсний ногоог таньж заадаг.
Жимсний мод	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Жимс, жимсгэнүүдийг нэрлэх, сүүдрийг олж модон дээр нааж ижилсүүлэх.	Том жимсний модон дээр жимсний сүүдэр наасан байдал, төрөл бүрийн жимсний бодит үзүүлэн/тоглоомууд.	Энэ юу вэ? Энэ алим мөн үү?.	Шүүн тунгаах, Харилцах	Жимс, хүнсний ногоог таньж заадаг.
Хоолны ширээ засацгаая	Өөртөө үйлчлэх цаг	Хоолны хэрэгслийг нэрлэж, зурагтай дэвсгэрийн дагуу зөв байрлуулах, хооллож	Хоолны хэрэгслийн зураг бүхий дэвсгэр, аяга, халбага, цайны	(Хоолны хэрэгслийг нэг бүрчлэн танилцуулах).	Суралцахуйд суралцах, Хамтран ажиллах	Хоолны хэрэгслийг ялгаж, зориулалтын дагуу хэрэглэдэг.

		дуусаад хураана.	аяга.			
Бороотой өдөр надад юу хэрэгтэй вэ?	Тойргийн цаг	Цаг агаарын үзэгдэл (бороо, салхи, нар)-тай танилцах, бороотой өдөр гадаа гарахад хэрэгтэй зүйлсийг сонгон нэрлэж, аюулгүй байдлын талаар ярилцана.	Бороо, салхины зурагт үзүүлэн, шүхэр, усны гутал, цув, нарны малгай, савтай ус, харандаа, аяга, халбага.	(Бороо, салхи, наранд юу тохиолдож болохыг тайлбарлах).	Шүүн тунгаах, сонгох, ялгах	Цаг агаарын үзэгдлийг ялгаж, нэрлэдэг.
“Бороо орлоо” хөдөлгөөнт тоглоом	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Цаг агаарын нөхцөлийг хэлэхэд тохирох хөдөлгөөнийг дуурайж хийнэ. (Салхилах, тэнгэр дуугарах, бороо шиврэх/ширүүсэх, нар гарах, солонго татах).	Цаг агаарыг холбох зурагт хуудас, харандаа/эсгий бал.	(Хөдөлгөөнийг үгээр илэрхийлэх).	Суралцахууд суралцах, ярих асуулт асуух	Хөгжмийн ая, хэмнэлд тохируулан хөдөлгөөнийг дуурайдаг.
Солонгон бороо	Хөгжөөн баясах цаг	Өнгийн цаас урж гарын жижиг булчинг хөгжүүлэх, урсан цаасаа шүхэр дотор хийж, хөгжмийн аянд "өнгийн бороо" оруулан тоглоно.	Шүхэр 2 ширхэг, өнгийн цааснууд.	Цаасыг түүж, шүхэр дотор хийхэд дэмжлэг үзүүлэх	Бүтээлчээр сэтгэх, хөдөлгөөнийг хийх Нийгэм, сэтгэл хөдлөл	Хөгжмийн аянд тохируулан хөдөлгөөн хийдэг.
Үсэрцгээе	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Үсэрдэг амьтдыг дуурайж үсрэх, саадан дээгүүр, зураас давж үсрэх дасгал хийнэ.	Саад (5 см өндөр), зураас хийх наалддаг цаас.	Ямар амьтад үсэрдэг вэ?.	Суралцахууд суралцах, Хамтран ажиллах	Гүйж, үсэрч чаддаг.
Алчуур хаях	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Тойргоор сууж, алчуур хаях уламжлалт тоглоомыг дүрмийн дагуу тоглоно.	Жижиг алчуур, хөгжилтэй хэмнэлтэй ая.	(Дүрмийг сануулах, ээлжлэх)	Хамтран ажиллах, Нийгэм, сэтгэл хөдлөл	Тоглоомыг дүрмийг дагадаг.
Бай оноё	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Нуман хаалга руу 1.5 м зайнаас бөмбөг өшиглөн тоглоно.	Нуман хаалга, бөмбөг.	(Бөмбөг өшиглөх зайг заах)	Хамтран ажиллах	
Шатаар алхья	Өөртөө үйлчлэх хөдөлмөр	Шатаар өгсөж, уруудах дүрмийг танилцуулж, аюулгүй байдлыг анхааран дадал болгох.	Шат, аюулгүйн санамж зураг.	(Аюулгүй байдлын дүрмийг биечлэн үзүүлэх).	Суралцахууд суралцах	Хөлөө ээлжлэн тавьж шатаар өгсөх, урууддаг.

5 дугаар сарын I долоо хоног

ЭНЭ БОЛ БИ

Шинэ үг: Хувцас, тоглоом

Үйл ажиллагаа 1. Миний бие эрхтэн (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Хүүхэлдэй эсвэл биеийн зураг, ая аялгуу

Аргачлал: Хүүхдүүдтэй хамт “Сайн байна уу?” богино дуугаар мэндчилнэ.

Багш: “Бид өнөөдөр биеийнхээ хэсгүүдийг нэрлэж тоглоно.” гэж хэлээд хүүхэлдэй эсвэл биеийн зураг гаргаж үзүүлнэ.

- “Энэ хүүхэлдэйд юу байна вэ? Энэ юу вэ?” гэж нүүрийг нь зааж харуулна.
- Хүүхдээр нүд, хамар, ам, чих, гар, хөл гэх энгийн хэсгүүдийг хэлүүлнэ, заалгана. Хөгжилтэй хөдөлгөөнт тоглоом тоглоцгооё
- Бүгд хамт нүдээ олж алгаараа зөөлөн даръя
- Одоо хамраа олж хуруугаараа зөөлөн хүрье
- Гарын алгаа ташъя, ташъя
- Хөлөөрөө бөмбөг өнхрүүлэе гэх мэтээр хүүхэд өөрийн биед хүрч мэдэрч, нэрлэж тоглоно.

Үйл ажиллагаа 2. Би хаана байна вэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хүүхдийн биеийн зурагт хуудас, биеийн хэсгийн стикер (нүд, хамар, ам, гар, хөл)

Аргачлал: Хүүхдийн биеийн зурагт хуудас байрлуулсан байна. Ажиглуулна. Юу дутуу байна вэ? Нүдийг нь олж хүүхдийн зурагт нааж өгөөрэй. Одоо хамрыг нь олъё гэх мэтээр заавар өгч ам, гар хөлийг наана. Богино хэллэг дагуулан хэлэх дасгал хийнэ.

Нүдээрээ би хардаг

Хамраараа би үнэрлэдэг

Гараараа би тоглодог

Хөлөөрөө би гүйдэг. Хүүхдүүд үгийг дагаж хэлэхдээ үйлдэл хийн дуурайна.

Үйл ажиллагаа 3. Би юу мэдэрч байна вэ? (Зугаалгын цаг)

Хэрэглэгдэхүүн: Цэцэрлэгийн гадна талбай, ногоон бүс, жижиг сагс,

Аргачлал:

1. Би юу мэдэрч байна вэ? ажиглалт: Гадаа бүлгийн талбайд ажиглалт хийнэ. Багш гараараа салхи мэдэрье гээд гараа өргөж салхи мэдэрнэ. Хүүхдүүд дуурайж хийнэ. Хөлөөрөө газар гишгэж мэдэрье, хамраараа агаарыг үнэрлэцгээе. Хүүхэд мэдэрсэн зүйлээ 1-2 үгээр хэлэх:

- Дулаахан, сэрүүн
- Хатуу, зөөлөн
- Гоё, муухай гэж хэлнэ.
- Багш: Нүдээрээ юуг харж байна вэ? Хүүхэд: мод, навч, газар
- Багш: Чихээрээ юуг сонсож байна вэ? Хүүхэд: Шувуу, салхи
- Багш: Гараараа юуг мэдэрч байна вэ? Хүүхэд: өвс, элс, чулуунд гар хүргэнэ.

2. Чулууг түүж цэвэрлэцгээе Багш: Ангийн талбайд байгаа чулууг түүж энэ сагсанд хийцгээе гэж хэлнэ. Хүүхэд чулууг цуглуулж жижиг сагсанд хийж модны ёроолд бөөгнүүлнэ.

3. “Нэг үү? Хоёр уу?” Хөдөлгөөнт тоглоом

Багш:

- Гүйж очоод чулуунаас нэг ширхгийг авчирч надад өгөөрэй.
- Алхаж очоод хоёр жижиг чулуу олж авчирч өгөөрэй.
- Модны дэргэд очоод хоёр гараараа хүрээрэй

“Бие эрхтнээ нэрлээ” хөдөлгөөнт дууг насанд тохируулан удаан, зөөлөн, хялбар хөдөлгөөнтэй дагуулна.

- Толгой- гараараа бага зэрэг хүрнэ
- Мөр- зөөлөн товшино
- Өвдөг- бөхийж хүрнэ
- Хөл- газар руу хөл чигт заана.

МИНИЙ НАЙЗУУД

Шинэ үг: Найз, чимэглэх

Үйл ажиллагаа 1. Миний найзын сандал (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Бүлгийн хүүхдүүдийн таних тэмдэгтэй сандал

Аргачлал: Хүүхдүүдийн сандлыг тойруулан тавина. Багш сандлын таних тэмдгийг харуулан “Энэ хэний сандал вэ?” гэж асуухад хүүхдүүд сандлын таних тэмдгийг хараад хэний сандал болохыг хэлнэ.

Үйл ажиллагаа 2. Миний найз (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Толгойн хэлбэртэй хэвлэмэл хуудас, нүд, хамар, ам, чихний хайчилж бэлтгэсэн дүрс, цавуу, өнгийн харандаа

Аргачлал: Хүүхдүүд хос хосоороо өдөөсөө харан сууна. Урдаасаа хараад сууж байгаа найзынхаа нүүр царайг ажиглана. Бэлдэц цаасан дээрээ нүд, ам, хамар, чихийг байрлуулан наана. Өнгийн харандаа ашиглан үс болон бусад зүйлсийг зурж, чимэглэнэ. Багшийн чиглүүлгээр хэрэгслээ хурааж байранд нь тавина.

Үйл ажиллагаа 3. Найзаа ольё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Амьтдын зураг хос хосоороо байх ард талд нь сэтгэл хөдлөлийн зураг

Аргачлал: Хүүхдүүдийн сандал доор хос зургуудыг нуусан байна. Зураг бүр нь хоёр ижил байхаар тооцоолж өөр өөр зураг байна. Багш хүүхдүүдийг сандал дороо юу байгааг харахыг хүснэ. Хүүхдүүд зургуудаа аваад хүзүүндээ зүүнэ. Өөр өөрийн зургаа сайтар ажиглахыг хүсээд ижил зураг авсан найзыгаа олж хамт зогсохыг хүснэ. Хүүхдүүд өөрийн зурагтай ижил зураг авсан найзаа олж хөтлөлцөн зогсоно. Хүүхдүүд тойрог болж газарт суугаад өөрийн авсан зурагт байгаа амьтадын хөдөлгөөнийг дуурайж дуугарна. Зургийн ард талд сэтгэл хөдлөлийн нүүрний хувирлын зураг байх ба мөн дуурайн тоглоно.

МИНИЙ ЦЭЦЭРЛЭГ

Шинэ үг: Цэцэрлэгийн барилга, бугуйвч

Үйл ажиллагаа 1. “Цэцэрлэгт юу болдог вэ?” ном (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Б.Энхжаргал “Цэцэрлэгт юу болдог вэ?” ном

Аргачлал: “Цэцэрлэгт юу болдог вэ?” номын зургийг харуулж урнаар ярина. Өгүүллэгийн дүр, үйл явдлыг нүүрний хувирал, биеийн хөдөлгөөн, дуу хоолойгоо тохируулан өөрчлөн тодотгоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Бид цэцэрлэгтээ ирээд юу юу хийдэг вэ?
- Ямар хоолонд дуртай вэ? Гэртээ ямар хоол иддэг вэ?
- Багш нартаа, найзууддаа хайртай юу?
- Цэцэрлэгтээ ямар тоглоомоор тоглох дуртай вэ? гэх мэт ярилцаад ангийн булан, төвүүд болон тоглоом наадгайгаа нэрлэн, ярилцана.

Үйл ажиллагаа 2. Миний цэцэрлэг (Зугаалга)

Хэрэглэгдэхүүн: Өнгийн цагариг, бугуйвч

Аргачлал: Хүүхдүүд цэцэрлэгийн барилгыг болон гадна орчныг ажиглан, алхана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Манай цэцэрлэгийн барилга ямар өнгөтэй байна вэ?
- Хашаа нь ямар өнгөтэй байна вэ?
- Цэцэрлэг хэдэн давхар вэ?
- Цэцэрлэгийн гадаа ямар ямар тоглоом байна вэ?
- Чиний тоглох дуртай тоглоом аль нь вэ? гэх мэт ярилцана.

“Өнгийн цагариг” хөдөлгөөнт тоглоом: Хүүхдүүдийн гарын бугуйнд улаан, шар, хөх өнгийн тууз зүүнэ. Цэцэрлэгийн талбайд өнгийн цагариг тараан байрлуулсан байна. Багшийн зааврыг сонсоод өөрийн бугуйвчтай ижил өнгийн цагаригт орж зогсоно. Багш

өнгөө олж зогсох, бугуйнд зүүсэн өнгийг танихад дэмжлэг үзүүлнэ. Тоглож дуусаад хүүхдүүд цагаригаа хурааж, зөөнө.

5 дугаар сарын II долоо хоног

МИНИЙ ДУРТАЙ ХООЛ

Шинэ үг: Хүнсний ногоо, жимс

Үйл ажиллагаа 1. Хүнсний ногоог ижилсүүлье. (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Хүнсний ногооны бодит үзүүлэн ба зурагт үзүүлэн, сагс

Аргачлал: Багш хүнсний ногоо бүрийг нэрлэж ширээн дээр тавьсны дараа зурагт үзүүлэнгээс луувангийн зургийг олоод, хүүхдүүдэд харуулна. Энэ бол лууван ижилхэн байна уу? гэж асууна. Багш хүүхэд хамтдаа хүнсний ногоо болон зурагт картыг нэрлээд ижилсүүлнэ. Хүүхдүүд сагснаас хүнсний ногооны бодит үзүүлэнг сонгон авч зурагт картыг сайтар ажиглан, ижлийг олж давхарлан тавина.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Сонгино хаана байна вэ?, Байцаа хаана байна вэ?
- Лууван хаана байна вэ? Лууванг хоолонд хийдэг үү? хийдэггүй юу?
- Төмс хаана байна вэ? Төмсийг хоолонд хийдэг үү? шууд иддэг үү? гэх мэтээр асууж ярилцана.

Үйл ажиллагаа 2. Жимсний мод (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Том жимсний модон дээр жимсний сүүдэр наасан байна. Төрөл бүрийн жимсний бодит үзүүлэн тоглоомууд, наалддаг тууз

Аргачлал: Багш цаасан хайрцаг ашиглан жимсний мод хийсэн байна. Нэг жимс сонгон: Энэ юу вэ? гэж асууна. Хүүхдүүд зааж, эсвэл нэрлэнэ. Хэрэв хүүхдүүд нэрийг нь хэлэхгүй бол багш жимсний нэрийг давтан нэрлэнэ. “Энэ бол алим.” гэх мэт...

Нэрлэсэн жимсээ ижлийг нь олж модонд наана. Наахдаа дүрс бүр дээр жимсээ барин харьцуулж “Энэ алим мөн үү?” гэж асууна. Зөв дүрсэн дээр очиж “Мөн байна” гэж хэлээд нааж тогтооно. Үлдсэн жимснүүдийг хүүхдүүд нэрлээд, жимсний модон дээрх дүрстэй ижилсүүлэн наана. Нэрийг нь хэлж чадахгүй бол багш давтан хэлж, ижлийг олоход нь дэмжлэг үзүүлнэ.

Үйл ажиллагаа 3: Хоолны ширээ засъя (Өөртөө үйлчлэх цаг)

Хэрэглэгдэхүүн: Хоолны хэрэгслийн зураг бүхий дэвсгэр, хоолны аяга, халбага, цайны аяга

Аргачлал: Багш тавиур дээр хоолны дэвсгэр, цайны аяга, хоолны аяга, халбага, бэлтгэсэн байна. Хоолны хэрэгслийг нэг бүрчлэн танилцуулан, нэрлэнэ. Ширээн дээр хоолны зураг бүхий дэвсгэр тавина. Зургийн дагуу хоолны хэрэгслийг нэг бүрчлэн нэрлэж, зурагт тохируулан тавина. Хүүхдүүд нэг нэг дэвсгэр аваад ширээн дээр тавина. Хоолны аяга, цайны аяга, халбагыг дэвсгэр дээр зургийн дагуу байрлуулна. Хүүхдүүд ширээндээ сууж, сайхан хооллохыг ерөөнө. Хооллож дуусаад аяга, таваг, халбагаа хураана. Хураах үед нь аяга, халбагаа зөв бариад, болгоомжтой явж хураахыг сануулж, дэмжлэг үзүүлнэ.

БОРОО

Шинэ үг: Нар, бороо, шүхэр

Үйл ажиллагаа 1. Бороотой өдөр надад юу хэрэгтэй вэ? (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Бороо, салхины зурагт үзүүлэн, шүхэр, усны гутал, цув, нүдний шил, савтай ус, нарны малгай, харандаа, аяга, халбага

Аргачлал: Зурагт самбар ашиглан бороо, салхи, хурц нарны зурагт үзүүлэн үзүүлж танилцуулна. Бороо, салхи, хурц наранд гарахад юу тохиолдож болохыг тайлбарлан ярилцана.

- Бороо орж, цахилгаан цахиж байвал гэрээсээ гарахгүй, хаалга цонхоо түгжих хэрэгтэй.

- Хүчтэй салхитай байвал яах вэ? Энэ үед гэрээсээ гарахгүй, хаалга, цонхоо түгжинэ.

Ширээн дээр шүхэр, усны гутал, цув, нүдний шил, савтай ус, нарны малгай, харандаа, аяга, халбага зэрэг эд зүйлсийг сайтар тайлбарлана. Хүүхдүүд эд зүйлсээс бороотой өдөр гадаа гарахад зүйлшгүй хэрэгтэй зүйлсийг сонгоно.

Үйл ажиллагаа 2. “Бороо орлоо” хөдөлгөөнт тоглоом (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Нар, бороо, үүл, салхи% солонго бүхий ижлийг олж холбох зурагт хуудас, харандаа эсвэл эсгий бал

Аргачлал: Багш цаг агаарын нөхцөлийг хэлж, тохирох хөдөлгөөн хийнэ. Хүүхдүүд багшийг дуурайн тохирсон хөдөлгөөн хийж тоглоно. Хөдөлгөөнт тоглоомыг баяр баясгалантай, хөгжилтэй хийж 4-5 удаа давтана.

- Салхи салхилаа гэхэд үүү-үүү гэж уруулаа цорвойлгон үлээнэ.
- Тэнгэр дуугарлаа гэхэд 2 хөлөө дороо дэвсэнэ.
- Бороо зөөлөн шивэрлээ гэхэд 2 гараараа өвдгөө зөөлөн цохино.
- Бороо ширүүслээ гэхэд 2 гараараа өвдгөө хурдан цохино.
- Нар гарлаа гэхэд 2 гараа өргөж толгой дээрээ дугуйлна.
- Солонго татлаа гэхэд 2 гараа тойрог болгон буулгаж газарт явган сууна.

Дасгал ажил хийнэ. Багш дасгал ажлыг самбарт наагаад хэрхэн холбож ажиллахыг нь үзүүлнэ. Ижил зургийг олж харандаа эсвэл эсгий балаар зурж холбоорой.

Үйл ажиллагаа 3. Солонгон бороо (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Шүхэр 2 ширхэг, өнгийн цааснууд

Аргачлал: Хүүхэд бүр өнгийн цаас сонгоод жижиглэн урна. Багш, багшийн туслах нэг нэг шүхэр дэлгэн дээш харуулан газарт тавина. Хүүхдүүд жижиглэн урсан цаасаа шүхэр дотор хийнэ. Хөгжмийн аянд багш шүхрийг өргөн доош харуулахад өнгийн бороо орно. Хүүхдүүд дахин цаасыг түүж шүхэр дотор хийж, багш шүхрийг өргөн бороо өнгийн цаасаар бороо оруулан хөгжилтэй тоглоно.

ХӨДӨЛГӨӨНТ ТОГЛООМ

Шинэ үг: тойргоор зогсох, шат

Үйл ажиллагаа 1. Үсэрцгээе (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: саад, зураас хийх наалддаг цаас

Аргачлал: Ямар амьтад үсэрдэг вэ? нэрлээрэй. Хүүхдийн нэрлэж хэлсэн амьтдыг дуурайж 2 хөлөө нийлүүлж, догонцож үсэрч тоглоно.

- 5 см өндөртэй саадан дээгүүр давж үсэрнэ
- 3-5 зураас давж үсэрнэ

Хүүхдүүдийг тойргийн дагуу зөөлөн алхуулах, амьсгалын дасгал хийнэ.

Үйл ажиллагаа 2. Алчуур хаях (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: жижиг алчуур, хөгжилтэй хэмнэлтэй ая

Аргачлал: Хүүхдүүд тойргоор сууна. Нэг хүүхэд алчуур авч тойргийн гадуур алхана. Хэн нэгэн хүүхдийн ард алчуураа орхино. Алчуур авсан хүүхэд нөгөө хүүхдийг хөөж алчуураа шидэж ононо. Онохгүй бол тойргийн гадуур алхаж алчуураа хэн нэгэн хүүхдийн ард орхиж үргэлжлүүлэн тоглоно.

Үйл ажиллагаа 3. Бай оноё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: нуман хаалга, бөмбөг

Аргачлал: Хүүхдүүд тойргоор зогсон бөмбөг өшиглөнө.

- Нуман хаалга руу 1,5 м зайнаас бөмбөг өшиглөнө.

Багш хүүхэд бүрийн оролцоог дэмжиж ээлжлэн тоглуулна.

Үйл ажиллагаа 4. Шатаар алхъя (Өөртөө үйлчлэх хөдөлмөр)

Хэрэглэгдэхүүн: Шат, аюулгүйн санамж зураг

Аргачлал: Багш хүүхдүүдийг дагуулан цэцэрлэгийн шатны доор зогсоно. Багш шатаар өгсөж, уруудах дүрмийн картуудыг бэлтгэж, шатаар аюулгүй өгсөж, уруудах, шатаар хэрхэн болгоомжтой явах аргыг биечлэн хийж үзүүлнэ. Хүүхдүүдийг ээлжээр бие даан шатаар өгсөж, уруудна. Хүүхдүүдийг шатаар өгсөж, уруудаж буйг ажиглаж,

Сонсъё, дэмжье/ Туслалцаа:

- Зурагт ном, тоглоом, эсвэл зурагт самбар ашиглан түлхүүр үйл явдал бүрийг зурагтай холбож үг хэллэгийг ойлгомжтой, богино өгүүлбэрээр үлгэрийг ярина.
- Асуулт тавих буюу үйл явдлыг дахин давтах, ойлгосон эсэхийг бататгаж харилцан ярилцана.

Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг оролцоо:

Цэцэрлэгтээ өөрийн дуртай номоо авч очих, бусадтай хамтран үзэж ярилцах
Гэрээр тоглосон тоглоомоо хувааж хэвшүүлэхэд үлгэрлэх
Гэр бүлээрээ гадаа салхинд гарахдаа тоглоомын талбайд бусадтай хамтран тоглож байгааг ажиглах

<p>Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./</p> <p>Амжилттай хэрэгжүүлсэн:</p> <p>.....</p> <p>Сул хэрэгжүүлсэн:.....</p> <p>.....</p> <p>Цаашид сайжруулах:.....</p> <p>.....</p> <p>Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:</p> <p>.....</p> <p>.....</p>
